

**ИРГЭНИЙ НИСЭХИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН
2021 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН**

Улаанбаатар хот

2021 оны 12 дугаар сарын 24-ний өдөр

Тус байгууллага нь Засгийн газрын үйл ажиллагааны 2020-2024 оны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө, Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2021 онд хөгжүүлэх үндсэн чиглэл, Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааг чиглэл болгон ажиллалаа.

**НЭГ. САЛБАРЫН ХӨГЖЛИЙН БОДЛОГЫН САНАЛ БОЛОВСРУУЛАХ, ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН
ОРЧИНГ БОЛОВСРОНГУЙ БОЛГОХ ЧИГЛЭЛЭЭР:**

Чикагогийн конвенцийн Хавсралтуудад 2010 оноос хойш оруулсан нэмэлт, өөрчлөлтийг иргэний нисэхийн багц дүрмүүдэд нэмж тусгах, дүрмийн зохицуулалтад сөргөөр нөлөөлж байгаа орхигдсон зүйл, заалт, орчуулгын алдаа болон үндэслэлгүйгээр нэмж тусгасан зүйл заалтыг залруулж, дүрмийн зохицуулалтыг боловсронгуй болгох, ИНД-ийн зохицуулалтын хүрээг аюулгүй байдлын дүрмээр хязгаарлаж зөвшөөрөлгүй эх үүсвэрээс авсан, үйл ажиллагаанд тохирдоггүй, ашигладаггүй зохиомол дүрмүүдийг хүчингүй болгох замаар ИНД-ийн зохицуулалтыг оновчтой болгон цэгцлэх зорилгоор ИНЕГ-ын даргын 2015 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн А/791 дүгээр тушаалын дагуу ИНД-ийг цогцоор нь шинэчлэх ажлыг эхлүүлсэн. Энэхүү ажлын хүрээнд олон эх үүсвэртэй 65 ИНД-ийг цэгцлэн, Шинэ-Зеландын эх үүсвэртэй, Чикагогийн конвенци болон Иргэний нисэхийн тухай хуульд нийцсэн 47 ИНД-ийг боловсруулах ажлыг 2016-2021 онуудад иргэний нисэхийн салбарын 80 гаруй шилдэг нисгэгч, инженер, нислэгийн хөдөлгөөний удирдагч болон мэргэжлийн ажилтнуудын оролцоотойгоор хийж гүйцэтгэсэн.

ИНД-ийн боловсруулалтын хувьд нийт боловсруулах 47 ИНД бүгд англи хэл дээр боловсруулагдсан бөгөөд үүнээс 34 ИНД-ийг боловсруулан Зам, тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 6 дугаар сарын 12-ны өдрийн 187 дугаар тушаалаар батлуулж, Хууль зүй, дотоод хэргийн яамны Улсын нэгдсэн бүртгэлийн 4414 дугаарт бүртгүүлсэн. Үлдсэн 13 ИНД (91, 115, 119, 121, 125, 133, 135, 137, 171, 172, 173, 174, 175)-ийг Зам, тээврийн хөгжлийн сайдын 2021 оны 02 дугаар сарын 04-ний өдрийн А/16 дугаар тушаалаар батлуулж, Улсын нэгдсэн бүртгэлийн 4414 дугаарт мөн нэмж, нийт 47 ИНД-ийг бүртгүүлсэн. Шинэчлэн батлуулсан ИНД-үүд нь утга агуулга, найруулга, орчуулгын хувьд сайжирсан бөгөөд зохиомол хүндрэлүүдийг авч, хэрэглэгчдэд ээлтэй, олон улсын байгууллагын шаардлага хангасан болно.

ИНД-ийг шинэчлэх ажлын хүрээнд:

- 47 ИНД, 172 Зөвлөмжийн цуврал, 247 Маягт, 9 Бүртгэлийн дэвтэр, 51 Зурагт хуудас, 35 ИНД-ийн талаарх танилцуулга мэдээлэл бэлтгэн гаргасан;
- 2021 онд ИНД-үүдэд хийсэн харьцуулсан мониторинг хийж, дараах 16 ИНД-д орох өөрчлөлтийг тодорхойлсон. (ИНД-12, ИНД-61, ИНД-66, ИНД-77, ИНД-91, ИНД-95, ИНД-101, ИНД-115, ИНД-119, ИНД-121, ИНД-125, ИНД-135, ИНД-129, ИНД-139, ИНД-172, ИНД-175).
- ИНД-13 "Албадлагын дүрэм"-ийн төслийг монгол, англи хэл дээр, ICAO Model civil aviation regulations-ны 2019 оны 11 дүгээр сарын V.2.9-д үндэслэн боловсруулж, хэлэлцүүлэг хийхээр ИНЕГ-ын цахим хуудсанд байршуулж, 2021 оны 6 дугаар сарын 24-нд иргэний нисэхийн үйл ажиллагаа эрхлэгчдэд санал авахаар хүргүүлсэн. 2021 оны 9 сарын 3-нд шинэчлэн боловсруулсан ИНД-13-ээр "МИАТ" ХК-ийн нисгэгчид оролцсон хэлэлцүүлэг зохион байгуулж, холбогдох саналыг дүрэмд тусгасан. Иргэний нисэхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгаар Дарга албадлагын дүрмийн дагуу захиргааны, торгох болон үнэмлэх, гэрчилгээнд арга хэмжээ авах эрх зүйн үндсийг бүрдүүлэх хуулийн заалт хүлээгдэж байна.

Зөвлөмжийн цуврал, маягтын талаар

Англи хэл дээр 172 (үүнээс орчуулгатай 22) зөвлөмжийн цувралыг боловсруулж батлуулан ИНЕГ-ын цахим хуудсанд байршуулан тогтмол шинэчлэн ажиллаж байна.

Тайлант хугацаанд АС61-1, АС61-2, АС61-3, АС61-5, АС61-7, АС61-10, АС61-12, АС61-13, АС61-14, АС61-15, АС61-16, АС61-17, АС61-18, АС61-19, АС61-20, АС65-7.4, АС65-9, АС65-10, АС66-2.20, АС66-2.21 зөвлөмжийн цувралуудад нэмэлт, өөрчлөлт оруулж ИНЕГ-ын цахим хуудсанд байршуулсан. Мөн АС92-1, АС92-2, АС92-3, АС101-1, АС102-1, АС103-1, АС108-1, АС115-1, АС139-2, АС139-4, АС139-6, АС139-7, АС 139-8, АС139-11, АС139-12, АС139-13, АС139-14, АС139-15,



АС139-16, АС139-17, АС140-1, АС157-1 монгол хэл дээрх зөвлөмжийн цувралыг шинэчлэн батлагдсан ИНД-үүдийн үг хэллэгтэй нийцүүлж ИНЕГ-ын цахим хуудсанд байршуулсан.

Англи хэл дээр 247 (үүнээс орчуулгатай 8) маягтад боловсруулалт хийж ИНЕГ-ын даргаар батлуулан ИНЕГ-ын цахим хуудсанд байршуулан тогтмол шинэчлэн ажиллаж байна.

Тайлант хугацаанд ИНД-ийн шинэчлэлтэй холбоотойгоор 24115/02, 24115/02I, 24115/02J, 24115/02K, 24115/02L, 24115/02M, 24115/02O, 24115/02P, 24119/08, 24119/08M, 24119/09, 24119/10, 24119/10M, 24135/02GAIFR, 24135/03GAHVFR, 24135/04GANIFR, 24135/05GAM, 24135/06GAITC, 24135/07GAETC, 24135/08GADG, 24135/09GADGE, 24139/04, 24171/03, 24172/02, 24173/02, 24174/02, 24175/02 маягтад өөрчлөлт оруулж, ИНЕГ-ын цахим хуудсанд байршуулсан.

Хүчингүй болгох ИНД-ийн талаар

ЗТХЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын 2020 оны 9 дүгээр сарын 18-ны өдрийн А/110 дугаар тушаалаар байгуулагдсан Агаарын тээврийн салбарт хүчин төгөлдөр мөрдөгдөж буй захиргааны хэм хэмжээний актад үнэлгээ хийх ажлын хэсэгт тус газраас холбогдох албан тушаалтнууд орж ажиллан, Иргэний нисэхийн тухай хууль, Олон улсын иргэний нисэхийн тухай конвенцийн дүрмийн зохицуулалтын шаардлага болон байгууллага иргэдэд хүнд суртал чирэгдэл үүсгэж байгаа дараах дүрмүүдийг хүчингүй болгох дүгнэлт гарган ЗТХЯ-ны Бодлого төлөвлөлтийн газарт хүргүүлсэн. Үүнд:

1. ИНД-144 Нисэхийн хангамжийн байгууллага, гэрчилгээжүүлэлт,
2. ИНД-183 Иргэний нисэхийн итгэмжлэгдсэн шалгагч,
3. ИНД-203 Агаарын хөлгийн осол зөрчлийг шинжлэн шалгах,
4. ИНД-301 Ачааны агаарын тээвэрлэгчид эрх олгох,
5. ИНД-75 Агаарын навигацийн үйлчилгээний зайчлалын стандарт,
6. ИНД-138 Эрэн хайх, авран туслах үйл ажиллагаа,
7. ИНД-131 Агаарын хөлгийн түрээс,
8. ИНД-191 Иргэний нисэхийн аюулгүй байдлыг хангахтай холбогдсон мэдээллийн нууцыг хамгаалах,
9. ИНД-303 Агаарын тээвэрлэгчийн даатгал,
10. ИНД-307 Захиалгат нислэгийн зөвшөөрөл,
11. ИНД-313 Гадаадын агаарын тээвэрлэгчдийн үйлдэх захиалгат нислэг,
12. ИНД-329 Тээвэрлэлтийн гэрээ,
13. ИНД-331 Зорчигчын бүртгэл

Иргэний нисэхийн ерөнхий газрын даргын 2021 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн “Журам хүчингүй болгох тухай” А/16 дугаар тушаалаар “Түр аэродром, талбай ашиглах журам”, 2021 оны 4 дүгээр сарын 29-ний өдрийн А/56 дугаар тушаалаар “Агаарын тээврийн үйл ажиллагаанд оролцогчдод насны хязгаарлалт тогтоох тухай” 2011 оны А/134 дүгээр тушаал, “Агаарын хөлгийн нислэгт тэнцэх чадварын хязгаарлалт мөрдөх тухай” 2019 оны А/61 дүгээр тушаал, “Нисэх багийн гишүүдэд тавигдах шаардлагын тухай” 2019 оны А/295 дугаар тушаалуудыг тус тус хүчингүй болгосон.

Авлигын индексийг бууруулах ажлын хүрээнд ИНЕГ-ын хэмжээнд хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа дүрэм, журмуудын судалгааг нэгтгэн гаргаж, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийн ИНБД-ийн шинэчлэлийн хүрээнд нийцүүлэн хүнд суртал чирэгдэл үзүүлсэн дүрэм журмуудыг хүчингүй болгох, ерөнхий зааварт нэгтгэж оруулж шинэчлэн батлуулах ажлыг зохион байгуулан ажиллаж байна.

Дүрмийн шаардлагаас чөлөөлөх талаар

Нислэгийн хөдөлгөөний үйлчилгээний албаны ИНД-65.13(2)-т заасан англи хэлний ур чадварын шаардлага болон ИНД-65.53(а)(4), 65.103(а)(4), 65.153(а)(3) болон 65.203(а)(3)-т заасан агаарын хөлгийн нислэгийн бүхээгийн танилцах дадлага хийх шаардлагаас чөлөөлүүлэх, “МИАТ” ТӨХК болон Монголын нисгэгчдийн холбооны ИНД-61.11(b)-д заасан англи хэлний ур чадварын шаардлагаас чөлөөлүүлэх хүсэлтийг байцаагчийн дүгнэлт гаргуулахаар ХЭЗДБГ-ын даргын 2021 оны 5 дугаар сарын 10-ны өдрийн 28 тоот албан бичгээр НААХЗА-нд хүргүүлсэн бөгөөд дүрмийн шаардлагаас чөлөөлөх үндэслэлгүй байна гэсэн хариу мэдэгдсэн.

ИНД-ийг сурталчлан таниулах талаар

2021 оны 3 дугаар сарын 26-нд Иргэний нисэхийн үндэсний төвд шинэчлэн батлагдсан ИНД-171, ИНД-172, ИНД-173, ИНД-175 дүрмийн танилцуулга, 2021 оны 3 дугаар сарын 29-нд Нислэгийн цаг уурын төвд ИНД-174 дүрмээр тус тус танилцуулга хийсэн.

“Air navigation service & Aeronautical chart”, “Altitude, height, level, elevation”, “Enforcement summary”, “ICAR and NZCAR’s revision cross-reference”, “NZ Part 19 reference to MCAR”, “Transition level”, “Агаарын тээврийн даатгал”, “Агаарын тээвэрлэгчийн бүтэц, удирдах ажилтанд тавих шаардлага”, “Зөрчлийн тухай хуулийн талаар”, “ИНД-ийн баталсан болон нэмэлт өөрчлөлт оруулсан



түүх”, “ИНД-ийн боловсруулалтын үе шатууд”, “Иргэний нисэхийн тухай хуулийн алдаатай заалт”, “Иргэний нисэхийн эрх зүйн баримт бичгийн шатлал”, “Иргэний нисэхийн эрх зүйн зохицуулалт”, “Конвенцийн хавсралтууд болон ИНД-ийн хамаарал” зэрэг 15 танилцуулгыг шинээр болон шинэчлэн ИНЕГ-ын цахим хуудасны “Мэдээлэл” хэсэгт байршуулсан.

“Definitions of ultralight and microlight aircraft”, “Part-119 Senior Persons Requirement”, “Transition altitude and level”, “VFR Visibility Minima”, “Visibility Minima” 5 зурагт хуудсыг шинэчилж байгууллагын цахим хуудаст байршуулсан.

Иргэний нисэхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд Засгийн газрын гишүүдээс санал авах явцад Хууль зүй, дотоод хэргийн яамнаас хуулийн төслийг дахин боловсруулах, төсөлд дахин санал авах чиглэл өгсөн. Үүний дагуу Иргэний нисэхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн эцсийн хувилбарыг боловсруулах, эрх бүхий байгууллагад барих саналыг өргөн мэдүүлэх, эцэслэн хэлэлцүүлэхээр Иргэний нисэхийн ерөнхий газрын даргын 2021 оны 6 дугаар сарын 03-ны өдрийн А/64 дүгээр тушаалаар НААХЗА-ны даргаар ахлуулсан 12 хүний

бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг байгуулсан. Ажлын хэсэг нь Монгол Улсын хууль тогтоомжийг боловсронгуй болгох үндсэн чиглэлд Зам, тээврийн хөгжлийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд тусгагдсан Иргэний нисэхийн тухай хуулийн төсөл (шинэчилсэн найруулга)-ийг Монгол Улсын олон улсын гэрээний дагуу нисэхийн аюулгүй ажиллагааны хяналт, зохицуулалтын тогтолцоог боловсронгуй болгох, иргэний нисэхийн аюулгүй ажиллагаа, үр ашигтай хөгжлийг дэмжихэд чиглэсэн зохицуулалтыг бүрдүүлэх, хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлалд нийцүүлэх, төслийн бүрдүүлбэр болон Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх бэлтгэл ажлыг хангаж ажилласан.

Ажлын хэсэг нь 2021 оны 6 дугаар сарын 03-наас 2021 оны 10 дугаар сарын 18-ны өдрийн хугацаанд нийт 19 удаагийн биечилсэн болон цахим хурал зохион байгуулж, ажлын төлөвлөгөө гарган, зохион байгуулалт хийж, хуулийн шинэчилсэн найруулгын төслийг судлан хэлэлцэж, санал боловсруулан ажилласан.

Иргэний нисэхийн бодлого, төлөвлөлтийн чиглэлээр дэд ажлын хэсгийн зүгээс тусгайлсан саналгүй бөгөөд бусад дэд ажлын хэсэг болох Төрийн байгууллагын чиг үүрэг, Иргэний нисэхийн хяналт, зохицуулалт, Агаарын тээврийн бодлого зохицуулалт, Агаарын навигацийн үйл ажиллагаа, Нисэх буудал, аюулгүйн хамгаалалтын үйл ажиллагааны чиглэлээр байгуулагдсан 5 дэд ажлын хэсгүүдээс давхардсан тоогоор шинээр тусгах зүйл, заалтын санал 27, зүйл заалт өөрчлөн найруулах санал 82, зүйл заалт хасах санал 7, нэр томъёоны тайлбарыг шинэчлэн найруулах 60 орчим саналыг тус тус ирүүлснийг нэгтгэн 2021 оны 10 дугаар сарын 28-ны өдөр ажлын хэсгийн гишүүдтэй хэлэлцүүлэг хийж, харилцан санал солилцож хуулийн төслийг Иргэний нисэхийн ерөнхий газрын даргын 2021 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн 01/1856 тоот албан бичгээр ЗТХЯ-нд хүргүүлсэн.

Иргэний нисэхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл батлагдсанаар салбарын бүтэц зохион байгуулалт боловсронгуй болох, салбарын урт, дунд хугацааны хөгжлийн стратегитай уялдсан, салбарын хөгжлийг шинэ шатанд гаргах эрх зүйн орчин бүрдэх ач холбогдолтой юм.

ХОЁР. АГААРЫН ТЭЭВРИЙН ЭДИЙН ЗАСГИЙН ЗОХИЦУУЛАЛТ, ГАДААД ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛЭЭР:

Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт “Төрөөс агаарын тээврийн салбарт баримтлах бодлогод тулгуурлан орон нутгийн болон олон улсын нислэгийн тоог нэмэгдүүлэх, өрсөлдөөнийг дэмжих замаар тус салбарт үнэ тарифыг бууруулах”, Төрөөс иргэний нисэхийн салбарт 2020 он хүртэл баримтлах бодлогын баримт бичигт “Агаарын тээврийн тээврийн салбарт татварын таатай орчин бүрдүүлэх замаар агаарын тээврийн өрсөлдөх болон санхүүгийн чадавхыг сайжруулах, иргэний нисэхийн үйлчилгээний өсөн нэмэгдэж байгаа эрэлт хэрэгцээг хангахад чиглэсэн санхүүгийн бодлогыг төрөөс баримтална” гэж тусгагдсаны дагуу орон нутгийн хуваарьт нислэгийн үйлчилгээ болон орон нутгийн нисэх буудлын үйлчилгээг НӨАТ-аас чөлөөлөх эрх зүйн зохицуулалтыг бүрдүүлэх судалгаа, бичиг баримтыг боловсруулан, хуулийн нэмэлт өөрчлөлт оруулах саналыг хавсралтуудын хамт дахин шинэчлэн ИНЕГ-ын 2021 оны 05 дугаар сарын 19-ний өдрийн 01/757 тоот албан бичгээр ЗТХЯ-нд хүргүүлсэн.

Дэлхийн Худалдааны Байгууллагын Иргэний агаарын хөлгийн худалдааны хэлэлцээрт нэгдэн орсонтой холбогдуулан дотоодын хууль тогтоомж, эрх зүйн зохицуулалтыг бүрдүүлэх зорилгоор Иргэний агаарын хөлөг, түүний эд анги, бүрэлдэхүүн хэсгийг гааль, нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх хуулийн төслийн үзэл баримтлал, хуульд нэмэлт өөрчлөлт оруулах төсөл, холбогдох судалгаа бүрдүүлбэр, танилцуулгыг дахин шинэчлэн боловсруулж, санхүүгийн тооцооллын хамт ЗТХЯ-ны Иргэний нисэхийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газарт 2021 оны



01, 03 дугаар сард цахимаар хүргүүлсэн. Мөн хуулийн төслийг Их хурлаар хэлэлцүүлэх бэлтгэл ажлын хүрээнд Гааль, НӨАТ-ын хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай танилцуулгыг бэлтгэж 2021 оны 10 дугаар сард ЗТХЯ-нд цахимаар хүргүүлсэн. Монгол Улсын Их Хурлын Төсвийн байнгын хороогоор 2021 оны 12 дугаар сарын 14-ний өдөр Гааль, НӨАТ-ын хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай асуудлыг хэлэлцүүлж дэмжигдсэн ба 2021 оны 12 дугаар 15-ны өдөр Монгол Улсын Их Хурлаар хэлэлцүүлсэн.

Олон улсын гэрээ конвенци:

“Олон улсын иргэний нисэхийн тухай конвенцын 50(а), болон 56 дугаар зүйлд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай протокол”-д нэгдэн орох бэлтгэлийг ханган, тус протоколуудын орчуулга, нэгдэн орох хуулийн төслийн үзэл баримтлал, танилцуулга, хуулийн төслийг боловсруулан ИНЕГ-ын 2021 оны 05 дугаар сарын 24-ний өдрийн 01/779 тоот албан бичгээр ЗТХЯ-нд хүргүүлсэн. Тус материалыг ЗТХС-ын Зөвлөлийн 2021 оны 06 дугаар сарын 04-ний өдрийн хурлаар хэлэлцэн Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхээр шийдвэрлэсэн. Мөн “Олон улсын иргэний нисэхийн тухай конвенцын 50(а) болон 56 дугаар зүйлд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай протокол”-ыг соёрхон батлах тухай хуулийн төслийн үр нөлөөг үнэлсэн үнэлгээ болон зардлын тооцоо хийсэн тайланг тус тус боловсруулан, ЗТХЯ-нд 2021 оны 09 дүгээр 30-ны өдөр цахимаар хүргүүлсэн. Энэхүү протоколд нэгдэн орох бэлтгэл ажлын хүрээнд дээрх протоколын албан ёсны орчуулгыг ГХЯ-аар хянуулан, баталгаажуулалт хийлгүүлэн 2021 оны 11 дүгээр сарын 01-ний өдрийн 01/1866 тоот албан бичгээр ЗТХЯ-нд хүргүүлсэн.

Олон улсын гэрээний тухай Монгол Улсын хуулийн 7 дугаар зүйлийн 7.6. дах хэсэгт заасны дагуу Иргэний нисэхийн эсрэг хууль бус үйлдэлтэй тэмцэх тухай 2010 оны Бээжингийн конвенцийн орчуулга, Агаарын хөлөгт үйлдсэн гэмт хэрэг, бусад зарим үйлдлийн тухай 1963 оны Конвенцод нэмэлт өөрчлөлт оруулсан 2014 оны Монреалийн Протоколын орчуулга, Бээжин хотноо 2010 онд батлагдсан Агаарын хөлгийг хууль бусаар булаан авах үйлдлийг хориглох тухай 1970 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн Гаагын конвенцийн нэмэлт протоколын орчуулгыг тус тус хийн хянан баталгаажуулахаар ГХЯ-нд 2021 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн 01/911 тоот албан бичгээр хүргүүлсэн. Мөн энэ оны 10 дугаар сарын 22-ны өдөр ГХЯ-ны Олон улсын гэрээ, эрх зүйн газартай орчуулга хянан баталгаажуулах гэрээ байгуулан ажиллаж байна.

Агаарын харилцаа болон хамтын ажиллагааны чиглэлээр:

ИНЕГ-ын даргын 2021 оны 04 дүгээр сарын 02-ны өдрийн А/46 дугаартай тушаалаар Монгол Улс болон Америкийн Нэгдсэн Улс хооронд шууд нислэг эхлүүлэхтэй холбоотойгоор АНУ-ын Төрийн департамент, Холбооны нисэхийн захиргаа, Тээврийн яам, Тээврийн аюулгүй байдлын агентлагийн төлөөлөлтэй хамтран Агаарын харилцаа, эдийн засгийн зохицуулалт бүрдүүлэх бэлтгэл ажлыг хангах ажлын хэсэг, Нисэхийн аюулгүй ажиллагааны аудит шалгалтад хамрагдах бэлтгэл ажлыг хангах ажлын хэсэг, Нисэхийн аюулгүй байдлын үнэлгээнд хамрагдах бэлтгэл ажлыг хангах ажлын хэсгийг тус тус байгуулсан. Мөн ЗТХС-ын 2021 оны 06 дугаар сарын 18-ны өдрийн 89 дүгээр тушаалаар Зам, тээврийн хөгжлийн дэд сайдаар ахлуулсан ЗТХЯ, ГХЯ болон ИНЕГ-ын төлөөллүүд оролцсон ажлын хэсэг байгуулагдсан.

Энэхүү ажлын хүрээнд агаарын харилцааны хэлэлцээр байгуулахтай холбогдуулан нарийвчилсан төлөвлөгөө гарган ажилласан. Үүнд:

- АНУ-ын талаас манай талд ирүүлсэн Агаарын тээврийн хэлэлцээр /АТХ/-ийн төслийн албан ёсны орчуулгыг бэлтгэн, баталгаат орчуулгын газраар энэ оны III дугаар улиралд баталгаажуулсан.
- АНУ-аас гадаадын бусад улсуудтай байгуулсан АТХ-ийн нэгдсэн жагсаалт бэлтгэсэн. Мөн хэлэлцээрийн төслийг БНХАУ, Япон Улс, БНСУ-ын АТХ-тэй харьцуулсан судалгаа хийж, хэлэлцээрт тусгасан аяллын дугаар хамтран ашиглах, томилгоо, давтамж, эрх олгох зэрэг зүйл заалтуудын нарийвчилсан харьцуулалт хийж удирдлагад хүргүүлсэн.
- АТХ байгуулах бэлтгэл ажлын хүрээнд АНУ-ын Элчин сайдын яам болон бусад холбогдох байгууллагатай хамтран ажиллаж байгаа бөгөөд 2021 оны 11 дүгээр сарын 11-ний өдөр АТБЗГ-ын дарга нь АНУ-ын Элчин сайдын яамны Худалдаа, эдийн засгийн зөвлөх Лаурэн Ховистай албан уулзалт хийсэн. Тус хэлэлцээрийг байгуулах нь эрх зүйн орчин бүрдүүлэх эхний алхам гэдгийг манай талд мэдэгдсэн бөгөөд хэлэлцээ эхлүүлэх болон нисэхийн аюулгүй ажиллагааны аудит шалгалтад хамрагдах ажлуудыг зэрэг эхлүүлэх нь зүйтэй хэмээн тодорхойлсон.



- ИНЕГ-ын төлөөлөл “МИАТ” ТӨХК-тай 2021 оны 11 дүгээр сарын 04-ний өдөр АНУ руу шууд нислэг үйлдэх бэлтгэл ажлын хүрээнд хийж гүйцэтгэсэн ажлын талаар санал, мэдээлэл солилцох хамтарсан уулзалтыг зохион байгуулсан. Дээрх уулзалтаар “МИАТ” компанийн зүгээс гүйцэтгэж байгаа ажлын явц болон төлөвлөгөөний хэрэгжилт, БОИНГ 787 маягийн агаарын хөлгийг холын нислэгт ашиглахтай холбоотой харьцуулсан судалгаа, эдийн засгийн үр ашиг, бусад үйл ажиллагааны талаар сүүлийн үеийн мэдээллийг танилцуулсан.

Испанийн Вант Улстай Агаарын харилцааны тухай хэлэлцээр байгуулах асуудал нь Ковид-19 цар тахлын улмаас хэлэлцээрийг үзэглэх цахим арга хэмжээг 2021 оны 07 дугаар сард зохион байгуулахаар Испанийн талтай цахим шуудангаар энэ оны 03, 04 дүгээр сард харилцан захидал бичиж, тохиролцсон. Испанийн талтай байгуулах Агаарын харилцааны тухай хэлэлцээрийн төслийг эцэслэн тохиролцож, 2021 оны 07 дугаар сарын 27-ны өдөр үзэглэсэн.

Бүгд Найрамдах Ардчилсан Лаос Ард Улстай Агаарын харилцааны тухай хэлэлцээр үзэглэх ажлыг 2021 оны 07 дугаар сард зохион байгуулахаар Лаосын талтай цахимаар тохирсон боловч Ковид-19 цар тахалтай холбоотойгоор хойшлогдсон. Лаосын талтай Агаарын харилцааны тухай хэлэлцээр байгуулах асуудлыг 2018 оноос хойш хэлэлцэж байгаа бөгөөд Лаосын талаас тогтмол хойшлуулсаар байна. Агаарын харилцааны хэлэлцээрийг цахимаар тохирох, цахим уулзалт зохион байгуулах зэрэг саналуудыг хэлэлцээрийн төслийн хамт тогтмол хүргүүлж байна. Лаосын талаас 2021 оны 10 дугаар сар хүртэл хойшлуулсан. Лаосын талаас энэхүү уулзалтын товын талаар эргэн холбогдоогүй тул манай талаас дахин хүсэлт гаргасны дагуу 11 дүгээр сард цахим уулзалт хийхээр төлөвлөсөн боловч эргэн ямар нэг мэдээлэл ирүүлээгүй болно. Лаосын талаас цахим уулзалт, хэлэлцээ хийх товоо тохирохгүй байгаатай холбогдуулан ИНЕГ-аас 2021 оны 12 дугаар сарын 02-ны өдөр АХХ-ийн төслийг цахимаар харилцан тохирох саналаа Лаосын Иргэний нисэхийн удирдах байгууллагад хүргүүлээд байна. Мөн Бүгд Найрамдах Ардчилсан Лаос Ард Улсаас Монгол Улсад суугаа Элчин сайдын яам руу 2021 оны 12 дугаар сарын 06-ны өдрийн 01/70 тоот албан бичгээр дээрх хүсэлт болон АХХ-ийн төслийг хүргүүлсэн.

ЗТХЯ-аас ирүүлсэн чиглэлийн дагуу Япон Улсын Иргэний нисэхийн товчоотой хоёр улсын хооронд долоо хоногийн нислэгийн давтамж нийт 30 байхаар хэлэлцэж байна. Японы талаас Санамж бичгийн төслийг боловсруулан өөрсдийн агаарын тээвэрлэгчдээс саналыг авч буй тухай мэдэгдсэн. Тус газарт 2021 оны 08 дугаар сарын 26-ны өдрийн 09/3697 тоот албан бичгээр ЗТХЯ-аас ирүүлсэн Монгол Улс, Япон Улс хооронд үйлдэх нислэгийн давтамжийг долоо хоногийн нийт 30 удаа болгон нэмэгдүүлж, нислэгийн давтамжид харгалзах багтаамжийг Японы талтай тохирох чиглэлийн дагуу Японы Иргэний нисэхийн товчоонд долоо хоногийн 7500 суудал байх санал хүргүүлсэн. Японы Иргэний нисэхийн товчооноос орчин үеийн өргөн биетэй агаарын хөлгүүдийн суудлын багтаамж ойролцоогоор 250 орчим тул манай санал болгосон долоо хоногийн 7500 суудал буюу нэг нислэгийн 250 суудлаар хязгаарлах шаардлагагүй гэж үзсэн бөгөөд нислэгийн суудлын багтаамж тогтоох асуудал нь аливаа нэг талын дотоодын дүрмээр бус хоёр байгууллага хоорондын хэлэлцэж тохиролцох асуудал болохыг тайлбарлан нислэгийн багтаамжтай уялдуулахгүй байх санал ирүүлснийг 2021 оны 10 дугаар сарын 15-ны өдрийн 01/1766 тоот албан бичгээр ЗТХЯ-нд уламжлан Монгол Улс болон Япон Улс хооронд үйлдэгдэх нислэгийн нийт давтамжийг долоо хоногийн 30 болгон нэмэгдүүлэх тал дээр чиглэл өгөхийг хүссэн. ЗТХЯ-аас 2021 оны 11 дүгээр сарын 02-ны өдрийн 09/4874 тоот албан бичгээр давтамж, багтаамжийг уялдуулах чиглэлүүд өгсний дагуу Японы талтай дахин хэлэлцээ хийж санал солилцон ажиллаж байна. Японы талаас 2021 оны 11 дүгээр сарын 12-ны өдөр Монгол талын сүүлийн саналыг дотооддоо хэлэлцэн ойрын хугацаанд хариу өгөхөө мэдэгдсэн болно. Японы талаас хариу ирээгүйтэй холбогдуулан ИНЕГ-аас Японы талд 2021 ондоо багтаан Санамж бичиг байгуулах саналаа хүргүүлсэн бөгөөд Японы тал дотоодын агаарын тээвэрлэгчдээс санал авч байгаа тул ойрын хугацаанд хариу өгөхөө мэдэгдсэн.

ЗТХЯ-аас хоёр улсын нутаг дэвсгэрт нисэн очих цэг нэмэх, агаарын тээвэрлэгчдийн томилгооны тоог нэмэх саналаа ОХУ-ын Тээврийн яаманд 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн 09/265 тоот албан бичгээр хүргүүлсэн боловч ОХУ-ын Тээврийн яамнаас цэг нэмэх, томилгооны тоонд өөрчлөлт оруулах асуудлыг Ковид-19 цар тахлын нөхцөл байдал сайжирч, олон улсын нислэг сэргэх үед хэлэлцэх саналаа 2021 оны 02 дугаар сарын 05-ны өдрийн 9-1549 тоот албан бичгээр ирүүлсэн.

ОХУ-ын тээврийн яамны Иргэний нисэхийн төрийн бодлогын газраас ИНЕГ-т ирүүлсэн 2021 оны 08 дугаар сарын 06-ны өдрийн 9-2410 тоот албан бичгээр МУ-ын нутаг дэвсгэр дээр Улаангом, ОХУ-ын нутаг дэвсгэр дээр Кызыл нислэгийн цэгийг нэмж тохирох асуудлыг албан бичиг солилцон баталгаажуулах саналыг ирүүлсэнтэй холбогдуулан ЗТХЯ-ны ИНБХЗГ-ын 2021 оны 08 дугаар сарын 24-ний өдрийн 01/1380 тоот албан бичгээр тус асуудлыг дэмжих, уг тохиролцоог баталгаажуулах



арга хэмжээ авах чиглэл өгсний дагуу МУ-ын нутаг дэвсгэр дээр Улаангом, ОХУ-ын нутаг дэвсгэр дээр Кызыл нислэгийн цэгийг нэмэх тохиролцоог баталгаажуулсан тухай албан бичгийг 2021 оны 09 дүгээр сарын 07-ны өдрийн 01/49 тоот албан бичгээр ОХУ-ын тээврийн яамны Иргэний нисэхийн төрийн бодлогын газарт хүргүүлсэн.

Бүгд Найрамдах Индонези Улс, Бүгд Найрамдах Малайз Улсын Иргэний нисэхийн байгууллагуудтай хоёр улсаас томилогдсон агаарын тээвэрлэгчид аяллын дугаар хуваан ашиглах зохицуулалт тохирох тухай санал, санамж бичгийн төслийн хамт 2021 оны 03 дугаар сарын 23-ны өдрийн 01/11 тоот албан бичгээр хүргүүлсэн. Малайзын талаас 04 дүгээр сарын 03-ны өдөр хариу ирсэн бөгөөд талууд Санамж бичгийн төсөл дээр харилцан санал солилцон ажилласан. Индонези Улсын талаас хариу ирүүлээгүй тул дипломат шугамаар Индонезийн талд аяллын дугаар хуваан ашиглах хүсэлт хүргүүлэх тухай хүсэлтийг 2021 оны 06 дугаар сарын 02-ны өдрийн 01/831 тоот албан бичгээр ГХЯ-нд хүргүүлсэн. Индонезийн талаас 2021 оны 08 дугаар сарын 05-ны өдөр дан аяллын дугаар хамтран ашиглах зохицуулалт бус Агаарын харилцааны хэлэлцээр байгуулах саналаа ирүүлсэн бөгөөд тус газрын зүгээс 2021 оны 08 дугаар сарын 26-ны өдөр агаарын харилцааны хэлэлцээрийн төслөө хүргүүлсэн. АТБЗГ-аас 2021 оны 10 дугаар сарын 28-ны өдөр Индонези, Малайз Улсын Иргэний нисэхийн ерөнхий газрын Агаарын харилцаа, агаарын тээвэр хариуцсан албан тушаалтнуудтай цахимаар холбогдсон бөгөөд Монголын талаас ирүүлсэн саналыг хүлээн авч ойрын хугацаанд хариу өгөхөө мэдэгдсэн. Индонезийн талаас өөрийн АХХ-ийн төслийг 2021 оны 11 дүгээр сарын 11-ний өдөр ирүүлсэн бөгөөд талууд АХХ төсөл тохиролцох тал дээр хамтран ажиллаж байна.

ЗТХЯ-аас 2021 оны 09 дүгээр сарын 08-ны өдрийн 09/3939 тоот албан бичгээр МУ-ын Засгийн газар болон БНХАУ-ын Засаг Захиргааны онцгой бүс Хонг Конгийн Засгийн газар хооронд 2013 оны 10 дугаар сарын 11-ний өдөр байгуулсан Харилцан ойлголцлын санамж бичгийн 7 дугаар заалтад нислэгийн давтамж нэмэгдүүлэхээр өөрчлөлт оруулах асуудлыг Хонг Конгийн талтай баталгаажуулах арга хэмжээ авах чиглэлийг ИНЕГ-т өгсөнтэй холбогдуулан тус газрын зүгээс хоёр талаас томилогдсон агаарын тээвэрлэгчид долоо хоногийн 15 удаагийн давтамжтайгаар нислэг үйлдэх эрхтэй байхаар өөрчлөлт оруулан баталгаажуулах арга хэмжээг авсан талаар 2021 оны 10 дугаар сарын 04-ний өдрийн 01/1676 тоот албан бичгээр ЗТХЯ-нд мэдэгдсэн.

Бүгд Найрамдах **Солонгос** Улсын чиглэлд нислэг үйлдэж буй агаарын тээвэрлэгчид болох “Ашиана Эйрлайнс”, “Кореан Эйр” компаниудын төлөөлөгчийн газрын тэргүүн болон “МИАТ” ТӨХК-ийн удирдлагатай 2021 оны 09 дүгээр сарын 02-ны өдөр уулзалт хийн, БНСУ-ын чиглэлийн нислэгийн зорчигчдоос Коронавируст халдварын тохиолдлууд илэрч байгаа асуудлыг цаашид залруулах арга хэмжээний талаар хэлэлцэж санал сонссон. Уулзалтын төгсгөлд олон улсын нислэгийн хуваарийг урт хугацаагаар батлах үүрэг өгснийг танилцуулсан бөгөөд нислэгийн үйл ажиллагааг урт хугацаагаар буюу 2021 оны 11, 12 дугаар сар, 2022 оны эхний улирлаар төлөвлөн саналаа ирүүлэх үүргийг өгсөн. Уулзалтын тэмдэглэлийг хөтлөн ЗТХЯ-ны ИНБХЗГ-т цахим хэлбэрээр 2021 оны 09 дүгээр сарын 09-ний өдөр хүргүүлсэн. Түүнчлэн МУ болон БНСУ хооронд үйлдэгдэж буй нислэгийг тогтмол нислэг болгох зорилгоор 2021 оны 10 дугаар сарын 12-оос 15-ны өдрүүдэд БНСУ-ын Газар, дэд бүтэц, тээврийн яамны байцаагч нарыг “Чингис Хаан” ОУНБ-д үзлэг шалгалт хийх ажлыг зохион байгуулсан.

МУ-ын Засгийн газар болон Бүгд Найрамдах **Грек** Улсын Засгийн газар хооронд байгуулах Агаарын харилцааны тухай хэлэлцээрт гарын үсэг зурж эцэслэн байгуулах асуудлыг энэ онд багтаан дипломат шугамаар солилцон албажуулах саналыг Грек Улсын Гадаад харилцааны яаманд мэдэгдэж, мөн хоёр улсын хооронд Агаарын харилцааны хэлэлцээр байгуулахад дэмжлэг хүссэн тухай 2021 оны 10 дугаар сарын 28-ны өдрийн 01/1838 тоот албан бичгээр ГХЯ-нд хүргүүлсэн. ГХЯ нь Бүгд Найрамдах Болгар Улсын Софи дахь МУ-ын Элчин сайдын яамаар дамжуулан Бүгд Найрамдах Грек Улсын ГХЯ-нд тус саналыг хүргүүлсэн. Грекийн талаас Бээжин хотод Монгол болон Грек Улсын элчин сайдын яамдууд байгаа тул хэлэлцээрийн төслийг Монгол, Грек, Англи 3 хэл дээр бэлтгэн Бээжинд суугаа хоёр улсын элчин сайдуудаар албажуулан гэрээнд гарын үсэг зурахаар ГХЯ-тай хамтран ажиллаж байна.

Эдийн засгийн зохицуулалтын чиглэлээр:

Японы олон улсын хамтын ажиллагааны байгууллага /JICA/-аас МУ-ын аялал жуулчлалын салбарын өнөөгийн байдал, ахиц ба сул хүндрэлтэй талууд, салбарын суурь ба хавсарга мэдээлэл, хэрэгцээт тусламж дэмжлэг, бусад донор байгууллагуудын хамтын ажиллагааны чиг хандлагыг таньж мэдсэний үндсэн дээр аялал жуулчлалын хөгжлийн бодлогын саналыг дэвшүүлэх үндсэн



зорилго бүхий “Тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх талаар мэдээлэл цуглуулах судалгаа”-г маягтын дагуу гаргаж ИСА-д 2021 оны 04 дүгээр сарын 12-ны өдөр цахимаар хүргүүлсэн.

Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газрын 2021 оны 04 дүгээр сарын 05-ны өдрийн 1/692 тоот албан бичгийн дагуу агаарын тээврийн салбарын статистик мэдээлэл, агаарын тээвэрлэгчдийн дэлгэрэнгүй мэдээлэл болон холбогдох бусад материалыг 2021 оны 04 дүгээр сарын 09-ний өдрийн 01/596 тоот албан бичгээр хариу хүргүүлсэн.

ЗТХЯ-ны 2021 оны 01 дүгээр сарын 12-ны өдрийн 09/121 тоот албан бичгээр аялал жуулчлал, агаарын тээврийг сэргээх талаар БОАЖЯ-аас хамтран ажиллахаар холбогдох мэдээлэл хүссэний дагуу агаарын тээврийн салбарын өнөөгийн байдал, цаашид агаарын тээврийн салбарт чөлөөт өрсөлдөөнийг дэмжих, зорчигч урсгалыг нэмэгдүүлэх чиглэлээр хийгдэх ажлын төлөвлөгөөний саналыг боловсруулж 2021 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн 01/106 тоот албан бичгээр ЗТХЯ-нд хариу хүргүүлсэн.

"Орон нутгийн нислэгийн зардлыг бууруулах зорилгоор нислэгийн тийз борлуулах, газрын үйлчилгээ, орон нутгийн шатахуун хангамж зэрэг үйлчилгээг нэгдсэн зохион байгуулалтад оруулах боломжтой эсэх талаар судалгаа"-г боловсруулан 2021 оны 06 дугаар сарын 08-ны өдрийн 01/892 тоот албан бичгээр ЗТХЯ-нд хүргүүлсэн.

"Агаарын харилцааны хэлэлцээрүүдэд тусгасан нислэгийн чиглэлийн зах зээлийн судалгаа"-г боловсруулан 2021 оны 06 дугаар сарын 08-ны өдрийн 01/892 тоот албан бичгээр ЗТХЯ-нд хүргүүлсэн.

Ковид-19 цар тахлын агаарын тээврийн салбарт нөлөөлж буй нөлөөлөл, иргэний нисэхийн салбар, санхүү эдийн засгийн нөхцөл байдал, тийзийн үнийг бууруулах талаар санал боловсруулан ЗТХЯ-ны ИНБХЗГ-т 2021 оны 08 дугаар сарын 31-ний өдөр цахимаар хүргүүлсэн.

Иргэний нисэхийн салбарын эдийн засаг, санхүүгийн өнөөгийн нөхцөл байдал Ковид-19 цар тахлын нөлөөлөл, тулгамдаж буй асуудал, агаарын тээвэрлэгчийн санхүүгийн нөхцөл байдал, нэн шаардлагатай санхүүжилтийн талаар танилцуулга боловсруулан 2021 оны 09 дүгээр сарын 07-ны өдрийн 01/1481 тоот албан бичгээр ЗТХЯ-ны ИНБХЗГ-т хүргүүлсэн.

“Хилийн чанад дахь Монголчуудын зөвлөл” ТББ-аас холбогдох албан тушаалтан, төрийн байгууллагуудад шаардлага ирүүлсэнтэй холбогдуулан нислэгийн тийзийн үнэ тариф, дэлхий даяар тархсан Ковид-19 цар тахлаас өмнөх болон цар тахлын үеийн зах зээлийн байдлын судалгаа, дүгнэлтийг боловсруулан 2021 оны 10 дугаар сарын 19-ний өдрийн 01/1793 тоот албан бичгээр ЗТХЯ-ны ИНБХЗГ-т хүргүүлсэн.

Олон улсын нислэг нээгдсэн боловч зорчигч урсгал нэмэгдэхгүй байгаатай холбогдуулан МУ-ын иргэд гадаад улсад зорчих боломж болон тусгаарлагдах хугацааны талаар судалгаа хийж мэдээлэл бэлтгэн, ЗТХЯ-ны ИНБХЗГ-т 10 дугаар сарын 29-ны өдөр цахимаар хүргүүлсэн.

Агаарын тээврийн салбарыг сэргээх чиглэлээр:

ИНЕГ-ын даргын 2021 оны А/53 дугаар тушаалаар Агаарын тээврийг сэргээх төлөвлөгөө боловсруулах ажлын хэсэг байгуулагдсан. Ажлын хэсэг нь агаарын тээврийг сэргээх төлөвлөгөөг боловсруулан ажиллаж дараах ажлыг хийж гүйцэтгэсэн. Үүнд:

- Агаарын тээвэрлэгчдээс санал авч, УОК-ийн тусгаарлан ажиглах байрны хүрэлцээнд нийцүүлэн 2021 оны 05, 06, 07, 08, 09, 10 дугаар сарын тусгай үүргийн нислэгийн хуваарийг тус тус батлуулан нийтэд зарласан. 2021 оны 09 дүгээр сарын 27-ны өдрийн УОК-ын хурлын тэмдэглэлээр гадаад улсаас ирж буй зорчигчийг 2021 оны 10 дугаар сарын 15-ны өдрөөс тусгаарлан ажиглах байранд тусгаарлах шаардлагагүй гэсэн шийдвэр гарсантай холбогдуулан 2021 оны 11, 12 дугаар сар, 2022 оны 01 дүгээр улирлын нислэгийн цагийн хуваарьт агаарын тээвэрлэгчдийн хүсэлтээр нислэгийн тоог нэмэгдүүлэн, нислэг гүйцэтгэх өдрийг тогтмолжуулан 10 дугаар сарын 28-ны өдөр батлуулан, ИНЕГ-ын цахим хуудсанд байршуулж олон нийтэд мэдээлсэн. “Чингис Хаан” ОУНБ, ИНҮТ-д албан бичгээр хүргүүлсэн.
- Хил нээхтэй холбогдуулан УОК-оос гаргаж буй журамд нийцүүлэн агаарын тээврийн үйл ажиллагааг эхлүүлэх бэлтгэл ажлыг хангах талаар ажлын хэсгийн төлөвлөгөөнд тусгасан ба энэ талаар судалгаа хийж агаарын тээвэрлэгчдийг бэлтгэл ажлыг хангахыг чиглэл болгосон.



- Агаарын тээвэрлэгчдийн санхүүгийн байдалд шинжилгээ хийж, 2021 оны 06 дугаар сарын 04-ний өдрийн 01/870 тоот албан бичгээр агаарын тээвэрлэгчдэд санхүүгийн дэмжлэг үзүүлэх санал танилцуулгыг ЗТХЯ-нд хүргүүлсэн.
- Аюулгүй ажиллагаа, аюулгүйн хамгаалалтын хяналтын талаар хэрэгжүүлж буй арга хэмжээнүүдийн үр нөлөөг үнэлэн, Ковид-19 цар тахлаас шалтгаалан өөрчлөгдөж буй хэрэгцээнд нийцүүлэх, Иргэний нисэхийн үйлчилгээ үзүүлэгч байгууллагуудын болон агаарын тээвэрлэгч нарын гэрчилгээ, ажилтнуудын үнэмлэх, зэрэглэлийн хүчинтэй хугацааг сунгах үйл ажиллагааг шуурхай зохион байгуулах, боломжтой тохиолдолд дүрмийн зарим шаардлагаас чөлөөлөх судалгаа, санал боловсруулсан.
- Олон улс болон орон нутгийн нислэгээр зорчих зорчигч, түүнд тавигдах халдвар хамгааллын дэглэм, Ковид-19 цар тахлын үед бусад улс орон, орон нутгийн засаг захиргаа агаарын тээврээр зорчих зорчигчийг хэрхэн хүлээн авах, тээвэрлэх горимын талаар судалгаа хийсэн.
- Нислэгийн урсгал төлөвлөлтийн албанаас нислэгийн зөвшөөрөл олгох үйл ажиллагааг хэрхэн зохион байгуулж байгаа талаар тайлбар авч, судалгаа хийсэн.
- Агаарын хөлөгт халуун хоол өгөх, нэрээр дуудаж буулгахгүй байх асуудлаар агаарын тээвэрлэгчидтэй 2021 оны 10 дугаар сарын 15-ны өдөр цахим уулзалтыг зохион байгуулж, тэдгээрийн саналыг авсан. Үүнтэй холбоотойгоор ХХЕГ, МХЕГ-ын төлөөлөлтэй 2021 оны 10 дугаар сарын 25-ны өдөр цахим уулзалтыг зохион байгуулсан бөгөөд агаарын тээвэрлэгчдийн саналыг уламжилсан.

Дээрх төлөвлөгөөний дагуу агаарын тээвэрлэгчид, УОК, хилийн мэргэжлийн хяналтын байгууллага, холбогдох эрүүл мэндийн байгууллагуудтай уялдаа холбоог сайжруулан хамтран ажилласнаар агаарын тээврээр зорчих үйл ажиллагааг хялбарчлах, бүртгэлийн үйл ажиллагаа, ирэх зорчигчид тавигдах эрүүл мэндийн халдвар хамгаалал, хяналтын үйл ажиллагаанд гарч байсан зарим хүндрэл бэрхшээлүүд багассан.

Орон нутгийн нислэгийг сэргээх, дотоодын агаарын тээврийг хөгжүүлэх зорилгоор Сангийн яамнаас санаачилсан Эдийн засгийг дэмжих "Шинэ сэргэлт"-ийн бодлого боловсруулах ажлын хүрээнд богино хугацаанд дундаж давхаргын өсөлтийг хангах, тэгш хүртээмжийг нэмэгдүүлэн, тогтвортой хөгжлийг хангах зорилгын дагуу холбогдох санал, танилцуулгыг боловсруулан ЗТХЯ-ны ИНБХЗГ-т 2021 оны 11 дүгээр сарын 01-ний өдөр цахим хэлбэрээр хүргүүлсэн.

Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 04 дүгээр сарын 15-ны өдрийн "Агаарын тээврийн салбарт авах зарим арга хэмжээний тухай" 137 дугаар тогтоолд заасныг хэрэгжүүлэх зорилгоор 2020 оны 08 дугаар сарын 21-ний өдрийн 01/3866 тоот албан бичиг, Монгол Улсын Сангийн яамны 2021 оны 05 дугаар сарын 21-ний өдрийн 4-2/2778 бичгээр өгсөн чиглэлийн дагуу олон улсын болон орон нутгийн чиглэлд хуваарьт нислэг гүйцэтгэдэг аж ахуйн нэгжийн Иргэний нисэхийн ерөнхий газарт төлөх агаарын навигацийн үйлчилгээний хураамжийн хуримтлагдсан өглөг "Аэро Монголиа" ХХК, "Хүннү Эйр" ХХК, "Изинис Эйрвэйз" ХХК тай тус тус тооцоо нийлэн баталгаажуулан, Иргэний нисэхийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4.3-т "агаарын навигацийн төлбөртэй үйлчилгээтэй холбогдох асуудлыг эрхлэн шийдэх" гэж заасны дагуу ИНЕГ-ын даргын 2021 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн тушаалаар тус агаарын тээвэрлэгчдийг агаарын навигацийн хураамжаас чөлөөлсөн.

ГУРАВ. НИСЭХИЙН АЮУЛГҮЙ АЖИЛЛАГААНЫ БОЛОН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ХЯНАЛТ, ЗОХИЦУУЛАЛТЫН ЧИГЛЭЛЭЭР:

Монгол Улсын иргэний агаарын хөлгийн бүртгэлд агаарын хөлгийг бүртгэх, бүртгэлээс хасах, Иргэний агаарын тээврийн үйл ажиллагаа эрхлэх болон иргэний нисэхийн үйлчилгээний байгууллага, хувь хүн, иргэний нисэхэд ашиглах бүтээгдэхүүнд зөвшөөрөл, гэрчилгээ олгох, түдгэлзүүлэх, хүчинтэй хугацааг сунгах, үйл ажиллагаанд нь тогтмол хяналт тавих, Аюулгүй ажиллагаа, аюулгүй байдлын үзлэг шалгалтыг тогтмол хийж, стандартуудыг мөрдүүлэх үндсэн чиг үүргийг хэрэгжүүлэн ажиллаж байна.

2021 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу энэ оны 12 дугаар сарын 20-ны байдлаар төлөвлөгөөт үзлэг шалгалт 197, төлөвлөгөөт бус 107, баримт бичгийн хяналтын 347 үзлэг шалгалт тус тус гүйцэтгэж, 155 үл нийцэл илрүүлж, 859 байцаагчийн дүгнэлтэд 674 шаардлагыг тусгаж холбогдох байгууллагуудад хүргүүлэн хэрэгжилтэд хяналт тавин ажилласан.

2021 онд нийт 197 төлөвлөгөөт үзлэг шалгалтын гүйцэтгэлийг төрөл ангиллаар нь товч салгаж харуулбал:

- Иргэний нисэхийн зориулалтаар нислэг үйлдэх Монгол Улсад бүртгэлтэй агаарын хөлгүүдийн нислэгт тэнцэх чадварт – 13
- Агаарын хөлгийн Техник үйлчилгээний байгууллага – 6



- Агаарын хөлгийн техник үйлчилгээний байгууллагын - 6
- Агаарын тээвэрлэгч компаниудын агаарын хөлгийн нислэгт тэнцэх чадварын хадгалалт - 24
- Дотоод, гадаадын агаарын тээвэрлэгчид - 70
- Иргэний нисэхийн сургалтын байгууллагууд - 6
- Иргэний нисэхийн аэродром - 3
- Агаарын навигацийн үйлчилгээний байгууллагууд - 32
- Нисэхийн аюулгүй байдлын чиглэлээр – 15 гэх мэт

Аэродром, агаарын навигацийн хяналтын хэлтсийн хувьд 2021 оны 12 дугаар сарын 20-ны байдлаар нийт 23 удаагийн гэрчилгээжүүлэлтийн үзлэг шалгалтыг гүйцэтгэж, Иргэний нисэхийн багц дүрмийн хүрээнд нийт 18 байгууллагад гэрчилгээжүүлэлтийн шалгалт гүйцэтгэсэнээс анхан шатны гэрчилгээжүүлэлтийн үзлэг шалгалт 2, гэрчилгээ сунгалтын 19 үзлэг шалгалт гүйцэтгэсэн. Үүнээс ИНД-139-өөр Чингис хаан ОУНБ-д шинээр ОУНБ-д шинээр гэрчилгээ олголт 1, гэрчилгээний хугацаа сунгасан 13, гэрчилгээг түдгэлзүүлсэн 3 /ИНД-139-өөр Буянт-Ухаа ОУНБ, Баянхонгор НБ, ИНД-174-өөр ХНАА/, гэрчилгээ олгохоос татгалзсан 1 /ИНД-140-өөр ИНҮТ-ийн АБХА/ байгууллага байна.

“Нью Улаанбаатар Интернэйшнл Эйрпорт” ХХК-д 2021 оны 06 дугаар сарын 29-ний өдөр ИНД 139-ийн 139.9(а)-ын дагуу №13 дугаартай Аэродромын анхан шатны гэрчилгээг 6 сарын хугацаатай олгосон. 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдөр хүртэл олгосон бөгөөд өмнө гаргасан дүгнэлтүүдийн шаардлагуудын хэрэгжилтийг шалгах үзлэг шалгалтыг гүйцэтгэж, 2021 оны 12 дугаар сарын 30-ний өдөр №13 дугаартай Аэродромын гэрчилгээг 3 сарын хугацаатай сунгасан.

Үнэмлэх гэрчилгээжүүлэлтийн хэлтсийн хувьд нийт 4 төрлийн /сургалтын байгууллага, агаарын тээвэрлэгч, итгэмжлэгдсэн эмнэлгийн байгууллага/ 10 үзлэг шалгалт хийхээр төлөвлөснөөс гүйцэтгэл 100 хувьтай байна.

Нислэгийн стандарт үйл ажиллагааны хяналтын хэлтсийн хувьд дотоодын болон гадаадын агаарын тээвэрлэгчид нийт 9 төрлийн /перрон, чиглэлийн, үндсэн бааз, төлөөлөгчийн газар гэх мэт/ төлөвлөгөөт үзлэг шалгалтыг хувиарын дагуу хийж тус бүрд нь зөвлөмж, шаардлагыг боловсруулан байцаагчийн дүгнэлт гаргаж холбогдох байгууллагуудад албан бичгээр хүргүүлсэн. Мөн ИНД-91, ИНД-119, ИНД-121, ИНД-135 дүрмүүдийн холбогдох шаардлагуудын хүрээнд 7 агаарын тээвэрлэгчийн 27 нисгэгчийг нислэгт шалгаж, байцаагчийн дүгнэлт гаргасан байна.

НААХЗА-ны хэмжээнд нийт 197 төлөвлөгөөт үзлэг шалгалтыг хийж гүйцэтгэхээр төлөвлөснөөс гүйцэтгэл нь 178 буюу 90,3 хувь байна. Цуцлагдсан хяналт шалгалтын хувьд дэлхий нийтийг хамарсан цар тахал, Изинис Эйрвэйз ХХК В737 маягийн агаарын хөлгөөр ХБННУ-д нойтон түрээсээр нислэг үйлдэж байгаа зэргээс үүдэлтэй байна.

Агаарын хөлгийн гэрчилгээжүүлэлт:

Монгол Улсад 45 агаарын хөлөг бүртгэлтэй байгаагаас 22 агаарын хөлөг нь НТЧ-ын хүчин төгөлдөр гэрчилгээтэй байна.

Нийт 16 “агаарын хөлгийн техник үйлчилгээний байгууллага” (7–дотоод, 9-гадаадын байгууллага) хүчин төгөлдөр гэрчилгээтэй байна.

➤ *Агаарын хөлгийн Нислэгт тэнцэх чадварын гэрчилгээжүүлэлт: 13*

№	Эзэмшигч	Агаарын хөлгийн маяг	Бүртгэлийн дугаар	НТЧ сунгасан огноо	Хүчинтэй хугацаа
Нислэгт тэнцэх чадварын гэрчилгээний хүчинтэй хугацааг сунгасан-9					
1	Хүннү Эйр ХХК	МИ-8АМТ	JU-6601	Хөдөлгүүрт гарсан техникийн дутагдлыг засаагүй тул гэрчилгээний хүчинтэй хугацааг сунгаагүй	
2	Тэнгэрийн Улаач Шинэ ХХК	Cessna-208B	JU-9999	2021.02.03	2022.02.02
3	Скай Жет ХХК	Cessna-208B	JU-7777	2021.03.17	2022.03.16
4	Томас Эйр ХХК	Airtractor AT-602	JU-1918	Сэнсний их засварын ажлыг гүйцэтгээгүй тул гэрчилгээний хүчинтэй хугацааг цуцлагдсан	
5	Монголиан Эйрвэйс ХХК	AS350 B3	JU-6889	Агаарын хөлөг засварт байгаа тул үзлэг шалгалтыг хойшлуулсан	



6	Геосан ХХК	Cessna-208B	JU-9993	2021.05.21	2021.11.19
7	МИАТ ХК	B737-800	JU-1015	2021.05.20	2022.05.20
8	Хүннү Эйр ХХК	ATR72-212A	JU-8801	2021.06.14	2022.06.13
9	Аэро Монголиа ХХК	EMB-145 LR	JU-1802	2021.06.25	2021.06.24
10	МИАТ ХК	B737-800	JU-1088	2021.11.15	2021.11.14
11	Хүннү Эйр ХХК	ERJ190-100	JU-8811	2021.11.08	2021.11.07
12	МИАТ ХК	B767-300ER	JU-1021	2021.11.24	2022.11.23
13	Монголиан Эйрвэйс ХХК	AS350 B3	JU-6888	Агаарын хөлөг засварт байгаа тул үзлэг шалгалтыг цуцлагдсан	

➤ ИНД-21 Агаарын хөлгийн Нислэгт тэнцэх чадварын хадгалалтын үзлэг шалгалт: 24

№	Эзэмшигч	Агаарын хөлгийн маяг	Бүртгэлийн дугаар	Хугацаа
1	Хүннү Эйр ХХК	ATR72-212A	JU-8801	2021.01.22
2	Аэро Монголиа ХХК	EMB-145 LR	JU-1802	2021.02.01
3	МИАТ ХК	B767-300	EI-FGN	Гэрээ дуусаж МУ-д дахиж нисэхгүй тул үзлэг шалгалт цуцлагдсан
4	МИАТ ХК	B737-8	EI-CXV	2021.05.05
5	Хүннү Эйр ХХК	ERJ190-100LR	JU-8811	2021.05.21
6	МИАТ ХК	B737-800	JU-1088	2021.06.10
7	Монголиан Эйрвэйс ХХК	AS 350B3	JU-6888	Агаарын хөлөг засварт байгаа тул цуцлагдсан
8	Түвшинбаяр	Savannah Bingo	JU-3287	2021.06.18
9	Залуу Бүргэд Женерал Авэйшн ХХК	Savannah Bingo	JU-3289	2021.06.18
10	Хүннү Эйр ХХК	Ми-8АМТ	JU-6601	2021.06.23
11	Топ Экстрим Экшин Монголиа ХХК	MTO Sport	JU-9001	2021.07.02
12	Топ Экстрим Экшин Монголиа ХХК	MTO Sport	JU-9002	2021.07.02
13	Топ Экстрим Экшин Монголиа ХХК	Calidus	JU-9003	2021.07.02
14	Gerhard Wackenhut	Cavalon	JU-9005	2021.07.02
15	МИАТ ХК	B737-800	JU-1021	2021.07.26
16	Сэлиэр Авиэйшн Монголиа ХХК	Xenon 4	JU-9009	2021.08.09
17	Аэрохели ХХК	AK1-3	JU-9080	2021.08.09
18	Сатурн Экстрем Монголиа ХХК	AT104-10АТ	JU-7799	2021.08.10
19	Тэнгэрийн Улаагч Шинэ ХХК	Cessna 208B	JU-9999	2021.08.18
20	Скай Жет ХХК	Cessna 208B	JU-7777	2021.09.10
21	Монголиан Эйрвэйс ХХК	AS 350B3	JU-6889	Агаарын хөлөг засварт байгаа тул цуцлагдсан
22	Томас Эйр ХХК	Airtractor	JU-1918	2021.10.01
23	Геосан ХХК	Cessna 208B	JU-9993	2021.11.15
24	МИАТ ХК	B737-800	JU-1015	2021.11.10

➤ ИНД-144 Нисэхийн хангамжийн байгууллага:5

ИНД-144 Нисэхийн хангамжийн байгууллага гэрчилгээжүүлэлт дүрмийн хавсралт S3 ангиллын "Агаарын хөлгийг шатах тослох материалаар хангах үйлчилгээний байгууллага" -ын гэрчилгээний хүчинтэй хугацааг сунгасан 5,



№	Байгууллагын нэр	Гэрчилгээ сунгасан огноо	Хүчинтэй хугацаа
1	Монголиан Авиэшн фуел ХХК	2021.02.03	2022.02.02
2	Магнай Трейд ХХК	2021.03.15	2022.03.14
3	Мэргэван ХХК	2021.05.07	2022.05.07
4	ИНУТ	2021.06.02	2022.06.01
5	ГТҮШХА	2021.06.14	2021.12.13

➤ ИНД-145 Агаарын хөлгийн техник үйлчилгээний байгууллагын гэрчилгээжүүлэлт:6

№	Байгууллагын нэр	Гэрчилгээ сунгасан огноо	Хүчинтэй хугацаа
1	Монголиан Эйрвэйс ХХК	Үзлэг шалгалтаар нийт 9 үл нийцэл болон 1 шаардлага гарсан тул гэрчилгээний хүчинтэй хугацааг сунгаагүй.	
2	Тэнгэрийн Улаач Шинэ ХХК	2021.02.03	2022.02.02
3	Изинис Эйрвэйз ХХК	2021.03.22	2022.03.21
4	Хүннү Эйр ХХК	2021.04.05	2022.04.04
5	Геосан ХХК	2021.05.10	2022.05.09
6	Аэро Монголиа ХХК	2021.10.22	2022.04.21

➤ ИНД-145 Агаарын хөлгийн техник үйлчилгээний байгууллагын хадгалалтын үзлэг шалгалт:7

№	Байгууллагын нэр	Хугацаа
1	Монголиан Эйрвэйс ХХК	2021.11.25
2	Тэнгэрийн Улаач Шинэ ХХК	2021.08.24
3	Изинис Эйрвэйз ХХК	2021.09.22
4	Хүннү Эйр ХХК	2021.10.07
5	Геосан ХХК	2021.11.17
6	Аэро Монголиа ХХК	2021.10.22

➤ Агаарын тээвэрлэгчийн шинэ маягийн агаарын хөлөг

Аэромонголиа ХХК агаарын хөлгийн паркаа шинэчилж, арилжааны нислэгийн үйл ажиллагаандаа А319-112 маягийн агаарын хөлөг ашиглаж эхлэх хүсэлт гаргасантай холбогдуулан ИНЕГ-ын даргын баталсан ажлын хэсэг /НСҮАХХ, НТЧХ, ҮГХ/-ийн удирдамжын дагуу

- Агаарын хөлгийн түрээсийн баримт бичиг
- Агаарын хөлгийн гэрчилгээжүүлэлт
- Агаарын хөлгийн нисэх бүрэлдэхүүн болон агаарын хөлгийн техник үйлчилгээний ажилтнуудын маягийн зэрэглэл
- Компанийн үйл ажиллагааны заавар, журмуудыг хянах
- Сургалт /нисэх бүрэлдэхүүн, инженер техникийн ажилтнууд, бүхээгийн ажилтнууд, нийт ажилтнуудад зааврын өөрчлөлтийн сургалт, бусад/
- Нислэгийн үйл ажиллагаа
- Нислэг төлөвлөлт, нислэг зохицуулалтын үйл ажиллагаа
- Газрын үйл ажиллагаа
- Бүхээгийн үйл ажиллагаа
- Үзүүлэх болон бататгах нислэг

зэрэг чиглэлээр үзлэг шалгалтыг гүйцэтгэсэн. Ажлын хэсгийн нэгдсэн тайлан гаргаж, Үйл ажиллагааны тодорхойлолтод холбогдох өөрчлөлтийг хийсэн.

- Монголиан Эйрвэйс Карго ХХК Fokker-50 маягийн агаарын хөлгөөр арилжааны нислэг /зорчигч тээвэр/-т ашиглаж эхлэх хүсэлт гаргасантай холбогдуулан ИНЕГ-ын даргын үүргийг



түр орлон гүйцэтгэгчийн баталсан ажлын хэсгийн удирдамжын дагуу дараах чиглэлүүдээр үзлэг шалгалтыг гүйцэтгэж, ажлын хэсгийн нэгдсэн тайлан гарсан. Үүнд:

- Агаарын хөлгийн баримт, бичиг
- Эрсдэлийн үнэлгээ, төлөвлөгөө
- Заавар, журам
- Сургалт /нисэх бүрэлдэхүүн, инженер техникийн ажилтнууд, бүхээгийн ажилтнууд, нийт ажилтнуудад зааврын өөрчлөлтийн сургалт, бусад/
- Агаарын хөлгийн нислэгт тэнцэх чадварын хадгалалт
- Нислэгийн төлөвлөлт, нислэгийн хяналт зохицуулалтын үйл ажиллагаа
- Үнэмлэхжүүлэлт

Үзүүлэх нислэг: Үзүүлэх нислэгийг тус компаниас боловсруулж ИНЕГ-аас батласан “Зөвшөөрлийн болон үзүүлэх нислэгийн хөтөлбөр”-ийн дагуу хийж гүйцэтгэсэн. Ажлын хэсгийн нэгдсэн тайлан гаргаж, Үйл ажиллагааны тодорхойлолтод холбогдох өөрчлөлтийг хийсэн.

Агаарын тээвэрлэгч, нислэгийн үйл ажиллагаа эрхлэгч, нисэхийн сургалтын байгууллагын гэрчилгээжүүлэлт:

➤ *Агаарын тээвэрлэгчийн гэрчилгээний хүчинтэй хугацаа сунгалт:*

- Хүннү Эйр ХХК-ийн АТ-018 дугаартай Агаарын тээвэрлэгчийн гэрчилгээний хүчинтэй хугацааг сунгах үзлэг шалгалтыг томилогдсон ажлын хэсэг гүйцэтгэж, байцаагч бүр дүгнэлт гаргасан. Ажлын хэсгийн нэгдсэн тайлан гаргаж, гэрчилгээний хугацааг 5 жилээр сунгаж олгосон. /АТ-018: 2021.11.12-2026.11.11/
- Томас Эйр ХХК-ийн ХАА-03 дугаартай зөвшөөрлийн гэрчилгээний хүчинтэй хугацааг сунгах үзлэг шалгалтыг ажлын хэсгийн байцаагч бүр чиглэл бүрээр гүйцэтгэж, нэгдсэн тайлан гаргаж, гэрчилгээний хүчинтэй хугацааг 3 жилээр сунгаж, Үйл ажиллагааны тодорхойлолтын хамт олгосон. /2021.01.15-2024.01.31/

➤ *Шинээр Агаарын тээвэрлэгчийн гэрчилгээ эзэмших өргөдөл гаргагч:*
ийн нэгдсэн тайлан гаргаж, агаарын тээвэрлэгчийн гэрчилгээ олгосон 2.22-201/
Скай Жет ХХК-иас ИНД-119 “Агаарын тээвэрлэгч гэрчилгээжүүлэлт”, ИНД-125 “Дунд нисэх онгоцны арилжааны нислэгийн үйл ажиллагаа”, ИНД-135 “Нисдэг тэрэг болон жижиг нисэх онгоцны арилжааны нислэгийн үйл ажиллагаа” дүрмүүдээр Агаарын тээвэрлэгчийн гэрчилгээ эзэмших хүсэлт ирүүлсэний дагуу ИКАО-ын үндсэн стандартын дагуу агаарын тээвэрлэгчийг гэрчилгээжүүлэх ажил хийгдсэн.

➤ *Агаарын тээвэрлэгчийн гэрчилгээний хавсралт “Үйл ажиллагааны тодорхойлолт”-нд орсон өөрчлөлтүүд:*

- МИАТ ХК
- Аэромонголиа ХХК
- Хүннү Эйр ХХК
- Изинис Эйрвэйз ХХК
- Монголиан Эйрвейс Карго ХХК
- Монголиан Эйрвэйс ХХК
- Хүннү Эйр ХХК-ийн Хүннү Авиэйшн алба

➤ *Хөдөө аж ахуйн зориулалттай агаарын хөлгийн үйл ажиллагаа, гэрчилгээжүүлэлт /ИНД-137/*

➤ *Гадаадын агаарын тээвэрлэгч байгууллагын гэрчилгээжүүлэлт /ИНД-129/*

Шинээр өргөдөл гаргагч:

БНСУ-ын Air Incheon компани ИНД-129-ийн дагуу Гадаадын агаарын тээвэрлэгчийн гэрчилгээ эзэмших хүсэлт гаргасантай холбогдуулан гэрчилгээжүүлэлтийн үзлэг шалгалтыг цахимаар хийж, FAOC-019 дугаартай гэрчилгээг 5 жилийн хугацаагаар олгосон. /FAOC-019, 2021.10.29-2026.10.29/

Гэрчилгээний хүчинтэй хугацаа сунгалт:



Air Busan компанийн FAOC-012 дугаартай Гадаадын агаарын тээвэрлэгчийн гэрчилгээний хүчинтэй хугацааг сунгах үзлэг шалгалтыг цахимаар гүйцэтгэж, гэрчилгээний хүчинтэй хугацааг 5 жилээр сунгаж олгосон. /FAOC-012, 2021.10.11-2026.10.09/

Angara Airlines компани FAOC-013 дугаартай Гадаадын агаарын тээвэрлэгчийн гэрчилгээний хүчинтэй хугацааг сунгах хүсэлт, өргөдлөө ИНЕГ-т ирүүлээгүй.

Гадаадын агаарын тээвэрлэгч байгууллагын “Үйл ажиллагааны тодорхойлолт”-нд оруулсан өөрчлөлтүүд:

- Asiana Airlines
- Air Busan
- Turkish Airlines

➤ *Иргэний нисэхийн сургалтын байгууллага, гэрчилгээжүүлэлт /ИНД-141/*

Шинээр гэрчилгээ олголт:

- Asian Aviation Training Center: Хүннү Эйр ХХК-иас ирүүлсэн хүсэлтийн дагуу АТР-72 маягийн агаарын хөлгийн нисэх багийн сургалтыг явуулахаар төлөвлөж буй Тайландын вант улсын Банконг хотын “Asian Aviation Training Center” сургалтын байгууллагыг ИНД-141 дүрмийн дагуу гэрчилгээжүүлэх үзлэг шалгалтыг цахимаар гүйцэтгэж, МСАА.141.25 дугаарын гэрчилгээг 5 жилийн хугацаагаар олгосон. /2021.02.26 - 2026.02.28/
- Turkish Airlines Inc: Изинис Эйрвэйз ХХК-иас ирүүлсэн хүсэлтийн дагуу В737-800 маягийн агаарын хөлгүүдийн нисэх багийн сургалтыг явуулахаар төлөвлөж буй БНТУ-ын Истанбул хотын “Turkish Airlines Inc” сургалтын байгууллагыг ИНД-141 дүрмийн дагуу гэрчилгээжүүлэх үзлэг шалгалтыг цахимаар гүйцэтгэж, МСАА.141.28 дугаарын гэрчилгээг 5 жилийн хугацаагаар олгосон. /2021.04.07-2026.04.30/
- Simuflight: Геосан ХХК-иас ирүүлсэн хүсэлтийн дагуу Өмнөд Африкийн Бүгд Найрамдах Улсын "Simuflight" сургалтын байгууллагыг ИНД-141 дүрмийн дагуу гэрчилгээжүүлэх үзлэг шалгалтыг цахимаар гүйцэтгэж, МСАА.АТО.141.30 дугаарын гэрчилгээг 5 жилийн хугацаагаар олгосон. /2021.08.31-2026.08.31/
- CAE Center: "CAE Center" нисэхийн сургалтын байгууллагыг ИНД-141 дүрмийн дагуу гэрчилгээжүүлэх үзлэг шалгалтыг цахимаар гүйцэтгэж, МСАА.АТО.141.31 дугаарын гэрчилгээг 5 жилийн хугацаагаар олгосон. /2021.09.14-2026.08.31/
- Аэрмонголиа ХХК-иас ирүүлсэн хүсэлт, өргөдлийг хянан тус сургалтын байгууллагын Үйл ажиллагааны тодорхойлолтод “CAE STS Ltd. ABU DHABI Aviation Training Center”-г нэмж оруулсан. EMB-145
- Baltic Commercial Aviation Training: Латви улсын “Baltic Commercial Aviation Training” нисэхийн сургалтын байгууллагыг ИНД-141 дүрмийн дагуу гэрчилгээжүүлэх үзлэг шалгалтыг цахимаар гүйцэтгэж, МСАА.АТО.141.32 дугаарын гэрчилгээг 5 жилийн хугацаагаар олгосон. /2021.11.23-2026.11.23/
- SAA, Aeronautical Academy: Бүгд Найрамдах Словени Улсын “SAA, Aeronautical Academy” нисэхийн сургалтын байгууллагыг ИНД-141 дүрмийн дагуу гэрчилгээжүүлэх үзлэг шалгалтыг цахимаар гүйцэтгэж, МСАА.АТО.141.33 дугаарын гэрчилгээг 5 жилийн хугацаагаар олгосон. /2021.12.03-2026.12.03/

Гэрчилгээний хүчинтэй хугацаа сунгалт:

- Boeing US Training and нисэхийн сургалтын байгууллагын МСАА/АТО.141.03 дугаартай гэрчилгээний хүчинтэй хугацааг сунгах үзлэг шалгалтыг цахимаар гүйцэтгэж, 5 жилийн хугацаагаар сунгаж олгосон. /2021.02.02- 2026.02.27/
 - Eastern Airways (UK) LTD нисэхийн сургалтын байгууллагын МСАА.АТО.141.29 дугаартай гэрчилгээний хүчинтэй хугацааг сунгах үзлэг шалгалтыг цахимаар гүйцэтгэж, 5 жилийн хугацаагаар сунгаж олгосон. /2021.05.05- 2026.05.05/
- *Агаарын хөлгийн түрээс*
- Изинис Эйрвэйз ХХК-ийн ХБННУ-ын Arik Air Limeted агаарын тээвэрлэгчидтэй хийсэн нойтон түрээсийн хугацааг 3 удаа сунгаж, Үйл ажиллагааны тодорхойлолтын А10 “Агаарын хөлгийн нойтон түрээс” хэсэгт өөрчлөлт оруулсан. /Түрээсийн хугацаа: 2021.05.31 хүртэл, 2021.11.20 хүртэл, 2022.02.08 хүртэл/
 - Аэрмонголиа ХХК JU-1199 бүртгэлийн дугаартай А319-112 маягийн агаарын хөлгийг Sprite Aviation UK No.1 Limited компаниас 5 жилийн хугацаагаар түрээслэн авч байгаатай



холбогдуулан Үйл ажиллагааны тодорхойлолтын А10 “Агаарын хөлгийн түрээс” хэсэгт нэмэлт өөрчлөлт оруулсан. /Түрээсийн хугацаа: 2021.06-2026.06/

- Монголиан Эйрвэйс ХХК нь Скай Жет ХХК-тай байгуулсан ХАГ-21/23-01 дугаартай хамтын ажиллагааны гэрээний хүрээнд JU-7777 бүртгэлийн дугаартай Cessna 208EX маягийн агаарын хөлгийг түрээслэн нислэгийн үйл ажиллагаандаа ашиглах болсонтой холбогдуулан Үйл ажиллагааны тодорхойлолтын А10 “Агаарын хөлгийн түрээс” хэсэгт нэмэлт өөрчлөлт оруулсан. /Түрээсийн хугацаа: 2021.05.24-2021.09.01/

➤ *Нислэгийн багасгасан босоо зайчлал буюу RVSM зөвшөөрөл*

ИКАО, ДОК-9574-ийн шаардлага болон Ази номхон далайн агаарын навигацын төлөвлөлт, хэрэгжүүлэлтийн ажлын хэсгийн 20/22 дугаар шийдвэрийн дагуу Монгол улс нь тодорхой шаардлага хангасан агаарын хөлгүүдэд Нислэгийн багасгасан босоо зайчлал буюу RVSM агаарын зайд нислэг үйлдэх тусгай зөвшөөрлийг олгож, MAAR буюу Азийн бүсийн хяналтын агентлагт мэдэгдэх үүрэгтэй болно. Үүний дагуу үндэсний агаарын тээврийн компаниудаас ирүүлсэн хүсэлтийг хянаж агаарын хөлгийн үйлдвэрлэгчээс гаргасан баримт бичиг, MEL-д тавигдах болон өдөр хадгалах чадамжийг баталгаажуулсан хэмжилтийн сүүлийн 24 сард амжилттай хийсэн байх ёстой тухай шаардлагуудыг хангасан

-Аэромонголиа ХХК-ийн JU-1199 бүртгэлийн дугаартай А319-112 маягийн агаарын хөлөгт

RVSM агаарын зайд нислэг үйлдэх тусгай зөвшөөрлийг олгож, MAAR-т F-2 маягтын илгээж, албан ёсоор бүртгүүлсэн.

➤ *Minimum equipment list /mel/ батлах*

Агаарын тээвэрлэгч байгууллагуудын нислэгийн үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл болох MEL болон түүнд орох нэмэлт өөрчлөлтийг Нислэгт тэнцэх чадварын хэлтэстэй хамтран 9 удаа батласан.

- МИАТ ХК
-B767-300 маягийн агаарын хөлгийн MEL
- Аэромонголиа ХХК
-А319-112 маягийн агаарын хөлгийн MEL- 2 удаа
- Хүннү Эйр ХХК
-ATR 72-212А маягийн агаарын хөлгийн MEL
- Изинис Эйрвэйз ХХК
-B737-700 маягийн агаарын хөлгийн MEL 2 удаа
- Монголиан Эйрвэйз Карго ХХК
-Фоккер 50 маягийн агаарын хөлөг
- Монголиан Эйрвэйс ХХК
-AS350В3/Н125 маягийн нисдэг тэрэгний MEL
-Robinson маягийн нисдэг тэрэгний MEL

➤ *Аюултай ачаа*

1. МИАТ ХК-ийн “Аюултай ачаа тээвэрлэх заавар”-ын англи, монгол хэл дээрхи өөрчлөлтийг ИНД-92, ИКАО-н Док-9284 “Аюултай ачааг агаараар аюулгүй тээвэрлэх техникийн зааварчилгаа”, ИНЕГ-аас олгогдсон зөвшөөрөл болон компанийн үйл ажиллагаанд хэрхэн нийцэж байгааг хянан баталгаажуулсан. Мөн коронавируст халдварын эсрэг вакциныг их хэмжээний хуурай мөс ашиглан агаараар тээвэрлэх шаардлагын хүрээнд боловсруулж ирүүлсэн "Вакцин тээвэрлэх журам"-ыг хянаж, ИНЕГ-аас хүлээн зөвшөөрсөн. Тус компани вакцин тээвэрлэх үйл ажиллагаанд эрсдлийн үнэлгээ хийж, сургалтын төлөвлөгөө гаргасан. Батлагдсан заавар, журмын хүрээнд сургалтын төлөвлөгөөний дагуу компаниас зохион байгуулсан сургалтанд зайнаас хяналт тавьсан.



2. Хүннү Эйр ХХК коронавируст халдварын эсрэг вакциныг их хэмжээний хуурай мөс ашиглан агаараар тээвэрлэх шаардлагын хүрээнд боловсруулж ирүүлсэн "Вакцин тээвэрлэх журам"-ыг хянаж, ИНЕГ-аас хүлээн зөвшөөрсөн. Тус компани вакцин тээвэрлэх үйл ажиллагаандаа эрсдлийн үнэлгээ хийж, сургалтын төлөвлөгөө гаргасан. Батлагдсан заавар, журмын хүрээнд сургалтын төлөвлөгөөний дагуу компаниас зохион байгуулсан сургалтанд зайнаас хяналт тавьсан. Мөн Агаарын тээвэрлэгчийн гэрчилгээний хавсралт Үйл ажиллагааны тодорхойлолтод өөрчлөлт оруулсан. Хүннү Эйр ХХК-иас Монгол улсын Сонгуулийн ерөнхий хорооноос Ерөнхийлөгчийн сонгуулийн ажилд ашиглах 11 ширхэг, 300 кг ачааг Дэли-Улаанбаатар чиглэлийн захиалгат нислэгээр тээвэрлэх хүсэлтийг хянан 2021 оны 02 сарын 18-ны өдрийн 03/г/09 тоот /гадаад/ албан бичгээр аюултай ачаа тээвэрлэх нэг удаагийн зөвшөөрөл олгосон.

➤ *Онцгой үүргийн нислэг*

Иргэний нисэхийн ерөнхий газрын дарга, Төрийн тусгай хамгаалалтын газрын даргын хамтарсан 2004 оны 403/356 тоот тушаалаар батлагдсан "Иргэний агаарын хөлгийн онцгой үүргийн нислэгийн журам"-ын дагуу Монгол улсын төрийн 3-н өндөрлөг Ерөнхийлөгч, Улсын их хурлын дарга, Ерөнхий сайд болон бусад гадаад, дотоодын өндөр албан тушаалтнууд /Монгол улсын Ерөнхийлөгчийн сонгуульд нэр дэвшигчид/-ын орон нутгийн болон олон улсын нийт 19 тусгай үүргийн нислэгт хяналт тавьж ажилласан.

Агаарын навигацийн үйлчилгээний байгууллагуудын гэрчилгээжүүлэлт:

➤ *ИНД 171-ийн хүрээнд Агаарын навигацийн техник үйлчилгээний байгууллагын гэрчилгээ сунгалт – 1:*

- ИНД-171-ийн дагуу Холбоо, навигаци, ажиглалтын албанаас 2021 оны 9 дүгээр сарын 15-ны 10-22/524 тоотоор ирүүлсэн гэрчилгээ сунгуулах өргөдөл маягт, албан хүсэлтийн дагуу НААХЗА-ны даргын баталсан удирдамжийн хүрээнд гэрчилгээ сунгалтын аудит шалгалтыг холбогдох чиглэлүүдээр гүйцэтгэсэн ажлын хэсгийн 01/21 дугаартай тайланг үндэслэн Холбоо, навигаци, ажиглалтын албанд олгогдсон 171-01 дугаартай гэрчилгээний хугацааг 2023 оны 02 дугаар сарын 16-ны өдөр хүртэл сунгасан.

➤ *ИНД172-ийн хүрээнд Нислэгийн хөдөлгөөний үйлчилгээний байгууллагын гэрчилгээ сунгалт - 1:*

- ИНД 172-ийн дагуу Нислэгийн хөдөлгөөний үйлчилгээний албанаас 2021 оны 11 дугаар сарын 08-ны өдрийн 10-20/328 тоот албан бичгээр ирүүлсэн гэрчилгээ сунгуулах өргөдөл маягт, албан хүсэлтийн дагуу НААХЗА-ны даргын баталсан удирдамжийн хүрээнд гэрчилгээ сунгалтын аудит шалгалтыг холбогдох чиглэлүүдээр гүйцэтгэсэн ажлын хэсгийн 03/21 дугаартай тайланг үндэслэн Нислэгийн хөдөлгөөний үйлчилгээний албанд олгогдсон 172-01 дугаартай гэрчилгээний хугацааг 2024 оны 12 дугаар сарын 10-ны өдөр хүртэл 3 жилээр сунгасан.

➤ *ИНД 173-ийн хүрээнд Нислэгийн журмын үйлчилгээний байгууллагын гэрчилгээ сунгалт - 1:*

- Нислэгийн журам боловсруулалтын албаны 173-01 дугаартай гэрчилгээний хугацааг ИНД-173-ийн дагуу үзлэг шалгалт хийсэн байцаагч нарын 157/21 дугаартай дүгнэлтийг үндэслэн 2022 оны 02 дугаар сарын 01-ний өдөр хүртэл сунгаж олгосон.

➤ *ИНД174-ийн хүрээнд НЦУУБ-ын гэрчилгээ сунгалт- 1, түдгэлзүүлсэн-1 :*

- Холбоо навигаци, ажиглалтын албанаас 2021 оны 01 дүгээр сарын 13-ны өдрийн 10-22/54 тоот албан бичгээр ирүүлсэн ИНД174-ийн хүрээнд олгогдсон №174-02 дугаартай гэрчилгээний хугацааг сунгуулах өргөдөл хүсэлтийг үндэслэн Холбоо, навигаци, ажиглалтын албанд гэрчилгээжүүлэлтийн үзлэг шалгалтыг хийж байцаагчийн 110/21 дугаартай дүгнэлтийг үндэслэн 174-02 дугаартай гэрчилгээг хүчингүй болгосон.
- ИНД-174-ийн дагуу Нисэхийн цаг уурын төвд олгогдсон 174-01 дугаартай гэрчилгээний хугацааг гэрчилгээжүүлэлтийн үзлэг шалгалт гүйцэтгэсэн байцаагчийн 129/21 дугаартай дүгнэлтийг үндэслэн 2021 оны 3 дугаар сарын 05-ны өдөр хүртэл сунгаж олгосон.

**Аэродромын гэрчилгээжүүлэлт:**

- *Шинээр гэрчилгээ олгосон - 1:*
- “Нью Улаанбаатар Интернэйшнл Эйрпорт” ХХК-ийн 2021 оны 03 дугаар сарын 17-ны өдрийн SMO/128 тоот албан бичиг, 2021 оны 05 дугаар сарын 28-ны өдрийн SMO/354 тоот албан бичиг, САА 24139/01 маягтаар ирүүлсэн өргөдлийн дагуу Төв аймгийн Сэргэлэн сумын Хөшгийн хөндий дэх “Чингис хаан” олон улсын нисэх буудалд Иргэний нисэхийн дүрэм 139-ийн хүрээнд аэродромын гэрчилгээжүүлэлтийн үзлэг шалгалтыг гүйцэтгэх, өмнө гаргасан дүгнэлтүүдийн шаардлагуудын хэрэгжилтийг шалгах НААХЗА-ны даргын баталсан удирдамжийн дагуу томилогдсон багийн бүрэлдэхүүн газар дээр нь холбогдох чиглэлүүдээр үзлэг шалгалтыг гүйцэтгэж, байцаагчийн дүгнэлтүүд гарсан. ААНХХ-ийн аэродромын байцаагчийн 371/21 дугаартай дүгнэлтийг үндэслэн “Нью Улаанбаатар Интернэйшнл Эйрпорт” ХХК-нд ИНД 139-ийн 139.9(а)-ын дагуу №13 дугаартай Аэродромын анхан шатны гэрчилгээг 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдөр хүртэл 6 сараар олгосон.
- Гэрчилгээний хугацаа сунгасан – 8:
 1. Ховд аймаг дахь Ховд нисэх буудлын Аэродромын гэрчилгээний хугацааг 2021 оны 9 сарын 30-ны өдрийг дуустал 6 сараар, 2022 оны 9 сарын 30-ны өдөр хүртэл 6 сараар 2 удаа сунгасан.
 2. Өмнөговь аймгийн Ханбогд сумын нутагт орших Ханбумбат нисэх буудлын Аэродромын гэрчилгээний хугацааг 2023 оны 4 сарын 30-ны өдөр хүртэл 2 жилээр сунгасан.
 3. Хөвсгөл аймаг дахь Мөрөн нисэх буудлын Аэродромын гэрчилгээний хугацааг 2021 оны 11 сарын 31-ны өдөр хүртэл 6 сараар, 2023 оны 11 сарын 30-ны өдөр хүртэл 2 удаа сунгасан.
 4. Увс аймаг дахь Дэглий цагаан нисэх буудлын Аэродромын гэрчилгээг 2022 оны 7 сарын 01-ний өдөр хүртэл 1 жилээр сунгасан.
 5. Баян-Өлгий аймаг дахь Өлгийн нисэх буудлын Аэродромын гэрчилгээний хугацааг 2022 оны 4 сарын 30-ны өдөр хүртэл 1 жилээр сунгасан.
 6. Говь-Алтай аймаг дахь Алтай нисэх буудлын Аэродромын гэрчилгээний хугацааг 2023 оны 4 дүгээр сарын 01-ний өдөр хүртэл 1 жил 6 сараар сунгасан.
 7. Завхан аймаг дахь Доной нисэх буудлын Аэродромын гэрчилгээний хугацааг 2023 оны 8 дугаар сарын 31-ний өдөр хүртэл 2 жилээр сунгасан.
 8. Өмнөговь аймаг дахь Гурвансайхан нисэх буудлын Аэродромын гэрчилгээг 2023 оны 4 дүгээр сарын 01-ний өдөр хүртэл 1 жил 6 сараар тус тус сунгасан.
- Гэрчилгээ түдгэлзүүлсэн – 2:
 1. Буянт-Ухаа ОУНБ-ын Аэродромын гэрчилгээг 2021 оны 7 дугаар сарын 07-ний өдрөөс байцаагчийн 419/21 дугаартай дүгнэлтийг үндэслэн түдгэлзүүлсэн.
 2. Баянхонгор нисэх буудлын Аэродромын гэрчилгээг 2021.07.30-ны өдрөөс байцаагчийн 490/21 дугаартай дүгнэлтийг үндэслэн түдгэлзүүлсэн.

Нисэхийн аюулгүй байдлын үйлчилгээний байгууллагын гэрчилгээжүүлэлт:

- Гэрчилгээ сунгалт – 2:
 1. Иргэний нисэхийн үндэсний төвөөс 2020 оны 10-1/1456 тоот албан бичгээр 140-20 дугаартай гэрчилгээний хүчинтэй хугацааг сунгуулах хүсэлт болон САА 24140/01 өргөдлийг ирүүлсэн ба Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 209 дүгээр тогтоолын дагуу гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт хэсэгчилсэн байдлаар шилжүүлсэнтэй холбогдуулан Иргэний нисэхийн үндэсний төвөөс ИНД-140 дүрмийг хэрэгжүүлэхээр авч байгаа арга хэмжээ, үйл ажиллагаанд үзлэг шалгалтыг зайнаас гүйцэтгэж, байцаагчийн 03/21 дугаартай дүгнэлтийг үндэслэн 140-20 дугаартай гэрчилгээний хугацааг 2021 оны 7 дугаар 10-ны өдөр хүртэл сунгасан.
 2. ИНҮТ-өөс 2021 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн 10-1/679 тоотоор ирүүлсэн 140-20 дугаартай гэрчилгээний хугацааг сунгуулах хүсэлт, өргөдөл, удирдах албан тушаалтнуудын Тохирох зөв хүний мэдүүлэг болон холбогдох нэмэлт, өөрчлөлтийг оруулсан “Аюулгүйн хамгаалалтын ерөнхий заавар”-ыг үндэслэн тус байгууллагын “Буянт-Ухаа” Олон улсын нисэх буудал болон “Чингис хаан” Олон улсын нисэх буудалд үзлэг шалгалтыг гүйцэтгэж, 140-20 дугаартай гэрчилгээний хугацааг 2022 оны 7 дугаар сарын 10-ны өдөр хүртэл нэг жилээр сунгасан.



- Гэрчилгээжүүлэх үзлэг шалгалт – 1:

Иргэний нисэхийн үндэсний төвөөс 2021 оны 10-1/309 тоот албан бичгээр ирүүлсэн Аюулгүй байдал, хамгаалалтын албыг ИНД-140-ийн дагуу гэрчилгээжүүлэх хүсэлт, Аюулгүй байдал, хамгаалалтын албаны өргөдөл, Тохирох зөв хүний мэдүүлэг, Тохирох зөв хүний асуулга болон “Аюулгүйн хамгаалалтын ерөнхий заавар”-ыг үндэслэн тус албаны ИНД-140 дүрмийг хэрэгжүүлэхээр авч байгаа арга хэмжээ, үйл ажиллагаанд гэрчилгээжүүлэлтийн үзлэг шалгалтыг 2021 оны 4 сарын 12-ноос 20-ны өдрүүдэд зайнаас гүйцэтгэж, байцаагчийн 234/21 дугаартай дүгнэлтээр ИНД-140-ийн холбогдох шаардлагуудыг хангаагүй тул уг дүрмээр гэрчилгээжүүлэх боломжгүй гэж үзсэн.

Нисгэгч, нислэгийн хөдөлгөөний удирдагч, агаарын хөлгийн техник үйлчилгээний ажилтнуудын үнэмлэх, гэрчилгээжүүлэлт:

Иргэний нисэхийн тухай Монгол Улсын хуулийн 391.1 дүгээр зүйлд заасны дагуу дараах Иргэний нисэхийн дүрмүүдээр мэргэжлийн үнэмлэх, зэрэглэл олгох, сунгах, түдгэлзүүлэх, хүчингүй болгох үүргийг хэрэгжүүлсэн. Үүнд:

- ИНД-61-ийн дагуу хийсэн ажлууд:

Нисгэгчийн үнэмлэх эзэмшигч нийт-145

Төлөвлөсөн - 101

Агаарын тээвэрлэгчийн нисгэгчийн үнэмлэх эзэмшигч – 65

Зэрэглэлийн хүчинтэй хугацааг сунгасан-62

Коммерийн нисгэгчийн үнэмлэх эзэмшигч – 80

Зэрэглэлийн хүчинтэй хугацааг сунгасан – 58

Шинээр маягийн зэрэглэл олгосон, сунгасан – 3

Шинээр коммерийн нисгэгчийн үнэмлэх олгосон - 10

Гадаадын нисгэгчийн үнэмлэхийг хүлээн зөвшөөрсөн гэрчилгээ /Validation/-17

- ИНД-65-ийн дагуу хийсэн ажлууд:

Нислэгийн хөдөлгөөний үйлчилгээний ажилтны үнэмлэх эзэмшигч- 217

Төлөвлөсөн - 173

Нислэгийн удирдагчийн үнэмлэх эзэмшигч - 152

Зэрэглэлийн хүчинтэй хугацааг – 132 сунгасан

Шинээр зэрэглэл олгосон- 7

Нислэгийн мэдээллийн ажилтны үнэмлэх эзэмшигч - 65

Зэрэглэлийн хүчинтэй хугацааг - 45 сунгасан

- ИНД-66-ийн дагуу хийсэн ажлууд:

Агаарын хөлгийн техник үйлчилгээний ажилтны үнэмлэх эзэмшигч-147

Төлөвлөсөн - 81

Маягийн зэрэглэлийн хүчинтэй хугацааг сунгасан-83

Маягийн зэрэглэл шинээр олгосон- 6

ТҮБГ- 9

Гадаад үнэмлэхийг хөрвүүлсэн-2

ИНД-67-ийн дагуу хийсэн ажлууд:

Эрүүл мэндийн гэрчилгээ эзэмшигч- 293

Төлөвлөсөн - 216

-Эрүүл мэндийн I ангиллын гэрчилгээг – 126

-Эрүүл мэндийн II ангиллын гэрчилгээг – 2

-Эрүүл мэндийн III ангиллын гэрчилгээг – 165 Нийт - 300

Мөн ИНД-141-ийн дагуу гэрчилгээжих хүсэлтээ ирүүлсэн дараах сургалтын байгууллагуудын гэрчилгээтэй холбоотой ажлыг зохион байгуулсан. Үүнд:

1. Монголын нисэхийн академи-д Гэрчилгээжүүлэх үзлэг шалгалтыг гүйцэтгэж Нисэхийн сургалтын байгууллагын гэрчилгээг шинээр олгосон./МСАА.АТО.141.27 - 2023.04.02/
2. МИАТ ХК-ийн нисэхийн сургалтын төвд гэрчилгээ сунгах үзлэг шалгалтыг гүйцэтгэж 2026.03.19-ний өдрийг хүртэл иргэний нисэхийн сургалтын байгууллагын гэрчилгээг олгосон.



3. “Нисэхийн сургалтын төв” нисэхийн сургалтын байгууллагын гэрчилгээжүүлэх үзлэг шалгалтыг гүйцэтгэж 2023 оны 05 дугаар сарын 01-ний өдрийг хүртэл иргэний нисэхийн сургалтын байгууллагын гэрчилгээг олгосон.
4. “Ханseo” сургалтын төвийн нисэхийн сургалтын байгууллагын төлөвлөгөөт үзлэг шалгалтыг 2021 оны 10 дугаар сарын 29-ний өдрөөс 11 дүгээр сарын 01-ний өдрүүдэд хийж гүйцэтгэсэн.
5. “Залуу бүргэд женерал авиэйшн” нисэхийн сургалтын байгууллагын гэрчилгээжүүлэх үзлэг шалгалтыг 2021 оны 05 дугаар сарын 24-ний өдрөөс 05 дугаар сарын 28-ний өдрүүдэд хийхээр төлөвлөж үзлэг шалгалтыг эхлүүлсэн боловч шалгуулагч байгууллага Ковид-19 цар тахлын улмаас шалгуулах боломжгүй болсон шалгуулагч байгууллагын хүсэлтээр тодорхойгүй хугацаагаар хойшлуулсан.

Төлөвлөгөөт бус үзлэг шалгалтын чиглэлээр:

Төлөвлөгөөт бус үзлэг шалгалт нь үндсэндээ дараах 4 тохиолдолд хийгддэг бөгөөд тайлант хугацаанд НААХЗА-ны ААНХХ-42, НСҮАХХ-15, НТЧХ-33 нийт 90 үзлэг шалгалтыг гүйцэтгэж байцаагчийн дүгнэлт боловсруулан холбогдох байгууллагуудад хүргэсэн байна.

- Шинээр гэрчилгээ, зөвшөөрөл олгох үзлэг, шалгалт,
- Гарсан зөрчил, дутагдлын дагуу хийгдэх үзлэг, шалгалт,
- Хуваарьт бус гэнэтийн үзлэг, шалгалт,
- ИНДүрэмд өөрчлөлт орсон эсхүл байгууллагын үйл ажиллагаанд нэмэлт өөрчлөлт орсонтой холбогдуулан хийгдэх үзлэг, шалгалт

Дээрх 90 төлөвлөгөөт бус үзлэг шалгалтаас нислэгийн аюулгүй ажиллагаанд ноцтой нөхцөл байдал үүссэн, тухайн нөхцөл байдал үүсэх, давтан гарахаас урьдчилан сэргийлсэн зарим чухал үзлэг шалгалтын ажлыг дурдвал:

- 2020.12.27-ны өдөр “Монголиан Эйрвэйс” ХХК-ийн JU-6888 бүртгэлийн дугаартай AS 350B3 маягийн нисдэг тэрэг хуваарьт нислэг үйлдэх үед “FUEL FILT” дохиолол ажиллаж, хээрийн буултыг “Баян Уул”-ийн районд үйлдсэн зөрчилд хяналт тавьж ажилласан.
- 2020.12.05-ны өдөр “Хүннү Эйр” ХХК-ийн JU-6601 бүртгэлийн дугаартай Ми-8АМТ маягийн нисдэг тэрэг УБ-Ононгийн халуун рашаан-УБ чиглэлд нисэх үед зүүн болон баруун хөдөлгүүрийн эргэлт зөрсөн шалтгаанаар эргэж буусан техникийн дутагдлын дагуу хяналт тавьж ажилласан.
- 2021.01.27-ны өдөр “Аэро Монголиа” ХХК-ийн ЕМВ-145 маягийн JU-1802 бүртгэлийн дугаартай агаарын хөлгийн баруун далавчны гадна талын “Flar Track”-нд гарсан гэмтэл гарсантай холбогдуулан үзлэг шалгалтыг хийж гүйцэтгэсэн.
- Зам, тээврийн хөгжлийн сайдын 2021 оны 2 дугаар сарын 18-ны өдрийн А/23 тоот тушаалын 1.7 дугаар заалтын дагуу агаарын тээвэрлэгчийн гэрчилгээ эзэмшигчийн агаарын хөлгүүдийн техникийн бэлэн байдал, нислэгийн аюулгүй ажиллагааны шаардлагыг хангуулах үзлэг шалгалтыг дараах агаарын хөлгүүдэд хийж гүйцэтгэсэн. Үүнд:
 - “МИАТ” ХК-ийн В767-300 маягийн JU-1021 бүртгэлийн дугаартай агаарын хөлөгт
 - “МИАТ” ХК-ийн В737-800 маягийн JU-1015, JU-1088 бүртгэлийн дугаартай агаарын хөлөгт
 - “Хүннү Эйр” ХХК-ийн ERJ190 маягийн JU-8811 бүртгэлийн дугаартай агаарын хөлөгт
 - “Хүннү Эйр” ХХК-ийн АTR72-212А маягийн JU-8801 бүртгэлийн дугаартай агаарын хөлөгт
 - “Аэро Монголиа” ХХК-ийн ЕМВ145 маягийн JU-1802 бүртгэлийн дугаартай агаарын хөлөгт
 - “Изинис Эйрвэйз” ХХК-ийн В737-800 маягийн EI-ULN бүртгэлийн дугаартай агаарын хөлөгт
 - “Монголиан Эйрвэйс Карго” ХХК-ийн В737-300 маягийн JU-8888 бүртгэлийн дугаартай агаарын хөлөгт
 - “Тэнгэрийн Улаач Шинэ” ХХК-ийн Cessna 208В маягийн JU-9999 бүртгэлийн дугаартай агаарын хөлөгт
 - “Монголиан Эйрвэйс” ХХК-ийн AS350 В3 маягийн JU-6880, JU-6888 бүртгэлийн дугаартай нисдэг тэргүүдэд



- “МИАТ” ХК-ийн В737-800 маягийн EI-CXV бүртгэлтэй агаарын хөлөгт гүйцэтгэсэн техник үйлчилгээ болон хөдөлгүүрүүдэд хийсэн засварын ажлыг шалгасан үзлэг шалгалтыг хийж гүйцэтгэсэн.
- “Томас Эйр” ХХК-ийн 19-26УНХ улсын дугаартай агаарын хөлгийг шатахуунаар цэнэглэх сумлагч машинд үзлэг шалгалтыг хийж гүйцэтгэсэн.
- “Монголиан Эйрвэйс” ХХК-ийн 25-92УНТ болон 23-10 УБН улсын дугаартай авто машинуудад агаарын хөлгийг шатахуунаар цэнэглэх үйл ажиллагаа явуулах үзлэг шалгалтыг хийж гүйцэтгэсэн.
- “Аэро Монголиа” ХХК-ийн А319-112 маягийн JU-1199 бүртгэлийн дугаартай агаарын хөлгийн шалгах нислэгүүдэд хяналт тавьж ажилласан.
- Газрын тусгай үйлчилгээ, шатахуун хангалтын албаны агаарын хөлгийн шатахуун тээврийн автоцистернуудэд үзлэг шалгалт хийж гүйцэтгэсэн.
- Геосан ХХК-ийн JU-9993 бүртгэлийн дугаартай С208 маягийн агаарын хөлгөөр 2021 оны 01 сарын 15-ны өдөр сургалт дадлагын нислэг үйлдэхээр төлөвлөж “Буянт-Ухаа” НБ-ын зогсоолд түлшээр цэнэглэж, өөрийн зогсоол руу тулгуурыг авалгүй явгалсан байдалд шалгалт хийсэн.
- Дэлхий даяар үүссэн цар тахлын улмаас олон улсын нислэг зогссон, энэ хугацаанд нисгэгч нарын ур чадвар хадгалалтын дадлага сургалтын талаарх асуудлыг 2020 оны 9 дүгээр сарын 11 өдрийн хурлаар ИНЕГ-ын Аюулгүй Ажиллагааны зөвлөлөөр хэлэлцэж гаргасан 07/20 дугаартай шийдвэрийн биелэлтийг шалгасан.
- Тус компани Ф-50 маягийн гаарын хөлгийг нислэгийн үйл ажиллагаанд ашиглахтай холбогдуулан Үзүүлэх болон батлах нислэгийн хөтөлбөрийн дагуу үзлэг шалгалт хийсэн.
- ИНЕГ-ын Аюулгүй байдлын зөвлөлийн 16-р хурлаас өгсөн үүрэг даалгаврын дагуу тус компанийн арилжааны нислэгийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа EC130T2 (JU-5555), EC145 (JU-6666), AS350B3 (JU-6880) маягийн нисдэг тэрэгнүүдэд перроны шалгах хуудсын дагуу үзлэг шалгалтыг хийж, илэрсэн үл нийцлийг арилгах хэмжээ авч ажиллах тухай албан бичиг хүргүүлсэн.
- “Скай Жет” ХХК-ийн 15-69УАК улсын дугаартай авто машин агаарын хөлгийг шатахуунаар цэнэглэх үйл ажиллагаа явуулах үзлэг шалгалтыг хийж гүйцэтгэсэн.
- “МИАТ” ХК-ийн В737-800 маягийн EI-CXV бүртгэлийн дугаартай агаарын хөлгийн “гарах агаарын температурын нөөц багассан, огцом өөрчлөгдөхөд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ”-ний үзлэг шалгалтыг хийж гүйцэтгэсэн.
- “Залуу Бүргэд Женерал Авиэйшн” ХХК-ийн агаарын хөлгийн техник үйлчилгээтэй холбоотой шаардлагуудыг хангаж байгаа эсэх үзлэг шалгалтыг хийж гүйцэтгэсэн.
- “Изинис Эйрвэйз” ХХК-ийн В737-700 маягийн EI-GVW бүртгэлтэй агаарын хөлгийн их биеийг ус сумлагчаар гэмтээсэн дутагдалд үзлэг шалгалтыг хийж гүйцэтгэсэн.
- “Монголиан Эйрвэйс” ХХК-ийн ажилтан С.Эрхэс-Эрдэнийн “Техник үйлчилгээний удирдлага болон төлөвлөлт хариуцсан удирдах ажилтан”-аар томилох чиглэсэн үзлэг шалгалтыг хийж гүйцэтгэсэн.
- “Монголиан Эйрвейс Карго” ХХК-ийн ашиглаж байгаа Fokker F27 Mk0502 маягийн JU-1050 бүртгэлийн дугаартай агаарын хөлгийн нисгэгчийн бүхээгийн цонх сольсон чиглэсэн үзлэг шалгалтыг хийж гүйцэтгэсэн.
- “МИАТ” ХК-ийн В767 маягийн JU-1021 бүртгэлийн дугаартай агаарын хөлөгт “WQAR” систем суурилуулах үзлэг шалгалтыг хийж гүйцэтгэсэн.
- Иргэний нисэхийн үндэсний төвийн шинэ нисэх буудлын шатахуун хангамжийн албаны агаарын хөлгийг шатахуунаар цэнэглэх R7000-J800 маркын 11-84УН улсын дугаартай сумлагч автомашинд үзлэг шалгалтыг хийж гүйцэтгэсэн.
- “МИАТ” ХК-ийн В737-800 маягийн EI-CXV бүртгэлийн дугаартай агаарын хөлгийн ерөнхий зориулалтын ачаа тээвэрлэх бэлтгэл ажил нь тус агаарын хөлгийн бүртгэгч Ирланд улсын Иргэний нисэхийн байгууллагаас ирүүлсэн зөвшөөрлийн дагуу хийж гүйцэтгэсэн эсэх үзлэг шалгалтыг хийж гүйцэтгэсэн.
- “МИАТ” ХК-ийн нислэг үйлдвэрлэлийн үйл ажиллагаа нь ИНД-43 болон ИНД-39 дүрмийн холбогдох шаардлагуудыг хангаж байгаа бөгөөд 202107/10 дугаартай Аюулгүй ажиллагааны



зөвлөмжийн хэрэгжилтийн дагуу холбогдох арга хэмжээг авч ажилласан эсэх үзлэг шалгалтыг хийж гүйцэтгэсэн.

- Иргэний нисэхийн үндэсний төвийн шинэ нисэх буудлын шатахуун хангамжийн алба-ны ТС-1 болон РТ төрлийн агаарын хөлгийн шатахуунуудыг хольж хүлээн авах түүгээр агаарын хөлөг сумлаж болох эсэх талаар үзлэг шалгалтыг хийж гүйцэтгэсэн.
- “МИАТ” ХК-ийн РТ төрлийн агаарын хөлгийн шатахуун нь Монгол Улсад мөрдөгдөж байгаа стандарт шаардлагыг хангаж байгаа мөн агаарын хөлгийн сумалгаанд ашиглаж болох эсэх талаар үзлэг шалгалтыг хийж гүйцэтгэсэн.
- “Мэргэван” ХХК-ийн агаарын хөлөгт ТС-1 төрлийн түлшний оронд РТ төрлийн түлш хэрэглэх санал болон ЧХОУНБ-Д, агаарын хөлөгт шууд шатахуун хангамжийн үйлчилгээ үзүүлж болох эсэх талаар үзлэг шалгалтыг хийж гүйцэтгэсэн.
- “Аэро Монголиа” ХХК-ийн ЕМВ-145 маягийн JU-1800 бүртгэлийн дугаартай агаарын хөлгийн хоёрдугаар үндсэн дугуй хагарч, далавчны эд ангиудыг гэмтээсэн байдалд үзлэг шалгалтыг гүйцэтгэж 2021 оны 11 дүгээр сарын 24-ны өдөр НСҮАХХ болон ААНХХ хамтран тайлан гаргаж танилцуулсан.

ДӨРӨВ. БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТИЙГ ХАНГУУЛАХ ЧИГЛЭЛЭЭР:

Агаарын навигацийн үйлчилгээний чиглэлээр:

Иргэний нисэхийн багц дүрмүүд ИНД171, ИНД172, ИНД173, ИНД175 шинэчлэгдэн батлагдсантай холбогдуулан харьяа салбар нэгжүүдийн үйл ажиллагааг шинэчилсэн дүрэмд нийцүүлэх, үйл ажиллагааны зааврыг шинэчлэх, үйл ажиллагаанд гарч болзошгүй хүндрэлтэй нөхцөл байдлыг тодорхойлох зорилгоор ажлын төлөвлөгөө боловсруулж, батлуулан, хэрэгжилтийг бүрэн хангаж ажилласан.

Дээрх ажлын хүрээнд 2021 оны 3 дугаар сарын 24-ний өдөр “Иргэний нисэхийн агаарын навигацийн үйлчилгээний чиглэлээрх шинэчлэгдэн боловсруулагдсан дүрмийн хэрэгжилт” сэдэвт цахим хурал зохион байгуулсан. Шинэчлэн батлагдсан ИНД-171 дүрмийн шаардлагын дагуу ерөнхий зааврыг 2021 оны 9 дүгээр сарын 01-ний өдөр, шинэчлэн батлагдсан ИНД-172 дүрмийн шаардлагын дагуу ерөнхий зааврыг 2021 оны 11 дүгээр сарын 19-ний өдөр, шинэчлэн батлагдсан ИНД-173 дүрмийн шаардлагын дагуу ерөнхий зааврыг 2021 оны 9 дүгээр сарын 28-ны өдөр, шинэчлэн батлагдсан ИНД-175 дүрмийн шаардлагын дагуу ерөнхий зааврыг 2021 оны 9 дүгээр сарын 14-ний өдөр тус тус боловсруулан батлуулж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

“Буянт-Ухаа” Олон улсын нисэх буудлын ил харааны ойртолтын налуу заагч \PAPI\ системийн гэрлүүдийн тусгалын өнцөг зөрүүтэй зааж байгаа талаар “Аэромонголиа” ХХК-аас албан бичгээр ирүүлсэн мэдээллийн дагуу “Буянт-Ухаа” Олон улсын нисэх буудлын ил харааны ойртолтын налуу заагч системийг нислэгээр шалган баталгаажуулах ажлын үнэлгээний хороог Иргэний нисэхийн үндэсний төвийн даргын 2021 оны 01 дүгээр сарын 22-ны өдрийн А/13 дугаар тушаалаар байгуулж, 2021 оны 01 дүгээр сарын 20-ны өдөр SMF PAPI багажаар хэмжилт тохируулга хийсэн. Улмаар буулт, суулт хийж буй нислэгүүдээр шалгуулахад дахин үл тохирол гараагүй тул 2021 оны 02 дугаар сарын 02-ны өдрийн 09:00 цагаас нислэгт ашиглаж эхэлсэн. Ингэснээр “Буянт-Ухаа” Олон улсын нисэх буудлын ил харааны ойртолтын налуу заагч системийг нислэгээр шалган баталгаажуулах ажлыг зогсоож, SMF PAPI багажаар баталгаажуулан хэвийн үйл ажиллагаанд оруулсан.

Зөөврийн зориулалт бүхий шалгалтын нислэгийн цогц төхөөрөмж нийлүүлэх ИНЕГ/ШХО/ТББ/Б-01/19-211/19 гэрээт ажлын хүрээнд нийлүүлэгдсэн хэмжих хэрэгслийг хүлээн авах, үйл ажиллагаанд ашиглах төлөвлөгөө гарган, холбоо, навигаци, ажиглалтын тоног төхөөрөмжүүдийг нислэгээр шалган баталгаажуулах зориулалт бүхий АНУ-ын Airfield Technology компанид үйлдвэрлэгдсэн АТ-940 загварын хэмжилт, тохируулгын цогц системийг шинээр үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд нэвтрүүлэх туршилт, шалгалтыг 2021 оны 3-4 дүгээр сард амжилттай хийж гүйцэтгэсэн.

Иргэний нисэхийн үндэсний төвийн даргын 2021 оны А/10 дугаар тушаалаар нисэхийн суурин холбооны AFTN системийн сервер, хэрэглэгчийн терминал болон холболтын тоног төхөөрөмжийг шинэчлэх №ИНЕГ/ХО/ТББ/Б-34/20 95/20 дугаартай гэрээний дагуу нийлүүлэгдсэн тоног төхөөрөмжүүдийг 2021 оны 01-02 дугаар сард үндсэн серверүүд, холболтын тоног төхөөрөмжүүдийг шинэчлэн суурилуулсан. Ингэснээр нисэхийн суурин холбооны AFTN системийн найдвартай ажиллагааг дээшлүүлж ажилласан.

Иргэний нисэхийн үндэсний төвийн даргын 2021 оны 02 дугаар сарын 05-ны өдрийн А/22 дугаар тушаалаар байгуулагдсан "Нислэгийн хөдөлгөөний удирдлагын автоматжуулалтын системийн программ хангамжийн үйлчилгээ, сайжруулалт хийх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах" үнэлгээний хорооны шийдвэрийн дагуу үйлдвэрлэгч Испани Улсын “Индра” компанитай шууд гэрээ байгуулж, гэрээний дагуу үйлчилгээ хийгдэж, нислэгийн хөдөлгөөний удирдлагын үйлчилгээний Aircon-2100



автоматжуулалтын системийн програм хангамж, системийн найдвартай хэвийн ажиллагааг хангаж байна.

Монгол Улсын Засгийн газрын 2015 оны 3 дугаар сарын 09-ний өдрийн “Иргэний нисэхийн салбарт хэрэглэх хэмжлийн нэгжийн тухай” 90 дүгээр тогтоолын дагуу иргэний нисэхэд Олон улсын (SI) системийн бус хэмжлийн фүүтийн нэгжийг нислэгийн хөдөлгөөний удирдлагын үйлчилгээнд хэрэгжүүлэх ажлын хүрээнд 2021 оны 5 дугаар сарын 28-ны өдөр нислэгийн хөдөлгөөний удирдлагын AIRCON2100 автомат системийг метрээс фүүтийн хэмжлийн нэгжид шилжүүлэх ажлын үнийн саналыг авах хүсэлтийг үйлдвэрлэгч “Индра” компанид хүргүүлсний дагуу тус компаниас уг ажлыг хэрэгжүүлэхэд AIRCON2100 системийн програм хангамжид шинэчлэл хийх шаардлагатайг мэдэгдсэн бөгөөд тусдаа гэрээ байгуулахад 45,000 EUR, АСА гэрээний хүрээнд 27,000 EUR үнийн саналыг ирүүлсэн. Тус зардлыг 2022 оны AIRCON 2100 автомат системийн АСА гэрээнд нэмэлтээр оруулж, 2022 оны төсвийн төсөлд саналыг тусгасан.

Агаарын зай, нислэгийн хөдөлгөөний үйлчилгээний чиглэлээр:

Монгол Улсын агаарын зайд ADS-B системийг нислэгийн хөдөлгөөний үйлчилгээний ажиглалтын зайчлалд бүрэн ашиглаж эхлэхтэй холбогдуулан цар тахлын үед ажиллах төлөвлөгөө, Нислэг техникийн осол зөрчлийг шинжлэн шалгах албанаас өгсөн 9 зөвлөмж, Нислэгийн аюулгүй ажиллагаа, хяналт зохицуулалтын албаны байцаагчийн 7 дүгнэлтүүдийг залруулах арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулан хэрэгжилтийг хангаж ажилласны үр дүнд 01/2021 AIRAC Supplement бүтээгдэхүүнээр зарласны дагуу 2021 оны 11 дүгээр сарын 04-ний өдрийн 0000 UTC цагаас эхлэн Монгол Улсын агаарын зайн нислэгийн хөдөлгөөний ажиглалтын удирдлагын зайчлалд автомат хамааралтай ажиглалтын ADS-B системийг бүрэн ашиглаж эхэлсэн.

Ази, Номхон далайн бүсийн орнуудын нэгдсэн VPN сүлжээнд холбогдоход шаардлагатай мэдээллийн аюулгүй байдал болон холболтын тоног төхөөрөмжийн худалдан авах ИНЕГ/ХО/ТББ/Б-22/20-150/20 дугаартай тендер зарлаж, 2021 оны 3 дугаар сарын 16-ны өдөр “АЙ ТИ ЗОН” ХХК-ийн нийлүүлсэн тоног төхөөрөмжийн ажиллагааг шалгаж хүлээн авч тоног төхөөрөмжийн бэлэн байдлыг хангасан. Монгол Улсын агаарын навигацийн үйлчилгээний нэгдсэн VPN сүлжээг зохион байгуулах төслийг боловсруулж, худалдан авах ажиллагааг амжилттай зохион байгуулсан.

Олон улсын иргэний нисэхийн байгууллагаас агаарын замуудад ашиглаж байгаа 5 үсгийн нэршлийн код (5LNC)-ын давхардлыг арилгаж нэршлийн кодууд ба агаарын замуудыг тодорхойлогч нэгдсэн систем (ICARD)-д бүртгүүлэх ажлыг эрчимжүүлэх шаардлагыг гишүүн улсуудад мэдэгдсэний дагуу Ази-Номхон далайн бүсийн төвтэй хамтран Монгол Улсын агаарын зайд иргэний нисэхийн зориулалтаар ашиглагддаг тодорхой цэгүүдийн нэршлийг өөрчлөх, нэгдсэн системд шинээр үүсгэх болон бусад бүсийн төвүүдээс шилжүүлэн авч шинэчлэн тогтоохоор тусгасан.

“Монгол Улсын агаарын замын шинэчилсэн зохион байгуулалт” сэдэвт цахим хэлэлцүүлгийг 2021 оны 10 дугаар сарын 21-ний өдөр зохион байгуулсан. Монгол Улсын агаарын зайд SULOK-MORIT-SULOK, INTIK-NIGOR-INTIK, POLHO-NOPUS-POLHO чиглэлд үзүүлэлтэд тулгуурласан навигаци бүхий PBN (Performance Based Navigation) Y001, Y002, Y003 шинэ агаарын зам тогтоож, тус замуудыг үйл ажиллагаанд ашиглахад нислэгийн хөдөлгөөний удирдлагын үйлчилгээнд үүсэх хүндрэл, аюулыг тодорхойлсон эрсдэлийн үнэлгээг боловсруулсан.

Мөн Монгол Улсын агаарын зайд INTIK-NIGOR-INTIK, POLHO-NOPUS-POLHO чиглэлд шинээр тогтоосон үзүүлэлтэд тулгуурласан агаарын замын аюулгүй ажиллагааны эрсдэлийн үнэлгээг боловсруулсан. Агаарын замын сегмент тус бүрийн чиглэл, соронзон хазайлт, сегментийн урт, аюулгүй нам өндөр зэргийг тооцоолох, төсөл зураг боловсруулж, 2021 оны 12 дугаар сарын 07-ны өдрийн 01/2142 тоот албан бичгээр ЗТХЯ-нд хүргүүлсэн.

ОУИНБ-ын Ази-Номхон далайн бүсийн товчоо руу ЭХАТ үйл ажиллагаа явуулах чадавхийн үзүүлэлтийг (SAR Capability Matrix) харуулсан мэдээллийн хүснэгтийг бөглөн ЭХАТ үйл ажиллагааны чадавхийн 41 үзүүлэлт бүхий (SAR PERFORMANCE INDICATORS) мэдээллийг боловсруулан 2021 оны 03 дугаар сарын 31-ний өдөр илгээсэн. Энэхүү материал нь ОУИНБ-ын Ази-Номхон далайн бүсийн товчооны ЭХАТ үйл ажиллагааны ажлын бүлэг (APSA/WG/6)-ийн 6-р хуралдааны материалд албан ёсоор орсон.

Шинэчлэгдсэн GANP Doc-9750-ийн хүрээнд боловсруулагдсан ASBU /Aviation System Block Upgrade/-г агаарын навигацийн үйлчилгээний чиглэлийн хүрээнд судалж суурь түвшнийг тодорхойлон, “Иргэний нисэхийн үндэсний төвийн 2030 он хүртэл хэрэгжүүлэх мастер төлөвлөгөөний төсөл”-д тусгасан. Мөн ASBU-ийн FRT0 B1-B2 хэсгүүдийг 2021-2030 онуудад үе шаттайгаар хэрэгжүүлэхээр төлөвлөсөн бөгөөд Нисэхийн системийн хэсэгчилсэн сайжруулалт (ASBU)-ын ажлын хүрээнд агаарын зайн менежментийг хэрэгжүүлэх ерөнхий төлөвлөгөөг тодорхойлсон. Олон улсын иргэний нисэхийн байгууллага болон Евроконтролоос санаачлан Европын бүсийн орнуудад 2009 оноос үе шаттайгаар хэрэгжүүлж байгаа “Departure to destination free



route concept”-ийг судалж, Монгол Улсын агаарын замуудыг уян хатан (flexible), чөлөөт байдал (free route)-аар ашиглах ерөнхий төлөвлөгөөг боловсруулан батлуулсан.

Бээжин ACC-ийн хүсэлтээр Бээжин хот болон Улаанбаатар хот хоорондын мэдээлэл солилцох ATFM Daily Plan (ADP) төлөвлөгөөг гаргасан бөгөөд ADP-ийн мэдээлэл солилцооны ажлын хамтарсан төлөвлөгөөг боловсруулсан. Энэхүү төлөвлөгөөний дагуу бүс нутгийн хэмжээнд мэдээлэл дамжуулах бие даасан сүлжээ (CRV)-г ашиглаж эхлэх хүртэлх хугацаанд 2021 оны 12 дугаар сарын 01-ний өдрөөс цахим хэлбэрээр өгөгдөл солилцохоор тусгасан.

Улаанбаатар – Бээжин нислэгийн хөдөлгөөн удирдлагын төв хооронд 2021 оны 6 дугаар сараас хамтарсан AIDC техникийн туршилт шалгалтыг эхлүүлэн 9 дүгээр сард амжилттай хийж гүйцэтгэлээ. Цаашид нислэгийн хөдөлгөөний удирдлагын бүсийн төвүүд хооронд AIDC-г үйл ажиллагаанд бүрэн оруулах, Ланжоу нислэгийн хөдөлгөөний удирдлагын төвтэй техникийн туршилт шалгалтыг эхлүүлэн ажиллаж байна.

Холбоо, навигаци, ажиглалтын үйлчилгээний чиглэлээр:

Агаарын навигацийн нэгдсэн VPN сүлжээ сансрын холбооны дамжуулах байгууламж, оптик дамжуулах байгууламжийн шинэчлэлтийн ажлын хүрээнд сансрын холбооны дамжуулах 27 байгууламжийг IP технологид шилжүүлэх, шилэн кабелийн VPN сүлжээг 15 байгууламжид үүсгэх техникийн шийдлийг боловсруулан худалдан авах ажиллагаа амжилттай болж гэрээ байгуулагдсан бөгөөд 2022 онд ажлыг бүрэн хэрэгжүүлэхээр ажиллаж байна.

Морин-Уул дахь цаг уурын радиолокаторын байранд суурилагдсан 2 сувгийн агаар газрын радио станцыг шинэчлэн суурилуулж үйл ажиллагаанд ашиглаж эхэллээ.

Сектор зохион байгуулалттай холбоотой шинээр зохион байгуулагдсан “БАЯН” секторын ажлын байрыг НХУ-ний автоматжуулалтын системд холбож туршин, үйл ажиллагаанд ашиглахад бэлэн болгосон.

“Чингис хаан” Олон улсын нисэх буудал ашиглалтад орсонтой холбоотой MLAT тооцоот ажиглалтын системийн транспондерийн төхөөрөмжийг “Чингис хаан” Олон улсын нисэх буудлын газрын үйлчилгээний 36 автомашинд суурилуулсан. Мөн нислэгийн ярианы бичлэгийн системийг өргөтгөх ажлыг амжилттай хийж гүйцэтгэсэн.

Холбоо, навигаци, ажиглалтын алба Чанарын менежментийн тогтолцооны MNS ISO 9001:2016 стандартын тохирлын гэрчилгээг 3 жилээр сунгуулсан.

Агаарын навигацийн үйлчилгээний тоног төхөөрөмжийн бэлэн байдал 2021 онд 99.83%-ын үзүүлэлттэй ажилласан. Агаарын навигацийн үйлчилгээний тоног төхөөрөмж, системүүдийн техник үйлчилгээ 2021 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн байдлаар холбооны үйлчилгээний чиглэлээр 595 буюу 96.1%, навигацийн үйлчилгээний чиглэлээр 88 буюу 86.6%, ажиглалтын үйлчилгээний чиглэлээр 61 буюу 95.3%, цахилгаан хангалтын үйлчилгээний чиглэлээр 270 буюу 96%, нийт дүнгээр 93.5%-ийн гүйцэтгэлтэй ажиллаж байна.

Агаарын навигацийн үйлчилгээний тоног төхөөрөмжийн 942 гэмтэл дутагдлын эрсдэлийг үнэлж, үүнээс 21 саатал, дутагдлыг шалгаж дүгнэн, зөвлөмж боловсруулж ажилласан.

Нисэхийн мэдээллийн үйлчилгээний чиглэлээр:

Нисэхийн мэдээллийн үйлчилгээний албаны Чанарын менежментийн тогтолцооны MNS ISO 9001:2016 стандартын тохирлын гэрчилгээг 3 жилээр сунгуулсан. 2021 онд дараах бүтээгдэхүүнүүдийг боловсруулан тараасан. Үүнд:

- AIRAC AIP AMDT 01/21-08/21, AIRAC AMDT 01/22-9ш
- AIP AMDT 01/21-08/-8ш
- AIP SUP01/21-02/-2ш
- AIC C 01/21-02/-2ш

Дээрх бүтээгдэхүүнүүдээр ШУА-ийн Одон орон геофизикийн хүрээлэнгээс хүлээж авсан 2020 оны соронзон хазайлтын өнцгийн утгын мэдээллийг зарлан мэдээлэх ажлын хүрээнд “Чингис хаан” Олон улсын нисэх буудал болон “Буянт-Ухаа” Олон улсын нисэх буудал, Арвэйхээр, Алтай, Булган, Булган сум, Чойбалсан, Гурвансайхан, Хатгал, Мөрөн, Тосонцэнгэл, Дэглий цагаан, Баянхонгор, Доной, Ховд, Мандалговь, Өлгий, Ханбумбат, Ховд НБ-ын соронзон хазайлтын мэдээллийг зарлан мэдээлсэн.

Өндрийн мэдээллийг EGM-08-р илэрхийлж, зарлах ажлын хүрээнд AIP-ын бүтээгдэхүүнүүдээр “Буянт-Ухаа” Олон улсын нисэх буудал-ын Бүс2-ын саадын мэдээллийг шинэчлэн, “Чингис хаан” Олон улсын нисэх буудал-ын мэдээлэлд жижиг засварууд оруулан зарлаж, Гурвансайхан нисэх буудлын ХБЗ-ын даацын мэдээлэл, Ховд болон Дэглий цагаан нисэх буудлын явгалах замын, Өлгий нисэх буудлын аэродромын саадын, Арвайхээр, Алтай, Булган, Булган сум, Чойбалсан, Гурвансайхан, Хатгал, Мөрөн, Тосонцэнгэл, Дэглийцагаан НБ-ын аэродромын саадын, Өлгий



аэродромын хяналтын цэгийн байрлал, Баянхонгор, Булган, Доной, Ховд, Мандалговь аэродромын саадууд, Баянхонгор, Өлгийн нисэх буудлын перрон, ЯЗ-ын мэдээллийг, Арвайхээр аэродромын саадын мэдээлэл, “Чингис хаан” Олон улсын нисэх буудлын Ангар, апро, саадын мэдээллийг, Ханбумбат аэродромын саадын мэдээллийг тус тус боловсруулан зарлан мэдээлсэн.

2021 оны 11 дүгээр сарын 25-ны байдлаар олон улсын 1934 нислэгт, орон нутгийн 3245 нислэгийн төлөвлөгөө, түүний хөөрөлт, буултын ATS мэдээнүүдийг боловсруулсан. А серийн 983, С серийн 364 NOTAM, 5 SNOWTAM зарласан, олон улсын чиглэлийн 1136 нислэгт НӨМТ, орон нутгийн чиглэлд 1813 НӨМТ-г, Аэронавигацийн шуурхай мэдээ 1889-г боловсруулж ажиллалаа. Мөн олон улсаас 330794 NOTAM хүлээн авч үүнээс чухал ач холбогдолтой 610 NOTAM-г 2D, 3D хэлбэрээр харуулан хэрэглэгчдийг нисэхийн мэдээгээр ханган ажилласан.

AIP-аар нийт 153 зураг, Хяналттайгаар нийт 169 зураг боловсруулсан ба Дэлхийн нислэгийн зураг – ICAO 1:1000000 (11 хуваалга зураг) Нислэгийн зураг – ICAO 1:500000 (34 хуваалга зураг) боловсруулсан.

SNOWTAM 2020 шинэ форматын бүтээгдэхүүн боловсруулах, хүлээн авах, тараан дамжуулах үйл ажиллагаа бүхий AIS System програм хангамжийг хөгжүүлж, баталгаажуулан 2021 оны 11 дүгээр сарын 04-ний өдрөөс үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд нэвтрүүлсэн бөгөөд үүнтэй холбогдуулан Rawdata програмд SNOWTAM-ийн шинэ форматын түүхий өгөгдөл хүлээн авч, удирдах модулиудыг өөрчлөн хөгжүүлсэн.

НМУ-ний автомат систем (eAIS)-ийн тогтмол өгөгдлийн санд 17 улсын 56 бүтээгдэхүүний 2500 өгөгдөл мэдээллийг шинэчлэн оруулсан.

“Буянт-Ухаа” Олон улсын нисэх буудалд 2021 оны 4 дүгээр сарын 25-ны өдөр хийгдсэн цахилгаан хангамжийн техник үйлчилгээнээс шалтгаалан үүссэн НМУ-ний автомат системийн тоног төхөөрөмжийн гэмтэл саатлын шалтгааныг програм хангамж нийлүүлэгч байгууллага (Avitech)-уудтай хамтран тодорхойлж, засварлан, холбогдох өгөгдөл мэдээллийг 2020 оны 7 дугаар сарын архиваар нөхөн сэргээлгэсэн.

Нислэгийн журам, шалгалтын нислэгийн чиглэлээр:

Өмнөговь аймгийн “Ханбумбат” нисэх буудалд зориулан зохиосон ZMKB RNAV/GNSS/ STAR, SID нисэн ирэх болон нисэн гарах нийт 12 журам нислэгийн журамд нислэгийн өмнөх баталгаажуулалт хийсэн.

Монгол Улсын доод агаарын зайн 27 сегментийн нийт 10 агаарын замын аюулгүй нам өндрүүдийн тооцооллыг хянасан.

“Чингис хаан” Олон улсын нисэх буудлын ХБ311 талын BUGAN чиглэлд VOR/DME болон үзүүлэлтэд тулгуурласан навигаци ашиглан хэрэглэлээр нисэн гарах нислэгийн журмууд болон BUGAN чиглэлээс нисэн ирэх нислэгийн журмуудын зохиолтын үйл явцуудыг хийж гүйцэтгэн, Нисэхийн мэдээллийн эмхтгэлээр 2021 оны 6 дугаар сарын 17-ны өдөр хүчин төгөлдөр болсон AIRAC AIP AMDT 03/21-ээр зарлан мэдээлэгдсэн.

Хөвсгөл аймгийн “Мөрөн”, Увс аймгийн “Дэглий Цагаан”, Ховд аймгийн “Ховд”, Өвөрхангай аймгийн “Арвайхээр” нисэх буудлуудын нислэгийн журмуудын хиймэл саадуудыг бататгасан.

2021 онд хийгдэх шалгалтын нислэг, фотометрийн хэмжлийн төлөвлөгөөний дагуу дараах нисэх буудлуудад суурилагдсан Ил харааны нарийвчлалтай ойртолтын налуу заагч системийн (PAPI) ээлжит хавар, намрын хэмжилт баталгаажуулалтыг хийж гүйцэтгэсэн. Үүнд:

- “Буянт-Ухаа” Олон улсын нисэх буудал
- Чойбалсан нисэх буудал
- Арвайхээр нисэх буудал
- Алтай нисэх буудал
- Ховд нисэх буудал
- Гурвансайхан нисэх буудал
- Мөрөн нисэх буудал
- Дэглий цагаан нисэх буудал
- Ханбумбат нисэх буудал
- “Чингис хаан” Олон улсын нисэх буудал

“Чингис Хаан” Олон улсын нисэх буудлын Хэрэглэлээр буулт үйлдэх систем, зай хэмжих төхөөрөмж (ILS/DME)-ийн ээлжит шалгалтын нислэгийг 13 цаг 30 минутын нислэгийн блок цагт, бүх чиглэлтэй хэт өндөр давтамжийн радио дохиологч, зай хэмжих төхөөрөмж (DVOR/DME)-ийн ээлжит шалгалтын нислэгийг 4 цаг 27 минутын блок цагт 2021 оны 4 дүгээр сарын 02-ны өдрөөс 05-ны өдрүүдэд хийж гүйцэтгэсэн.

“Чингис хаан” олон улсын нисэх буудлын CONV. SID RWY-29 BUGAN 1A нисэн гарах хэрэглэлийн нислэгийн журмын нислэгээр шалган баталгаажуулах шалгалтын нислэгийг 1 цагийн блок цагт 2021 оны 10 дугаар сарын 27-ны өдөр хийж гүйцэтгэсэн.



“Буянт-Ухаа” Олон улсын нисэх буудалд хэрэглэлээр буулт үйлдэх систем ILS-420, суултын системийн зай хэмжигч төхөөрөмж DME-415, “Чингис хаан” Олон улсын нисэх буудлын хэрэглэлээр буулт үйлдэх систем NORMARC 7000B, суултын системийн зай хэмжигч төхөөрөмж DME-LDB-103LP, бүх чиглэлтэй хэт өндөр давтамжийн радио дохиологч VRB-53D, зай хэмжигч DME-LDB-103HP төхөөрөмжүүдэд шалгалтын нислэгийг 2021 оны 3 дугаар сарын 11-ний өдрөөс 15-ны өдрүүдэд 11 цаг 30 минутын блок цагт хийж гүйцэтгэсэн.

АНУ-ын Олате хотод байрлах Airfield Technology Inc. компаниас 2021 оны 10 дугаар сарын 04-ний өдрөөс 15-ны өдрүүдэд зохион байгуулсан АТ-940 тоног төхөөрөмжийн үйлдвэрлэлийн сургалтад 5 ажилтныг хамруулсан.

“Тавантолгой” нисэх буудлаас аэродром орчимд өндрийн саад үүсгэх магадлалтай гэсэн цахилгаан шонгуудын мэдээллийг хүлээн авч Олон улсын иргэний нисэхийн байгууллагын Чикагогийн конвенцийн Хавсралт 14-д заасан шаардлагын дагуу тус аэродромын саадыг хязгаарлах гадаргуу (Тоноглолгүй хөөрч буух зурвас код 4-өөр тооцоолсон)-г үүсгэж, тооцоолол хийж Иргэний нисэхийн ерөнхий газрын Нисэхийн аюулгүй ажиллагааны хяналт, зохицуулалтын албаны Аэродром агаарын навигацийн хяналтын хэлтэст 2021 оны 02 дугаар сарын 03-ны өдрийн 10-7/137 тоот албан бичгээр хүргүүлсэн.

Нислэгийн урсгал төлөвлөлтийн чиглэлээр:

Монгол Улсын агаарын зайд 2021 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн байдлаар нийт 71454 нислэг гүйцэтгэгдсэн байна. Үүнд: Олон улсын өнгөрөлтийн нислэг - 64791, Олон улсын буулт, хөөрөлт- 2255, Орон нутгийн нислэг - 4408 байна.

Дээрх үзүүлэлтийг өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад Олон улсын өнгөрөлтийн нислэг - 5.3%-иар, орон нутгийн нислэг- 19.5% -иар тус тус буурсан, олон улсын буулт, хөөрөлт- 34.6%-иар өссөн дүнтэй байна.

2021 оны нийт нислэгийн төлөвлөлт гүйцэтгэлийн мэдээ /2021.12.15-ны байдлаар/

№	Нислэгийн төрөл	Төлөвлөлт	Гүйцэтгэл	Биелэлт		Нислэгт эзлэх %
				тоогоор	хувиар	хувиар
1	Олон улсын өнгөрөлт	330913	64791	-266122	19.6%	90.7%
2	Олон улсын хөөрөлт, буулт	6139	2255	-3884	36.7%	3.1%
3	Орон нутгийн хөөрөлт, буулт	6872	4408	-2464	64.1%	6.2%
Нийт нислэгийн дүн:		343924	71454	-272470	20.8%	100%

2020, 2021 оны 01 дүгээр сарын 01-ээс 12 дугаар сарын 15-ны нийт нислэгийн гүйцэтгэлийн харьцуулалт:

№	Нислэгийн төрөл	Нислэгийн тоо		+өсөлт, -бууралт	
		2020.I-XII.06	2021.I-XII.06	тоогоор	хувиар
1	Олон улсын өнгөрөлт	68402	64791	-3954	-5.3
2	Олон улсын буулт, хөөрөлт	1675	2255	510	34.6
3	Орон нутгийн хөөрөлт, буулт	5479	4408	-1147	-19.5
Нийт нислэгийн дүн:		75556	71454	71454	-5.4

Нисэх буудлуудын үйлчилгээний чиглэлээр:

Нисэх буудлуудын бодлогын хэрэгжилт, төлөвлөлтийн чиглэлээр тайлант хугацаанд дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн. Үүнд:

Иргэний нисэхийн ерөнхий газар болон Иргэний нисэхийн үндэсний төв, түүний салбар нэгжийн 2021-2022 оны өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангах ажлын хэсгийг ИНҮТ-ийн даргын 2021 оны А/251 дүгээр тушаалаар байгуулсан. 2021-2022 оны өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангах арга хэмжээний



төлөвлөгөөг батлуулж, хэрэгжилтийг ханган ажилласан. 2021 оны 12 дугаар 01-ний өдрийн байдлаар төлөвлөгөөний хэрэгжилт 100%.

ИНҮТ-ийн даргын 2021 оны А/332 дугаар тушаалаар хавар-зуны ашиглалтаас намар-өвлийн ашиглалтад шилжин ажиллах үйл ажиллагааны бэлэн байдал, өвөлжилтийн бэлтгэл ажлын үзлэг шалгалтыг орон нутгийн нисэх буудлууд болон төвийн салбар нэгжүүдэд 2021 оны 9 дүгээр сарын 13-ны өдрөөс 10 дугаар сарын 26-ны өдрүүдэд зохион байгуулж, нислэг үйлдвэрлэлийн бэлэн байдлыг хангасан.

Монгол Улсын Засгийн газрын 2007 оны 175 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Иргэний нисэхийн аюулгүй байдлын үндэсний хөтөлбөр”-ийг Монголын Улсын Засгийн газрын 2021 оны 5 дугаар сарын 12-ны өдрийн 136 дугаар тогтоолоор “Иргэний нисэхийн аюулгүй байдлын журам” болгон батлуулсан. Мөн Иргэний нисэхийн аюулгүй байдлын Зөвлөлийн 2021 оны 01 дүгээр хурал /16 дахь удаагийн/-ыг 2021 оны 8 дугаар сарын 17-ны өдөр цахимаар зохион байгуулж, зөвлөлийн 2021 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилт, “Буянт-Ухаа” Олон улсын нисэх буудлын нислэг үйлдвэрлэлийн үйл ажиллагааг “Чингис хаан” Олон улсын нисэх буудалд нүүлгэн шилжүүлсэн ажлын тайлан, Олон улсын иргэний нисэхийн байгууллагаас хийгдэх USAP-CMA аудит шалгалтын асуудлыг тус тус хэлэлцүүлэн, холбогдох шийдвэрүүдийг гаргуулсан. Иргэний нисэхийн аюулгүй байдлын зөвлөлийн 2021 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилт 92%-тай дүгнэгдсэн.

Монгол Улсын Засгийн газрын 2010 оны 289 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан “Агаарын тээврийг хялбаршуулах үндэсний хөтөлбөр”-ийг Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 5 дугаар сарын 12-ны өдрийн 137 дугаар тогтоолоор “Агаарын тээврийг хялбаршуулах журам” болгон батлуулсан.

Агаарын тээврийг хялбаршуулах Зөвлөлийн 2021 оны 1 дүгээр хурал /8 дахь удаагийн хурал/-ыг 2021 оны 8 дугаар сарын 17-ны өдөр цахимаар зохион байгуулж, 2021 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилт, Олон улсын иргэний нисэхийн байгууллагаас хийгдэх USAP-CMA аудит шалгалтын асуудлуудыг тус тус хэлэлцүүлэн, холбогдох шийдвэрүүдийг гаргуулсан. Мөн Агаарын тээврийг хялбаршуулах Зөвлөлийн дэргэдэх Нарийн бичгийн даргын ажлын албаны хурлыг 2021 оны 3 дугаар сарын 09, 23, 9 дүгээр сарын 10, 11 дүгээр сарын 15-ны өдрүүдэд 4 удаа тус тус зохион байгуулсан. Агаарын тээврийг хялбаршуулах зөвлөлийн 2021 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилт 92,5%-тай дүгнэгдсэн.

Зам, тээврийн хөгжлийн сайдын 2016 оны 3 дугаар сарын 02-ны өдрийн 48 дугаар тушаалаар баталсан “Агаарын хөлөг шувуу, мал, амьтантай мөргөлдөх аюулаас сэргийлэх хөтөлбөр”-ийн хэрэгжилт 2021 оны жилийн эцсийн байдлаар 96.1%, хөтөлбөрийн ерөнхий хэрэгжилт /2016-2021/ 97.3%-тай дүгнэгдсэн.

Агаарын хөлөг шувуу, мал, амьтантай мөргөлдөх аюулаас сэргийлэх зөвлөлийн хурлыг 2021 оны 9 дүгээр сарын 15-ны өдөр зохион байгуулж, 2021 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилт, хөтөлбөрийн ерөнхий хэрэгжилт /2016-2021/-ийг тус тус хэлэлцүүлэн, холбогдох шийдвэрүүдийг гаргуулсан. Мөн агаарын хөлөг шувуу, мал, амьтантай мөргөлдөх аюулаас сэргийлэх зөвлөлийн дэргэдэх Нарийн бичгийн даргын ажлын албаны хурлыг 2021 оны 5 дугаар сарын 31-ний өдөр цахимаар зохион байгуулсан.

“Нисэх буудал дахь агаарын хөлгийн шатахууны агуулах, гидрант системийн үйл ажиллагаа болон чанарын хяналтад тавигдах шаардлага” стандартыг 2021 оны 10 дугаар сарын 28-ны өдрийн Стандарт, хэмжил зүйн газрын Иргэний нисэхийн стандартчиллын техникийн хорооны хурлаар хэлэлцүүлж, батлуулсан.

“Аэродром орчимд агаарын хөлгийг шувуу, мал амьтантай мөргөлдөх аюулаас сэргийлэх” стандартыг 2021 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн Стандарт, хэмжил зүйн газрын Иргэний нисэхийн стандартчиллын техникийн хорооны хурлаар хэлэлцүүлж, батлуулсан.

Мөн “Агаарын хөлгийн мөстөлт арилгах, хамгаалах ажиллагааны заавар”-ыг Олон улсын SAE AS стандартын дагуу боловсруулан, 2021 оны 3 дугаар сарын 02-ны өдөр ИНҮТ-ийн даргаар батлуулж, НААХЗА-аар хүлээн зөвшөөрүүлсэн.

Засгийн газрын 2019 оны “Олон улсын нисэх буудлуудын нэрийг өөрчлөх, тэдгээрийн ашиглалтын талаар авах арга хэмжээний тухай” 455 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд ИНЕГ-ын даргын 2021 оны 5 дугаар сарын 27-ны өдрийн А/61 дугаар тушаалаар байгуулагдсан “Буянт-Ухаа” Олон улсын нисэх буудлыг нүүлгэн шилжүүлэх ажлыг зохион байгуулах удирдлагын төв нь 2021 оны 6 дугаар сарын 02-ны өдрөөс 7 дугаар сарын 04-ний өдрүүдэд нүүлгэн шилжүүлэх ажлыг амжилттай зохион байгуулсан.

Мөн “Буянт-Ухаа” Олон улсын нисэх буудлын цаашдын ашиглалтын төлөвлөгөөг Иргэний нисэхийн ерөнхий газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгчээр 2021 оны 9 дүгээр сарын 28-ны өдөр батлуулж, тайлангийн хугацаанд хэрэгжилтийг ханган ажиллаа. Төлөвлөгөөний хэрэгжилт 96%-тай байна.

Гэрчилгээжүүлэлт:

*ИНД-139.5-аар гэрчилгээжсэн нисэх буудлууд*

Нисэх буудлын нэр	Гэрчилгээний дугаар	Гэрчилгээ сунгасан огноо	Хүчинтэй огноо
“Гурвансайхан” НБ	139-6	2020.10.13	2023.04.01
“Ховд” НБ	139-12	2020.09.30	2022.09.30
“Доной” НБ	139-11	2020.08.28	2023.08.31
“Чойбалсан” НБ	139-4	2020.04.30	2022.07.15
“Мөрөн” НБ	139-5	2021.05.31	2023.11.30
“Алтай” НБ	139-152		2023.04.01
“Өлгий” НБ	139-9	2020.07.30	2022.04.30
“Дэглий цагаан” НБ	139-7	2021.06.25	2022.07.01

ИНД-139.5-ын дагуу гэрчилгээжүүлэх нисэх буудал

№	Нисэх буудал	Хугацаа	Тайлбар
1	“Буянт-Ухаа”	НААХЗА-ны гэрчилгээжүүлэх үзлэг шалгалт 2021.11.08-2021.12.02-ны өдрүүдэд зохион байгуулагдсан.	Аэродромын ерөнхий зааврыг ИНД-139.501-н хүрээнд боловсруулж батлуулна.

ИНД-139.5А хязгаарлагдмал аэродромоор гэрчилгээжүүлэх нисэх буудлууд

№	Нисэх буудлын нэр	Гэрчилгээжүүлэлтийн байдал	Тайлбар
1	Арвайхээр	Шинээр гэрчилгээжинэ.	Аэродромын ерөнхий зааврыг НААХЗА-д хүргүүлсэн.
2	Баруун-Урт	Шинээр гэрчилгээжинэ.	Аэродромын ерөнхий зааврыг боловсруулж байгаа.
3	Булган	Шинээр гэрчилгээжинэ.	Аэродромын ерөнхий зааврыг НААХЗА-д хүргүүлсэн.
4	Өндөрхаан	Шинээр гэрчилгээжинэ.	Аэродромын ерөнхий зааврыг НААХЗА-д хүргүүлсэн.
5	Тосонцэнгэл	Шинээр гэрчилгээжинэ.	Аэродромын ерөнхий зааврыг боловсруулж байгаа.
6	Мандалговь	Шинээр гэрчилгээжинэ.	Аэродромын ерөнхий зааврыг боловсруулж байгаа.
7	Булган сум	Шинээр гэрчилгээжинэ.	Аэродромын ерөнхий зааврыг боловсруулж байгаа.

Иргэний нисэхийн дүрэм -140

№	Гэрчилгээ эзэмшдэг байгууллагуудын нэр	Гэрчилгээний дугаар	Гэрчилгээний хугацаа
1	Иргэний нисэхийн үндэсний төв	140-20	2021.07.10
2	Гурвансайхан НБ	140-03	2022.09.01
3	Доной НБ	140-04	2023.09.01
4	Ховд НБ	140-05	2023.11.01
5	Чойбалсан НБ	140-06	2022.06.01
6	Мөрөн НБ	140-08	2023.09.28
7	Алтай НБ	140-12	2022.09.01
9	Өлгий НБ	140-15	2023.11.30
10	Дэглий цагаан НБ	140-17	2022.06.15

Иргэний нисэхийн дүрэм -144

№	Гэрчилгээжсэн байгууллага /нисэх буудал/-ын нэр	Гэрчилгээний дугаар	Хүчинтэй огноо
1	Иргэний нисэхийн үндэсний төв	МСАА.144.008/20	2022.06.01
2	“Алтай”	МСАА.144.008/20 гэрчилгээний хавсралтаар	2022.06.01
3	“Өлгий”	МСАА.144.008/20 гэрчилгээний хавсралтаар	2022.06.01
4	“Гурвансайхан”	МСАА.144.008/20 гэрчилгээний	2022.06.01



		хавсралтаар	
5	“Отгонтэнгэр”	МСАА.144.008/20 хавсралтаар	гэрчилгээний 2022.06.01
6	“Дэглий цагаан”	МСАА.144.008/20 хавсралтаар	гэрчилгээний 2022.06.01
7	“Мөрөн”	МСАА.144.008/20 хавсралтаар	гэрчилгээний 2022.06.01
8	“Ховд”	МСАА.144.008/20 хавсралтаар	гэрчилгээний 2022.06.01
9	“Чойбалсан”	МСАА.144.008/20 хавсралтаар	гэрчилгээний 2022.06.01

2022 онд ИНҮТ-ийн МСАА.144.008/20 хавсралтад нэмж оруулах нисэх буудлууд

10	“Баянхонгор”	Гэрчилгээ аваагүй байгаа	Батлагдсан
11	“Булган”	Гэрчилгээ аваагүй байгаа	Батлагдсан
12	“Тосонцэнгэл”	Гэрчилгээ аваагүй байгаа	Батлагдсан
13	“Өндөрхаан”	Гэрчилгээ аваагүй байгаа	Батлагдсан
14	“Баруун-урт”	Гэрчилгээ аваагүй байгаа	Батлагдсан
15	“Мандалговь”	Гэрчилгээ аваагүй байгаа	Батлагдсан
16	“Арвайхээр”	Гэрчилгээ аваагүй байгаа	Батлагдсан

Газрын тусгай үйлчилгээ, шатахуун хангалтын албаны МСАА.144.009/20 дугаартай гэрчилгээний хугацаа 2021 оны 12 дугаар сарын 13-ны өдөр дуусаж байгаа бөгөөд Шинэ нисэх буудлын шатахуун хангамжийн албаныг ИНД-144-өөр гэрчилгээжүүлэхээр холбогдох арга хэмжээг авах ажиллаж байна.

Аэродромын үйл ажиллагааны чиглэлээр:

Зам, тээврийн хөгжлийн Сайдын 2021 оны А/56 дугаар тушаалаар “Аэродромын төлөвлөлт, ашиглалт” техникийн баримт бичгийн 7.5 дахь заалтад өөрчлөлт орсны дагуу аэродром орчмын аюулгүйн бүсийг шинэчлэн тогтоох ажлыг зохион байгуулж, 2021 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн байдлаар 15 нисэх буудлын аэродром орчмын аюулгүйн бүсийг шинэчлэн тогтоосон.

Мөн Монгол Улсад ашиглагдаж байгаа хөөрч буух зурвасууд, хатуу хучилттай зурвасын даацыг техникийн аргаар тодорхойлоход шаардлагатай инженер геологийн судалгааг хийлгэх зорилгоор тендер шалгаруулалт зарлаж, уг тендерт шалгарсан “Таван үндэс” ХХК-тай гэрээ байгуулан, даацын тооцоолол хийх болон геотехникийн судалгааны тайлан гаргах ажлыг гүйцэтгүүлсэн. “Таван үндэс” ХХК-ийн ажлын тайланг үндэслэн орон нутгийн 6 нисэх буудал /Алтай, Мөрөн, Дэглий цагаан, Баянхонгор, Ховд, Гурвансайхан/-ын даацын тооцоог гарган, Нислэгийн аюулгүй ажиллагааны хяналт, зохицуулалтын албаар баталгаажуулан, нисэхийн мэдээллийн эмхтгэлээр зарлуулж, 2021 оны 12 дугаар сарын 02-ны өдрөөс тус мэдээллүүд нь хүчин төгөлдөр болсон.

Аюулгүйн хамгаалалтын үйл ажиллагааны чиглэлээр: Аюулгүй байдлын үйлчилгээ үзүүлэх 89/21, ИНҮТ-52/2021/ дугаартай гэрээг 2021 оны 7 дугаар сарын 02-ны өдөр “НУБИЭ” ХХК-тай байгуулсан.

Мөн Аюулгүйн хамгаалалтын үйл ажиллагаанд ашиглагдах дараах дүрэм, журам заавруудыг “НУБИЭ” ХХК, Нисэхийн аюулгүйн хамгаалалтын үйлчилгээний байгууллага, “Чингис хаан” Олон улсын нисэх буудлын агаарын замын боомт дахь Хилийн шалган нэвтрүүлэх боомт, Иргэний агаарын тээвэр дэх Цагдаагийн хэлтэс зэрэг байгууллагуудтай хамтран баталж, үйл ажиллагаанд мөрдүүлэн ажиллаж байна.

Мөн Орон нутгийн 9 нисэх буудлын “Аюулгүй байдлын хөтөлбөр”, “Аюулгүйн хамгаалалтын үйл ажиллагааны заавар”-ыг НААХЗА-аар хүлээн зөвшөөрүүлсэн.

Орон нутгийн нисэх буудлууд /9 нисэх буудал/-ын хориотой, хамгаалагдсан болон нийтийн эзэмшлийн бүсийг “Иргэний нисэхийн аюулгүй байдлын журам”-ын шаардлагад нийцүүлэн тогтоолгож, Иргэний нисэхийн ерөнхий газрын даргаар 2021 оны 01 дүгээр сарын 22-ны өдөр батлуулсан. Ингэснээр НААХЗА-ны нисэхийн аюулгүй байдлын хяналтын байцаагчийн 443/20 дугаартай дүгнэлтийн шаардлагыг бүрэн хангасан.

Шувуу, хүрээлэн буй орчны чиглэлээр: Хэнтий аймгийн Дадал сумын “Дэлүүнболдог” нисэх буудлын байгаль орчны төлөв байдал ба байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тодотголын техникийн даалгаврыг бэлтгэж, “Дээшлэх говь” ХХК-тай 2021 оны 6 дугаар сарын 21-ний өдөр ИНҮТ/УЗ/ЗҮ-118/21 дугаартай гэрээг байгуулан ажиллаж, байгаль орчны төлөв байдлын



үнэлгээний тайланг ИНЕГ-ын удирдлагад танилцуулан, Байгаль орчин, аялал жуулчлалын яаманд ИНЕГ-ын 2021 оны 10 дугаар сарын 19-ний өдрийн 01/1792 тоот албан бичгээр хүргүүлсэн.

Мөн “Ховд”, “Өлгий” нисэх буудлуудын аэродромын аюулгүйн бүсэд шувуудын эрсдэлийн мониторинг судалгаа хийх ажлын хүрээнд 2021 оны 7 дугаар сарын 10-ны өдөр тендер шалгаруулалт зохион байгуулж, “Монголика” ХХК-тай 2021 оны 9 дүгээр сарын 08-ны өдөр гэрээ байгуулан, мониторингийн судалгааны ажлыг эхлүүлсэн.

Газрын тусгай үйлчилгээ, шатахуун хангалтын чиглэлээр: “МИАТ” ТӨХК-тай 2021 оны 3 дугаар сарын 14-ний өдөр ИНҮТ-13/2021 МИАТ-21/38 дугаартай гэрээ байгуулан, УБХОУШНБ-ын засвар үйлчилгээний барилга “Ангар” болон барилга байгууламжийг дагалдах бичиг баримтын хамт “МИАТ” ТӨХК-д хүлээлгэн өгсөн.

Мөн “НУБИЭ” ХХК-тай 2021 оны 7 дугаар сарын 02-ны өдөр ИНҮТ-51/2021, 90/21 дугаартай “Хамтын ажиллагааны гэрээ”, 2021 оны 7 дугаар сарын 01-ний өдөр ИНҮТ-47/2021 дугаартай “Түрээсийн гэрээ”, 2021 оны 11 дүгээр сарын 15-ны өдөр 262/21, ИНҮТ-109/2021 дугаартай “Тусгай зориулалтын автомашин түрээслүүлэх” гэрээг тус тус байгуулсан.

“Буянт-Ухаа” Олон улсын нисэх буудлын талаар:

“Буянт-Ухаа” Олон улсын нисэх буудлын үйл ажиллагааг Төв аймгийн Хөшигийн хөндийд байрлах “Чингис хаан” Олон улсын нисэх буудал (шинэ нисэх буудал) руу шилжүүлсэнтэй холбогдуулан “Буянт-Ухаа” Олон улсын нисэх буудлыг ИНД-139-өөр гэрчилгээжүүлэх ажлын хүрээнд холбогдох үзлэг шалгалтыг 2021 оны 11 дүгээр сарын 11-ний өдрөөс 12 дугаар сарын 02-ны өдрүүдэд зохион байгуулсан.

Гаалийн ерөнхий газрын даргын 2021 оны 10 дугаар сарын 04-ний өдрийн А/189 дүгээр тушаалаар Ачаа, шуудан үйлчилгээний цогцолбор дахь 170м² талбай бүхий нээлттэй түр агуулах ажиллуулах зөвшөөрлийн хугацааг нэг жилээр сунгуулсан.

Аэродром, барилга байгууламж, ашиглалтын хэсэг нь 2021-2022 оны өвөлжилтийн бэлтгэлийг хангах ажлын хүрээнд ИНЕГ, ИНҮТ болон харьяа салбар нэгжүүдийн барилга байгууламжийн инженерийн шугам сүлжээ, тоног төхөөрөмжүүдэд засвар шинэчлэлийн ажлыг төлөвлөгөөний дагуу зохион байгуулж, объектуудын халаалтыг 9 дүгээр сарын 15-ны өдрөөс 10 дугаар сарын 05-ны хооронд графикайн дагуу бүрэн өгч, тохируулга зүгшрүүлэлтийг хугацаанд нь хийсэн.

Мөн “Чингис хаан” Олон улсын нисэх буудлын түр оффис /А кэмп/-ын 3 блок барилгын дотор халаалтын систем болон дулааны узельд засвар үйлчилгээ хийж барилгын халаалтыг бүрэн өгсөн.

Орон нутгийн нисэх буудлуудын үйл ажиллагаа:

Орон нутгийн 19 нисэх буудал 402 орон тоотой үйл ажиллагаагаа явуулж байна. Тайлант хугацаанд орон нутгийн нисэх буудлуудын үйл ажиллагаатай холбоотой дараах томоохон ажлуудыг хийж гүйцэтгэлээ. Үүнд:

“Булган” нисэх буудлын аэродромын их засвар хийж гүйцэтгэх гүйцэтгэчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог ИНҮТ-ийн даргын 2021 оны А/184 дүгээр тушаалаар байгуулж, аэродромын их засварын ажлын тендерт шалгарсан “БСМ” ХХК нь 2021 оны 8 дугаар сарын 07-ны өдрөөс 30-ны өдрүүдэд нисэх буудлын хөөрч буух шороон зурвасны их засвар, явгалах зам, агаарын хөлгийн зогсоолын хүчитгэлийн их засварын ажлыг хийж гүйцэтгэсэн. ХБЗ-ын засварын ажлыг 2021 оны 9 дүгээр сарын 08-ны өдөр хүлээн авч акт үйлдсэн.

Мөн “БСМ” ХХК-д тус төвийн зүгээс санал тавьж, “Мөрөн” нисэх буудлаас УБ-Мөрөн чиглэлийн хатуу хучилттай авто зам хүртэлх 1,8 км шороон замд шороо асгуулж, нягтруулалт хийлгэн сайжруулсан замтай болсон.

“Гурвансайхан” нисэх буудлын хөөрч буух хучилттай зурвасын урсгал засварын ажлыг нийт 8028 м² талбайд 2021 оны 10 дугаар сарын 12-ны өдрөөс 11 дүгээр сарын 08-ны өдрүүдэд хийж гүйцэтгэсэн.

“Өлгий” нисэх буудалд технологийн машинд суурилуулах шувуу үргээх дуу авианы төхөөрөмжийг 36,0 сая төгрөгөөр авч, тус нисэх буудлын үйл ажиллагаанд ашиглуулж байна.

“Ховд” нисэх буудлын автомашины гараашийн засварын ажлыг 133,0 сая төгрөгийн өртөгтэйгээр гүйцэтгүүлсэн.

Аюулгүй байдал, хамгаалалтын талаар:

Иргэний нисэхийн үндэсний төвийн аюулгүйн хамгаалалтын үйлчилгээ үзүүлэх ИНД-140-ийн ИНД140-20 дугаартай гэрчилгээний хүчинтэй хугацаа 2021 оны 7 дугаар сарын 10-ны өдөр дууссантай холбогдуулан гэрчилгээний хүчинтэй хугацааг сунгуулах ажлыг зохион байгуулж,



Аюулгүйн хамгаалалтын үйлчилгээний байгууллагын гэрчилгээний хүчинтэй хугацааг 2022 оны 7 дугаар сарын 10-ны өдрийг хүртэл сунгуулсан.

Мөн гэрээт харуул, хамгаалалтын үйлчилгээ эрхлэх гэрчилгээний хүчинтэй хугацааг сунгуулах ажлыг зохион байгуулж, ЦЕГ-ын Бүртгэл хяналтын төвөөр 2022 оны 6 дугаар сарын 29-ний өдрийг хүртэл сунгуулсан.

“Буянт-Ухаа” Олон улсын нисэх буудлын үйл ажиллагаа “Чингис хаан” Олон улсын нисэх буудалд шилжсэнтэй холбогдуулан Иргэний нисэхийн үндэсний төвийн “Аюулгүйн хамгаалалтын ерөнхий заавар”-т “Буянт-Ухаа” аэродромын үйл ажиллагааг нэмэлт өөрчлөлтөөр тусган, НААХЗА-аар 2021 оны 11 дүгээр сарын 15-ны өдөр хүлээн зөвшөөрүүлэв.

Иргэний нисэхийн үндэсний төвийн 2020 оны Хөрөнгө оруулалтын батлагдсан төлөвлөгөөний дагуу “Баянхонгор”, “Баян-Өлгий”, “Завхан”, “Хөвсгөл” нисэх буудлуудын аюулгүйн үзлэгийн рентген төхөөрөмжийн иж бүрдлийг шинээр авч, иж бүрдэл, ажиллагааг 2021 оны 3 дугаар сарын 03, 08, 12-ны өдрүүдэд техникийн шаардлагын дагуу шалган хүлээн авах ажлыг цахимаар зохион байгууллаа.

Нэвтрэх үнэмлэхний хяналтын системийн программын шинэчлэлтийг хийх тендерт “Ай Ти Зон” ХХК, хамгаалалтын харилцаа холбооны системийн тоног төхөөрөмжийн тендерт “Hitech” ХХК тус тус шалгарч, стандарт сорилын цүнх худалдан авах гэрээг хийсэн.

Аюулгүйн үзлэгийн рентген төхөөрөмжийн сэлбэгийн I багцад “Ач холдинг” ХХК шалгарч 2021 оны 10 дугаар сарын 06, Аюулгүйн үзлэгийн рентген төхөөрөмжийн сэлбэгийн II багцад “Бит ТНТ” ХХК шалгарч 2021 оны 11 дүгээр сарын 22, сургалт дадлагажуурын программын тендерт “Бодь электроникс” ХХК шалгарч 2021 оны 11 дүгээр сарын 10-ны өдөр тоног төхөөрөмжүүдийг тус тус хүлээн авсан.

IATA-аас “Буянт-Ухаа” Олон нисэх буудлын үйл ажиллагаа “Чингис хаан” Олон улсын нисэх буудалд шилжин, байршил өөрчлөгдсөнтэй холбогдуулан Европын холбооноос Монгол Улсын агаарын тээврээр олон улсад илгээгдэж байгаа ачаа шуудангийн аюулгүй байдал стандарт, шаардлагад хэрхэн нийцэж байгаа эсэхэд 2021 оны 8 дугаар сарын 23, 24-ний өдрүүдэд АССЗ давтан аудит шалгалт хийсэн бөгөөд тус аудитад амжилттай шалгагдсан.

Ерөнхий зориулалтын нисэхийг хөгжүүлэх чиглэлээр:

“Ерөнхий зориулалтын нисэхийг хөгжүүлэх хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө 82.8 хувьтай хэрэгжиж байсан бөгөөд тус хөтөлбөрийг Засгийн газрын 2021 оны 10 дугаар сарын 13-ны өдрийн 314 дүгээр тогтоолоор хүчингүй болгосон.

2021 оны төсөвт 3 байршилд хөөрч, буух зурвас байгуулахад шаардлагатай тэмдэг тэмдэглэгээ худалдан авах 52.3 сая төгрөгийг тусган батлуулсан бөгөөд Ховд аймгийн “Чандмань”, Өвөрхангай аймгийн “Хужирт” Увс аймгийн “Цагаан нуур” сумын хөөрч, буух зурвасын тэмдэг тэмдэглэгээний ажлыг бүрэн хийж дуусган, 2021 оны 9 дүгээр сарын 17-ны өдөр акт үйлдэн хүлээн авсан.

Зам, тээврийн хөгжлийн сайд, аймгуудын Засаг дарга нартай 2021 оны 3 дугаар сарын 12-ны өдөр байгуулсан гэрээ болон Газрын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.3 дахь заалтын дагуу бага оврын агаарын хөлгийн хөөрч, буух зурвасыг аймаг, орон нутгийн удирдлагуудтай хамтран тогтоон 61 газрыг тусгай хэрэгцээнд авсан.

2021 онд 87 байршилд хөөрч, буух зурвасын координат баталгаажуулахаас тайлангийн хугацаанд 61 байршилд хөөрч, буух зурвасын цэгийг сонгон хэмжилт хийж, координатыг баталгаажуулаад байна.

Газрын үйлчилгээ, шатахуун хангалтын чиглэлээр:

Агаарын хөлгийг шатах тослох материалаар хангах үйлчилгээний байгууллагын № МСАА.144.008/20 дугаартай гэрчилгээний хүчинтэй хугацаа 2021 оны 6 дугаар сарын 02-ны өдөр дууссан бөгөөд гэрчилгээний хүчинтэй хугацааг сунгуулах ажлыг зохион байгуулж, 2022 оны 6 дугаар сарын 02-ны өдрийг хүртэл сунгуулсан.

Газрын тусгай үйлчилгээ, шатахуун хангалтын албаны нийт тээврийн хэрэгслийг Улсын үзлэгт хамруулах ажлыг зохион байгуулж ШХТАХ-ийн 44 автомашин, ТГҮХ-ийн 37 тусгай тоноглолтой автомашин, технологийн 22 автомашин механизм, аврах гал унтраах албаны 4 тусгай тоноглолтой автомашин, шатахууны хэсгийн 6 тоноглолтой автомашин нийт 117 хөдлөх бүрэлдэхүүнийг улсын үзлэгт хамруулсан.

Нийтийн тээврийн үйлчилгээний статистик үзүүлэлт /сүүлийн 4 жил/

Үзүүлэлтүүд	Хэмжих нэгж	2018 он	2019 он	2020 он	2021 он
1 Ажилласан цаг	мян.цаг	246,2	249,9	253,1	220,6



2	Автомашинь нийт гүйлт	сая.км	2,917	3,017	2,980	2,849
3	Автомашинь тоо	тоо	71	71	66	78
4	Ажилласан машин/өдөр	тоо	17801	18161	19087	17107
5	Парк ашиглалт	хувь	63,4	60,7	75,4	64,7

“Буянт-Ухаа” Олон улсын нисэх буудлаас “Чингис хаан” олон улсын нисэх буудал руу шилжүүлсэнтэй холбогдуулан агаарын хөлгийн газрын үйлчилгээний 24 автомашин, механизм, тоног төхөөрөмж, 45 тэргэнцэрийг 7 дугаар сарын 01-ний өдрөөс 04-ний өдрийн хооронд амжилттай нүүлгэн шилжүүлсэн.

Иргэний нисэхийн ерөнхий газрын даргын 2021 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн А/10 дугаар тушаалаар томилогдсон ажил хүлээн авах комисс нь “Дэглий цагаан”, “Чойбалсан” нисэх буудлуудад нийлүүлэх GPU-414 маркийн 2 ширхэг агаарын хөлгийн цахилгаан тэжээлийн төхөөрөмжийг “Огторгуйн бүтээл” ХХК-аас хүлээн авч, шинэ нисэх буудлын газрын үйлчилгээнд ашиглаж байна.

Иргэний нисэхийн үндэсний төвийн даргын 2021 оны 3 дугаар сарын 10-ны өдрийн А/48 дугаар тушаалаар байгуулагдсан ажил хүлээн авах комисс нь “Дэглий цагаан”, “Гурвансайхан” нисэх буудлууд болон Газрын тусгай үйлчилгээ, шатахуун хангалтын албанд нийлүүлэх Ко-829А1 маркийн аэродром цэвэрлэгээ үйлчилгээний 3 ширхэг автомашиныг “Батсээр” ХХК-аас хүлээн авч Ховд, Увс, Өмнөговь аймгийн нисэх буудлуудад хүлээлгэн өгсөн.

2021 оны 01 дүгээр сарын 10-ны өдөр Дэглий цагаан нисэх буудалд ирсэн агаарын хөлгийн ачаа тээшний туузан дамжуулагч NBL механизмыг “Вертексмон” ХХК-аас хүлээн авч шинэ нисэх буудлын газрын үйлчилгээнд ашиглаж байна.

Оношилгоо, хэмжил зүйн чиглэлээр:

Стандарт хэмжил зүйн газрын даргын 2019 оны 7 дугаар сарын 22-ны өдрийн А/239 дүгээр тушаалаар 4 жилийн хугацаатай 6 дахь удаагаа итгэмжлэгдсэн бөгөөд “Геодезийн захиалагчийн хяналтын хэмжилт”, “Хуйларсан гүйдлийн сорилт”-ын төрлүүдээр механик хэмжилт, сорилт гүйцэтгэх техникийн чадавхтайгаа нотлон итгэмжлэлийн хүрээгээ өргөтгөсөн.

Тус лабораторын үйл ажиллагааг өргөжүүлэх, сайжруулах ажлын хүрээнд газрын тосны бүтээгдэхүүний найрлагын бүрэлдэхүүн тодорхойлох, дөл үүсэх хэм тодорхойлох, автомат титратор 3 шинэ тоног төхөөрөмжийн хөрөнгө оруулалт хийсэн.

Мөн цаг уурын автомат станцын шалгалт тохируулгын багаж, радио цахилгааны хэмжих хэрэгслийн шалгалт тохируулгын давтамж хэмжигч багажийг шинээр худалдан авч, үйл ажиллагаанд ашиглаж эхлээд байна.

Тайлант хугацаанд тус лаборатори нь дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн болно.

Сорилт шинжилгээ: Захиалагч байгууллагын хүсэлтийн дагуу газрын тосны бүтээгдэхүүний 269 дээжид чанар хяналтын иж бүрэн шинжилгээ хийж, үр дүнг боловсруулан хүргүүлсэн.

Шилэн хэмжүүрийн шалгалт тохируулга: Захиалагч байгууллагын хүсэлтийн дагуу лабораторийн 12 шилэн хэмжүүрт шалгалт тохируулга хийсэн.

Цаг уурын автомат станцын хэмжилт, шалгалт тохируулга: Төвийн болон орон нутгийн нисэх буудлуудын 31 цаг уурын автомат станц, 3 даралт хэмжигч, 5 чийг температур хэмжигчид хэмжилт, шалгалт тохируулга хийж гүйцэтгэсэн.

Радио цахилгааны хэмжих хэрэгслийн шалгалт тохируулга: Радио, цахилгааны 63 ширхэг хэмжих хэрэгсэлд хэмжилт, шалгалт тохируулгын ажлыг хийж гүйцэтгэсэн.

Газардуулгын эсэргүүцлийн хэмжилт: Захиалагч байгууллагын хүсэлтийн дагуу 514 газардуулгын эсэргүүцлийн хэмжилт хийж гүйцэтгэсэн.

Түлш нөөцлөх савны хазайлтын хэмжилт: Орон нутгийн 15 нисэх буудлын ТС-1 түлш нөөцлөх 39 савны хазайлтын хэмжилтийг хийж, онооллын таблиц, үр дүнг боловсруулан нисэх буудлуудад хүргүүлсэн.

Сүмбэнметр, туузанметрийн шалгалт тохируулга: 17 сүмбэнметр, 3 туузанметр, 1 шугамын шалгалт тохируулгын ажлыг хийж гүйцэтгэсэн.

Үл эвдэх сорилын үзлэг шалгалт: Газрын тосны бүтээгдэхүүн нөөцлөх 33 савны насжилт тодорхойлж, үл эвдэх сорилын үзлэг шалгалт хийсэн.

Шинэ нисэх буудлын шатахуун хангамжийн чиглэлээр:

Шинэ нисэх буудлын шатахуун хангамжийн албыг агаарын хөлгийг шатах тослох материалаар хангах үйлчилгээний байгууллагаар гэрчилгээжихээр холбогдох ажлыг зохион байгуулж, НААХЗА-нд гэрчилгээжих хүсэлт гаргасны дагуу Шинэ нисэх буудлын шатахуун, хангамжийн албыг ИНД-144-өөр гэрчилгээжүүлэх үзлэг шалгалт 2021 оны 12 дугаар сарын 04-ний өдрөөс эхлэн хийгдэж байна.



Шатахуун ханган нийлүүлэгч нарт үзүүлэх үйлчилгээний хүрээнд тайлангийн хугацаанд дараах ажлуудыг хийж гүйцэтгээд байна. Үүнд:

Шатахуун ханган нийлүүлэгч “Мэргэ ван” ХХК-тай 2021 оны 7 дугаар сарын 08-ны өдөр, “Монголиан авиашн фүел” ХХК-тай 2021 оны 7 дугаар сарын 01-ний өдөр “Агаарын хөлгийн шатахууныг хадгалах, ачих, дамжуулан цэнэглэх үйлчилгээ үзүүлэх гэрээ”-г тус тус байгуулсан бөгөөд гэрээ байгуулсан өдрөөс 11 дүгээр сарын 30-ны өдрийг хүртэлх хугацаанд “Мэргэ ван” ХХК-аас 5337 тн, “Монголиан авиашн фүел” ХХК-аас 3632 тн, “Хүннү айр” ХХК-аас 260 тн, ГТҮШХА-аас 48 тн нийт 9277 тн шатахууныг хүлээн авсан.

“МИАТ” ХХК-тай 2021 оны 7 дугаар сарын 01-ний өдөр, “Аэромонголиа” ХХК-тай 2021 оны 7 дугаар сарын 01-ний өдөр, “Хүннү-эйр” ХХК-тай 2021 оны 7 дугаар сарын 01-ний өдөр “Агаарын хөлгийн шатахуун хадгалах, ачих, цэнэглэх үйлчилгээ үзүүлэх гэрээ”-г тус тус байгуулан, шатахуун сумалгааны үйлчилгээ үзүүлж байна.

Мөн шатахуун ханган нийлүүлэгч нартай гэрээгээр хамтран ажиллаж байгаа “Туркиш эйрлайнс” ХХК, “Асиана эйрлайнс” ХХК, “Кореан эйр” ХХК, “Аэрофлот” ХХК агаарын тээвэрлэгч байгууллагуудын агаарын хөлгийг 2021 оны 7 дугаар сарын 04-ний өдрөөс эхлэн шатахуунаар сумлаж байна. 2021 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн байдлаар 1042 удаа нийт 8816 тн шатахуун сумласан байна. Үүнээс шатахууны гидрант системээр 537 удаа, сумлагчаар 507 удаа сумласан.

Сарууд	Сумлагааны мэдээлэл				Санхүүгийн мэдээлэл			
	Шатахууны хэмжээ /мян.тн/	Төрлөөр		Тоо хэмжээ /удаа/	Сумлагааны хөлс /сая.төг/	Хадгалалтын хөлс /сая.төг/	Нийт орлого /сая.төг/	Үйл ажиллагааны зардал /сая.төг/
		Диспенсер	Сумлагч					
7	1.5	73%	27%	193	54	2	56	145
8	1.7	72%	28%	213	61	4	65	107
9	2.0	74%	26%	218	72	4	76	130
10	1.6	79%	21%	197	59	2	61	154
11	2.0	69%	31%	221	72	3	75	178
	8.8			1044	317	15	333	713

ТАВ. ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ЧИГЛЭЛЭЭР:

Хүний нөөцийн удирдлагатай холбоотой нийтлэг үйлчилгээ, үйл ажиллагааг зохицуулах талаар:

Зам, тээврийн хөгжлийн сайдын 2020 оны А/171 дүгээр тушаалаар батлагдсан зохион байгуулалтын бүтцийн дагуу агентлаг 106, Иргэний нисэхийн үндэсний төв болон харьяа үйлдвэрлэлийн салбар, нэгжүүд 2090 орон тоотой үйл ажиллагаагаа явуулж байна.

ИНЕГ-ын даргын 2020 оны 10 дугаар сарын 05-ны өдрийн А/416 дугаар тушаалаар “Хөдөлмөрийн дотоод журам”-д нэмэлт, өөрчлөлт оруулж, 2020 оны 10 дугаар сарын 05-ны өдрөөс мөрдөн ажиллаж байна.

ИНЕГ-ын даргын 2021 оны А/43 дугаар тушаалаар агентлагийн ажилтнуудын гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулж батлах, ажлын гүйцэтгэлийг үнэлэх журмыг шинэчлэн боловсруулж батлуулан хэрэгжилтийг хангаж ажиллаж байна.

ИНЕГ-ын даргын 2021 оны 01 дүгээр сарын 27-ны өдрийн А/19 дүгээр тушаалаар Иргэний нисэхийн хүний нөөцийн дунд хугацааны /2021-2024 он/ стратеги төлөвлөгөөг батлуулсан. ИНЕГ-ын даргын 2021 оны 02 дугаар сарын 23-ны өдийн А/23 дугаар тушаалаар “Иргэний нисэхийн ерөнхий газрын ажилтны ёс зүйн дүрэм”, 2021 оны 05 дугаар сарын 21-ний өдрийн А/59 дүгээр тушаалаар “Иргэний нисэхийн ерөнхий газраас гадаадад албан томилолтоор ажиллуулах болон сургалтад хамруулах журам”, 2021 оны 08 дугаар сарын 31-ний өдрийн А/108 дугаар тушаалаар “Сул ажлын байранд ажилтан сонгон шалгаруулах журам”-ыг тус тус шинэчлэн батлуулсан.

Хурал, зөвлөгөөний талаар:

Тайлант хугацаанд ИНЕГ-ын даргын зөвлөл 2021 онд 11 удаа хуралдаж, 24 асуудал хэлэлцэж 38 үүрэг даалгавар өгсөн. Хурлаас гарсан шийдвэрийг албажуулан холбогдох албан тушаалтнуудад хүргүүлж, хэрэгжилтэд хяналт тавин ажилласан. Үүрэг даалгаврын хэрэгжилт 87 хувь.



ИНЕГ-ын даргын шуурхай зөвлөгөөнийг тухай бүр зохион байгуулж, хурлын тэмдэглэл хөтлөн, өгсөн үүрэг даалгаврыг холбогдох газруудад хүргүүлэн биелэлтэд хяналт тавин ажиллаж байна. 2020 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн байдлаар даргын шуурхай хуралдаан нийт 15 удаа зохион байгуулагдаж, 272 үүрэг даалгавар өгөгдсөн. Үүрэг даалгаврын хэрэгжилт 100 хувь.

Зам, тээврийн хөгжлийн Сайдын шуурхайгаас өгсөн үүрэг даалгаврыг холбогдох албан тушаалтнуудад цаг хугацаанд нь хүргэж, хэрэгжилтийн талаарх мэдээллийг долоо хоног бүрийн Пүрэв гарагт нэгтгэн гаргаж, Зам, тээврийн хөгжлийн яаманд тогтмол хүргүүлж байна. Нийт 23 үүрэг даалгавар өгсөн. Үүрэг даалгаврын хэрэгжилт 100 хувь.

Хүний нөөцийн бүртгэл, судалгааны талаар:

Хүний нөөцийн холбогдолтой ажилд авах, чөлөөлөх, шилжүүлэн ажиллуулах, чөлөө олгох, тэтгэмж тусламж олгох, сахилгын шийтгэл ногдуулах, нэмэгдэл урамшуулал олгох зэрэг тушаал шийдвэрийг тухай бүрт нь төлөвлөж, батлуулан, хүний нөөцийн туслах бүртгэлд тусган ажиллаж байна. 2021.12.01-ний өдрийн байдлаар агентлагийн хэмжээнд сул ажлын байранд 7 ажилтныг шинээр ажилд авсан. Үүнд: ХДЖ-ын 3.5.1.1 дахь заалтын дагуу 2 ажилтныг, 3.5.1.2 дахь заалтын дагуу 5 ажилтныг шинээр ажилд авсан. Салбартаа 2-оос дээш жил ажилласан 17 ажилтныг шилжүүлэн томилсон бөгөөд үүнээс 7 ажилтныг албан тушаал дэвшүүлэн томилсон. Тайлант хугацаанд нээлттэй сонгон шалгаруулалт зарлаагүй.

Албан хэрэг хөтлөлт, архивын ажлын талаар:

2021 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 2021 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн байдлаар гадны байгууллагуудаас нийт 3877 албан бичиг ирүүлснээс хариутай албан бичиг 393, хариугүй албан бичиг 3251 байна. Хариутай албан бичгийн шийдвэрлэлт 96,6 хувь. ИНЕГ-аас гадны байгууллагууд руу 2205 албан бичиг явуулсан.

2020.12.01-ний өдрийн байдлаар үйл ажиллагааны чиглэлээр А тушаал нийт 150, боловсон хүчний чиглэлээр Б тушаал 118 гарсан байна. Үйл ажиллагааны чиглэлээр гарсан нийт 150 тушаалын 255 заалтыг хяналтандаа авсан. А тушаалын хэрэгжилт 90,2 хувь, Б тушаалын хэрэгжилт 100 хувьтай байна.

2021 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн байдлаар 108 өргөдөл, гомдол ирүүлснээс 98 өргөдлийг хуулийн хугацаанд нь шийдвэрлэж хариу өгсөн. Бусад байгууллагад шилжүүлж хариу өгсөн 6, шийдвэрлэх хугацаа болоогүй хяналтанд байгаа 6 өргөдөл гомдол байна. Өргөдөл гомдлын шийдвэрлэлт 94.4%-тай байна. Хуулийн хугацаанд шийдвэрлээгүй хугацаа хэтэрсэн өргөдөл гомдол байхгүй байна. Иргэний нисэхийн ерөнхий газарт 2021 онд иргэдээс ирүүлсэн өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн I улирлын мэдээг 2021.03.24-ний өдрийн 01/485, II дугаар улирлын тайлан мэдээг 2021.06.22-ны өдрийн 02/996, III улирлын мэдээг 2021.09.24-ний өдрийн 01/1611 тоот албан бичгээр тус тус Зам, тээврийн хөгжлийн яаманд хүргүүлж, мэдээг тус газрын www.mcaa.gov.mn цахим хуудаст байршуулан олон нийтийг мэдээллээр хангаж байна.

2020 онд хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын дагуу ИНЕГ болон харьяа байгууллагуудаас баримт бичгийг хүлээн авч, бүртгэл үйлдсэн. “Байгууллагын архивын ажлын үндсэн заавар”, “Баримт бичиг хадгалах хугацааны үлгэрчилсэн жагсаалт”-ыг үйл ажиллагаандаа мөрдөж ажилласан.

Архивт хүлээн авсан баримтын бүртгэл, архивын лавлагаа олгосон тухай бүртгэл, байгууллага албан тушаалтанд түр олгосон баримтын бүртгэл, хадгаламжийн санд цэвэрлэгээ үйлчилгээ болон норматив дэглэмийг хангаж ажилласан тухай бүртгэлүүдийг тухай бүр хөтлөн явуулж байна. Архивт хадгалагдаж буй баримтаас нийт 84 хадгаламжийн нэгж /2402 хуудас/ лавлагаа гаргаж, ИНЕГ болон харьяа алба, хэлтсийн ажилтнуудад 427 хадгаламжийн нэгж баримтыг түр ашиглуулахаар олгосон байна.

Байгууллагын баримт бичиг нягтлан шалгах комиссын 2021 оны 04 дүгээр сарын 08-ны өдрийн 01 дүгээр хурлаар 2021 онд хөтлөх хэргийн нэрийн жагсаалтыг хэлэлцүүлж, ИНЕГ-ын даргаар батлуулсан.

Шагнал урамшуулал, нийгмийн асуудлыг шийдвэрлэсэн талаар:

Төрийн одон медальд тодорхойлсон 124 ажилтны, ЗТХЯ-ны шагналд тодорхойлсон 82 ажилтны, ИНЕГ-ын шагналд тодорхойлсон 237 ажилтны мэдээллийг нэгтгэн ИНЕГ-ын даргын зөвлөлөөр хэлэлцүүлж, холбогдох мэдээлэл, материалыг нэгтгэн бэлтгэж ЗТХЯ-нд хүргүүлсэн.

Монгол Улсад Нисэх хүчин үүсэж хөгжсөний 96 жилийн ойг тохиолдуулан Зам, тээврийн хөгжлийн сайдын 2021 оны 05 дугаар сарын 24-ний өдрийн А/77 дугаар тушаалаар 69 ажилтан,



ИНЕГ-ын даргын 2021 оны 05 дугаар сарын 24-ний өдрийн Б/48 дугаар тушаалаар 240 ажилтныг шагнаж урамшуулсан.

Ажилтнуудын нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийг 2021 онд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулж, ИНЕГ-ын даргаар батлуулсан. 2021 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн байдлаар ажилтнуудын нийгмийн баталгааг хангах, тэтгэмж, тусламж, олгох чиглэлээр дараах ажлуудыг хийж гүйцэтгэв. Үүнд:

Сэргээн засах амралт:

Сэргээн засах, амралт нь иргэд, байгууллага хамт олон, иргэний нисэхийн салбарын ажилтан, албан хаагч, өндөр настан, ахмадуудад амралт, чөлөөт цагаа тав тухтай орчинд зөв боловсон өнгөрүүлэх, алжаал ядаргаагаа тайлах, эрүүл агаарт амрах боломжийг олгон, амт чанартай хоол, найрсаг үйлчилгээ үзүүлэх зорилт тавин ажилласан.

Байгууллагын 2021 оны бизнес төлөвлөгөөг боловсруулан баталж, төлөвлөгөөний хүрээнд идэвхжүүлэлтийн дараах арга хэжээнүүдийг авч ажиллалаа. Үүнд:

1. Жаргалант амралт цахим хуудсаар дамжуулан байгууллагын үндсэн үйлчилгээнүүд, гэр буудлын танилцуулга, хоолны QR цэс, ковид-19 цар тахлын үед амрагч үйлчлүүлэгчдийн халдвар хамгааллын дэглэм сахиж үйлчлүүлэх журам зэргийг байршуулан байнгын идэвхтэй ажиллуулснаар LIKE-12653, 12843 дагагчтай болгов. Амралтын газрын гэр дүүргэлтийг ажлын өдрүүдийн нэмэгдүүлэх зорилгын хүрээнд TOP FAN уралдааныг улирал бүр тогтмол зохион байгуулж байна.
2. БОАЖЯам, Нийслэлийн аялал жуулчлалын газар, IHotel.mn-ээс зочлох үйлчилгээний байгууллагууд /тур оператор, жуулчны бааз, амралтын газар, зочид буудлууд... гэх мэт/-ыг дэмжих, үйл ажиллагааг нь сэргээх зорилгоор зохион байгуулсан “ХЯМД АМАР” аялал жуулчлалын цахим үзэсгэлэнд оролцлоо. Энэ нь амралтын үйл ажиллагааг сурталчлах, ачаалал багатай буюу ДАВАА-ПҮРЭВ гаригуудад гэр дүүргэлтийг нэмэгдүүлэх ач холбогдолтой байв.
3. Амрагчдын өглөөний цайны нэр төрлийг нэмэгдүүлэх зорилгоор тогооч нарын дунд уралдаан зарлаж өглөөний хоолны багц менюг шинэчиллэв.
4. Амрагч, үйлчлүүлэгчдийн хоолны захиалгыг QR bar kod ашиглан онлайнаар авах үйлчилгээг нэвтрүүлэв. Энэхүү үйлчилгээг нэвтрүүлснээр амрагч, үйлчлүүлэгч нар гар утаснаасаа шууд захиалга өгөх боломжтой болсон.
5. НХҮА-ны зоогийн газрын хоолны нэр төрлийг нэмэгдүүлэн, шинэчилсэн менюгээр үйлчлэх, буфет хэлбэрээр үйлчлэх, кофены булан тохижуулах зэрэг ажлыг хийж гүйцэтгэснээр тус зоогийн газрын борлуулалтын орлого 25%-30% нэмэгдээд байна.

Мөн ИНЕГ болон салбарын хэмжээнд зохион байгуулагдсан нийт 27,962,953 төгрөгийн өртөг бүхий 25 удаагийн сургалт семинар болон бусад арга хэмжээг бараа, материал, түүхий эдийн өртгөөр нь зохион байгуулж, салбарын байгууллагуудаа дэмжин ажиллалаа.

УОК, Нийслэлийн Засаг даргын шийдвэрийн дагуу амралтын үйл ажиллагаа түр хязгаарлагдсан хугацаанд манай хамт олон салбарын ажилтан, албан хаагчдынхаа дархлааг дэмжих зорилгоор гишүүнэ ургамлаар технологийн дагуу жимсний чанамал, варень хийж, тухайн бүтээгдэхүүндээ хүнсний мэргэжлийн лабораторийн шинжилгээний дүгнэлт гаргуулан, “Гишүүний чанамал”-ыг ИНЕГ болон ИНҮТ-ийн Гамшгаас хамгаалах штаб болон харьяа салбар, нэгжүүдэд үнэ төлбөргүй тараалаа. Энэхүү хөтөлбөр нь TV5 телевизийн мэдээний хөтөлбөрөөр цацагдаж, бусад байгууллагууд ажилтнуудынхаа эрүүл мэндэд анхаарч, ажлын бүтээмжийг дээшлүүлж болох жишиг болж байна.

Дээрхи үйл ажиллагаануудыг зохион байгуулан ажилласны үр дүнд тус амралтын газраар 2021 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн байдлаар нийт 7256 амрагч, үйлчлүүлэгч үйлчлүүлээд байна. Үүнээс 5494 нь хувь хүн, 1762 нь иргэний нисэхийн салбарын байгууллагуудын ажилтан, албан хаагчид болон тэдний гэр бүлийн гишүүд байна.

Хэдийгээр тус амралтын газар нь 2021 онд Монгол улсын Засгийн газар, Улсын онцгой комиссын амралт, сувилалын газруудын үйл ажиллагааг түр хугацаанд хязгаарлах тухай шийдвэрүүдийн дагуу нийт 124 хоногийн хугацаанд амралт, сувилалын үйл ажиллагаагаа явуулаагүй боловч 677,6 сая төгрөгийн орлоготой ажиллаж, 2021 онд төлөвлөсөн орлогоо 30 хувиар давуулан биелүүлсэн байна.

Мэдээллийн технологи, инноваци:

ИНЕГ-ын даргын 2021 оны 01 дүгээр сарын 08-ны өдрийн А/02 дугаар тушаалаар “Дижитал шилжилт хийх” ажлын хэсэг байгуулагдаж, нэгдсэн төлөвлөгөөг батлуулсан. Төлөвлөгөөнд 2021 онд



6 зорилтын хүрээнд 43 ажил гүйцэтгэхээр төлөвлөсөн. Төлөвлөгөөний хэрэгжилт 95%-тай хэрэгжиж байна.

Төрийн үйлчилгээг түргэн шуурхай авах боломжийг бүрдүүлэх зорилгоор төрийн үйлчилгээний нэгдсэн "eMongolia" порталд үнэмлэхжүүлэлт, гэрчилгээжүүлэлт болон нислэгийн хуваарийн мэдээллийг оруулах ажлын хүрээнд "Чингис хаан" Олон улсын нисэх буудал-ын вэб хуудасны нислэгийн хуваарийн мэдээллийг линк [/https://e-mongolia.mn/services/citizen/sector/5d88ef9b0384df17c56691a8./](https://e-mongolia.mn/services/citizen/sector/5d88ef9b0384df17c56691a8/) хэлбэрээр eMongolia-д оруулсан. Мөн мэргэжлийн үнэмлэх, гэрчилгээжүүлэлтийн мэдээллийг "eMongolia" порталд линк хэлбэрээр байршуулахаар бэлтгэн Харилцаа, холбоо, мэдээллийн технологийн газарт хүргүүлээд байна.

ИНЕГ-ын газрын дотоод үйл ажиллагааны "iMCAA" системийн үүрэг даалгавар, файлын сан, цахим лавлах, мэдээ, архив болон баримт бичиг боловсруулах модулиудыг үйл ажиллагаанд шинээр нэвтрүүлэх ажлын хүрээнд дараахь ажлуудыг хийж гүйцэтгэж байна. Үүнд:

- Дотоод үйл ажиллагааны "iMCAA" системийн 9 модулийг 2021 оны 11 дүгээр сарын 15-ны өдрөөс бүрэн нэвтрүүлж, ИНЕГ, ИНҮТ, орон нутгийн нисэх буудлуудын захиргаа, бичиг хэргийн үйл ажиллагаанд бүрэн нэвтрүүлж, сургалт зохион байгуулсан. Үүнд:
 1. Албан хэрэг хөтлөлтийн модуль
 2. Бичиг баримтын төсөл боловсруулах модуль
 3. Дотоод мэдээллийн модуль
 4. Үүрэг даалгаврын модуль
 5. Онлайн хүсэлтийн модуль
 6. Ухаалаг бичиг баримтуудын модуль
 7. Хэрэглэгчийн халамжлах тактикийн модуль
 8. Системийн үндсэн тохиргооны модуль
 9. Онлайн сургалтын модуль

Иргэний нисэхийн ерөнхий газрын 13, Иргэний нисэхийн үндэсний төвийн 31, нийт 44 удирдах албан тушаалтантай нууцлалын гэрээ байгуулан, тоон гарын үсгийн гэрчилгээг олгон, 2021 оны 11 дүгээр сарын 08-ны өдөр iMCAA системтэй холбосон. Тоон гарын үсгийг тус албан тушаалтнууд нь 2021 оны 11 дүгээр сарын 09-ний өдрөөс үйл ажиллагаандаа ашиглаж эхэлсэн.

Мөн 2021 онд iMCAA нэгдсэн системд нийт 234 засвар хийсэн бөгөөд iMCAA систем ашиглалтын сургалтыг тогтмол хийж, заавар, зөвлөмж өгч ажилласан ба 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс ИНЕГ болон ИНҮТ-ийн үйл ажиллагаанд бүрэн нэвтрүүлэхээр холбогдох тушаал шийдвэрийг гаргах бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна.

Агаарын тээврийн салбарын хэмжээнд нэгдсэн платформыг хөгжүүлэх ажлын хүрээнд дижитал өгөгдлийн нэгдсэн сангийн хөгжүүлэлтийг 2021 оны 7 сарын 19-ний өдөр бүрэн хийж дуусган, ИНЕГ болон ИНҮТ, түүний алба салбарууд тус бүр хавтас үүсгэсэн бөгөөд тус хавтсанд устгагдах эрсдэлтэй болон бусад бүх баримт бичгүүдийг хадгалсан. Тус файлууд нь ямар ч тохиолдолд устгагдахгүй хадгалагдана.

Мөн дижитал нэгдсэн өгөгдлийн санд Veritech ERP систем, ATS систем, iMCAA системүүдийг нэгтгэснээр динамик систем нэвтэрч, 2021 оны 11 дүгээр сарын 20-ны өдөр байгууллагын үйл ажиллагааны тайлан, хүний нөөцийн тайлан, баримт бичгийн тоон мэдээлэл зэрэг тайлангуудыг гаргаж эхэлсэн.

Нислэг захиалгын онлайн системийг 2021 оны 8 дугаар сараас эхлэн хөгжүүлж, тайлангийн хугацаанд 1, 2-р үеийн тестийг хийж дуусгаад байна. Энэхүү онлайн системийг 2021 оны 12 дугаар сарын 30-ны өдрөөс эхлэн гадаадын болон дотоодын агаарын тээвэрлэгчид бүрэн ашиглаж эхэлнэ.

Агаарын тээврийн салбарын хэмжээнд шинээр нэвтрүүлж байгаа нэгдсэн платформын хүрээнд 2021 онд ашиглалтад оруулахаар төлөвлөсөн 1-р шатны 7 дэд систем болох Зохицуулалтын үйлчилгээний дэд систем, Хяналт шалгалтын дэд систем, Гэрчилгээжсэн байгууллагаас ирүүлэх баримт бичгийн хяналт баталгаажуулалтын дэд систем, Хэрэглэгчийн үйлчилгээний хандалтын дэд систем, Номын сангийн дэд систем, Хүний нөөцийн удирдлагын дэд систем, архивын дэд системүүдийн хөгжүүлэлтийг бүрэн хийж дуусгасан бөгөөд 2021 оны 12 дугаар сарын 10-ны өдрөөс үйл ажиллагаанд туршилтаар нэвтрүүлж эхлээд байна.

Е-Үнэмлэх системийн хөгжүүлэлт, нэвтрүүлэлтийн чиглэлээр нисгэгч, нислэгийн удирдагч, агаарын хөлгийн инженерийн зэрэглэл олгох, үнэмлэх, гэрчилгээний хугацаа сунгах үйл ажиллагааны тестийг НААХЗА-ны холбогдох байцаагч нартай хамтран хийж, засваруудыг бүрэн хийж гүйцэтгэсэн. Мөн байцаагчийн дүгнэлтийн программыг НААХЗА-ны байцаагч нарт танилцуулан туршилт хийсэн бөгөөд туршилтын үр дүнд гарсан засваруудыг хийж гүйцэтгэсэн.

Veritech ERP системийн сайжруулалтын хүрээнд хүний нөөцийн системийн хувилбар-2 хөгжүүлэгдэж дууссан бөгөөд шинэ хувилбарын өгөгдлийг шилжүүлэн, шалгаж хүлээн авч таниулах сургалтыг 2021 оны 06 дугаар арын 17, 10 дугаар сарын 12-ны өдрүүдэд тус тус цахимаар зохион байгуулж, нийт 43 ажилтныг хамруулсан.



Сүлжээ, мэдээллийн аюулгүй байдлын чиглэлээр: “Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн нарийн бичгийн даргын 2021 оны 8 дугаар сарын 31-ний өдрийн МН/09 дугаар захирамжийн дагуу Тагнуулын ерөнхий газрын харьяа Мэдээллийн аюулгүй байдлын газраас 2021 оны 09 дүгээр сарын 22-ны өдөр Холбоо навигаци, ажиглалтын алба болон Мэдээллийн технологи, хөгжлийн албанд мэдээллийн аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээ хийж, мэдээллийн аюулгүй байдлын өнөөгийн нөхцөл байдал болон MNS ISO/IEC 27001 стандартад нийцэж буй эсэхэд хамтарсан шинжилгээ хийсэн.

Олон улсын Мэдээллийн аюулгүй байдлын хууль, кибер аюулгүй байдлын хуулийн төсөл, тагнуулын тухай хууль, стандартуудыг судалж “Мэдээллийн аюулгүй байдлын журмын төсөл”-ийг боловсруулж байна.

Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах, нийтийг хамарсан үйл ажиллагааны чиглэлээр:

ИНЕГ, ИНҮТ-ийн үйл ажиллагааг олон нийтэд мэдээлэх, сурталчлах зорилгоор цаг үеийн холбогдолтой болон онцлох мэдээ мэдээлэл, нийтлэлийг бэлтгэн, өдөр тутмын сонин, цахим хуудсууд болон телевизийн сувгуудаар мэдээлэх ажлын хүрээнд ИНЕГ болон ИНҮТ-ийн цахим хуудас www.mcaa.gov.mn www.ncac.mcaa.gov.mn, фэйсбүүк хуудсууд, болон бусад олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл, цахим хуудсаар дамжуулан нийт 925 цаг үеийн холбогдолтой мэдээ, мэдээллийг нийтэлж, Цаг үеийн асуудлаар 3 ТВ нэвтрүүлэг, 1 нийтлэл бэлтгэн 5 телевиз, өдөт тутмын 5 сонин, 13 сайт 1 радиогоор дамжуулан олон нийтэд хүргэсэн байна.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачлагаар хэрэгжүүлсэн “Тэрбум мод тарих” үндэсний хөдөлгөөнд нэгдэж, өнгөрөлтийн нислэгийн тоогоор мод тарих зорилт тавин төлөвлөгөө гарган ажиллаж байна. Эхний ээлжийн модыг Сэргээн засах амралтын газарт тарьсан.

Ажилтнуудын чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх боломжоор хангах ажлын хүрээнд “Оюунлаг нисэхийнхэн” номын хандивын аяныг зохион байгуулж, 1400 гаруй номыг цуглуулан бүртгэлжүүлж, Нисэхийн сургалтын төвийн номын сангийн сан хөмрөгийг баяжууллаа.

Авта замын хөдөлгөөн ихэссэнтэй холбогдуулан өдрийн 8 цагийн ажилтнуудын ажлын цагт өөрчлөлт оруулж, 2021 оны 09 дүгээр сарын 07-ны өдрөөс он дуусталх хугацаанд ажлын цагийг 08:00-16:30 цаг болгож зохицуулалт хийсэн.

Хэвлэх цех нь ИНЕГ болон ИНҮТ, харьяа салбар, нэгжүүдийн захиалгын дагуу албан хэрэглээний хэвлэмэл хуудас, баримт бичиг, эрх зүйн акт, бусад шаардлагатай хэвлэлийн материалуудыг хэвлэн нийлүүлэх болон захиалгат бүтээгдэхүүний хэвлэлийн процессийн гүйцэтгэлд хяналт тавих, хэвлэлийн шаардлагатай материал, хэрэгслийн зарцуулалтад бүртгэлээр хяналт тавих зэрэг ажлуудыг цаг тухай бүрд нь хэрэгжүүлэн ажиллаж байна. Тайлангийн хугацаанд нийт 39 нэр төрлийн 540,629 ширхэг даралтад хуудсыг бэлтгэн нийлүүлсэн байна.

Эрүүл мэнд, спорт сургалтын чиглэлээр:

“Монгол Улсын хүн амын орчин үеийн эрүүл амьдралын хэв маяг, зан үйлд сургах, аливаа саад, бэрхшээлийг даван туулах бие, сэтгэлийн тэсвэр хатуужилтай шинэ үеийг бий болгох зорилгоор “Хүн амын бие бялдрын хөгжил, чийрэгжилтийн түвшин тогтоох сорил”-ыг Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилгаар жил бүрийн дөрөвдүгээр сард явуулж, үнэлэлт, дүгнэлтийг үндэслэн шаардлагатай арга хэмжээг авч ажиллах зарлигийн дагуу ИНЕГ-ын нийт ажилтан албан хаагчдын эрүүл амьдралын хэв маяг, зан үйлд сургах зорилгоор 19 төрлийн спортын чиглэлээр үйл ажиллагаа явуулах хүчин чадалтай Эрүүл мэнд, спорт сургалтын төвийг шинээр ашиглалтад оруулаад байна.

Энэхүү эрүүл мэнд, спортын цогцолбор нь өдөрт 120-140 хүн хүлээн авч, бэлтгэл сургуулилт хийх хүчин чадалтай спорт заал, өдөрт 300-400 хүн хүлээн авах хүчин чадалтай Фитнес, спенинг танхим, өдөрт 400 - 420 хүн хүлээн авах хүчин чадалтай бассейн /саун, душ/ гэсэн 3 их танхимтай.

Эрүүл мэнд, спортын цогцолбор нь иргэний нисэхийн салбарын ажилтан албан хаагчдад эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэх, спортоор дамжуулан бие бялдрын зөв хөгжил олгох зорилгоор сагсан бөмбөг, волейбол, ширээний теннис, софт теннис, дартс, хөл бөмбөг, усанд сэлэлт, аюу фитнес, даам, шатар, хананд авиралт, бадминтон, спиннинг, фитнес, кросфит, йога, аэробик, шагайн харваа гэсэн 18 төрлийн үйлчилгээ үзүүлэхээр төлөвлөсөн боловч танхимийн тохижилт засварын ажлууд бүрэн хийгдэж дуусаагүй байгаа тул 2021 оны байдлаар йога, бүжиг, дартс, ширээний теннис, усанд сэлэлтийн чиглэлээр сургалт явуулж байна. Тайлангийн хугацаанд давхарсан тоогоор 150-160 хүн йога, 100–120 хүн бүжиг, 150-160 хүн дартс, 60-70 хүн ширээний теннис, 70-80 хүн усанд сэлэлтийн сургалтад тус тус хамрагдан, хичээллэж байна.

Сургалт, дадлагын чиглэлээр:



Нисэхийн сургалтын төв нь сургалт, дадлагын үйл ажиллагаанд ИКАО-ын стандарт, шаардлагыг бүрэн хангасан орчин үеийн сургалтын арга барил, техник, технологийг нэвтрүүлж, олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн нисэхийн аюулгүй байдал, нисэхийн аюулгүй ажиллагааг хангах чадварлаг, мэргэжлийн хүний нөөцийг сургаж, бэлтгэх зорилгын хүрээнд үйл ажиллагаа явуулдаг ИНД1-141-ээр гэрчилгээжсэн, ОУ-ын Trainer Plus хөтөлбөрийг хэрэгжүүлэгч байгууллага юм.

Тус төв нь Trainair plus хөтөлбөрийн ИКАО-аас баталгаажуулсан Aeronautical Information Management (AIM) Specialist стандартчиллагдсан сургалтын багц хөтөлбөрт 3 жилд 1 удаа хийгдэх үнэлгээг хийж, тайланг 2021 оны 3 дугаар сарын 01-ний өдөр, 9 бүлэг, 170 асуулгын үр дүнг 2021 оны 11 дүгээр сарын 21-ний өдөр тус тус ИКАО-д хүргүүлсэн.

Мөн Нисэхийн сургалтын төв нь Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2021 оны 6 дугаар сарын 18-ны өдрийн А/97, А/231 дугаартай хамтарсан тушаалаар батлагдсан “Мэргэжлийн сургалтын байгууллагыг бүртгэх, сургалтын үйл ажиллагаанд тавигдах шаардлагыг тогтоох журам”-ын дагуу сургалтын хөтөлбөр болон сургалтын үйл ажиллагаа зэрэгт үнэлгээ, хяналтыг хийлгэж, мэргэжлийн сургалтын үйл ажиллагаа эрхлэх 099/2021 дугаартай гэрчилгээг 2021 оны 9 дүгээр сарын 16-ны өдөр авсан.

Нисэхийн сургалтын байгууллагын МСАА.141.05 дугаартай гэрчилгээний хүчинтэй хугацааг сунгуулах үзлэг шалгалт 5 дугаар сарын 24-ний өдрөөс 7 дугаар сарын 01-ний өдрүүдэд тус сургалтын төвд хийгдсэн бөгөөд үзлэг шалгалтад амжилттай шалгуулж, 2021 оны 7 дугаар сарын 09-ний өдрийн 442/21 дугаартай байцаагчийн дүгнэлтээр МСАА.141.05 дугаартай гэрчилгээний хүчинтэй хугацааг 2023 оны 5 дугаар сарын 01-ний өдөр хүртэлх сунгуулсан.

Түнчлэн Нисэхийн сургалтын төвд 2022 оноос эхлэн ИКАО-ын англи хэлний ур чадварын шалгалтын төвийг байгуулах ажлын төлөвлөгөөг боловсруулан, бэлтгэл ажлыг хангаж байна.

Тус сургалтын төвийн хэмжээнд иргэний нисэхийн чиглээр мэргэшсэн үндсэн 6 гэрээт 68, нийт 74 багш ажилтнуудыг мэргэшүүлэх, давтан сургах, дадлагажуулах ажлыг зохион байгуулан ажиллаж байна. Үүнээс докторын зэрэгтэй 1 багш, магистрын зэрэгтэй 26 багш, бакалаврын зэрэгтэй 47 багш байна.

Эдгээр багшлагч ажилтнуудыг мэргэшүүлэх, мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх чиглэлээр 2021 онд дараах арга хэмжээг зохион байгуулан ажиллаа. Үүнд:

- “НСТ-ийн өнөөгийн байдал, цаашдын хөгжил” сэдэвт цахим хэлэлцүүлгийг 2021 оны 1 дүгээр сарын 22-ны өдөр “Zoom cloud meeting” програмаар зохион байгуулж, цаг үеийн тулгамдсан асуудлуудыг нээлттэй хэлэлцлээ.
- Олон улсын иргэний нисэхийн байгууллага (ИКАО)-ын Trainair plus хөтөлбөрийн хүрээнд 2021 оны 3 дугаар сарын 05-ны өдөр НСТ-ийн өнөөгийн байдал, цаашдын төлөвлөлт, үйл ажиллагааг хэрхэн идэвхжүүлэх зэрэг асуудлаар виртуал уулзалтыг зохион байгууллаа.
- ИКАО-ын Олон улсын сургалтын байгууллагаас 2021 оны 6 дугаар сарын 08-ны өдөр зохион байгуулсан нисэхийн салбарын сургалт шинэ хэм хэмжээнд шилжих нь” сэдэвт вэбнарт оролцов.
- Trainair plus хөтөлбөрийн хүрээнд 2021 оны 7 дугаар сарын 09-ний өдөр зохион байгуулсан “Иргэний нисэхийн удирдах байгууллагад зориулсан Ковид-19 аюулгүй ажиллагааны эрсдэлийн удирдлага” сэдэвт виртуал сургалтад ИНЕГ-ын Нисэхийн аюулгүй ажиллагааны хяналт, зохицуулалтын алба, Агаарын навигаци, нисэх буудлын бодлого зохицуулалтын газар болон тус төвийн салбар нэгжийн 10 ажилтан хамрагдаж гэрчилгээжсэн.
- Trainair plus хөтөлбөрийн хүрээнд ИНУТ-ийн даргын 2021 оны 11 дүгээр сарын 03-ны өдрийн А/416 дугаар тушаалаар ИКАО-ын багш бэлтгэх хоёр дахь шатны “Training instructors course part 2” сургалтыг 11 дүгээр сарын 15-ны өдрөөс 19-ний өдрүүдэд зохион байгуулж, 12 багшийг хамруулан, гэрчилгээжүүлсэн.
- Багшийн мэргэжил дээшлүүлэх институтэд 2021 оны 11 дүгээр сарын 23-ны өдрөөс 25-ны өдрүүдэд зохион байгуулагдсан “Багшийг чадваржуулах” сэдэвт сургалтад нийт 30 багшийг хамруулж гэрчилгээжүүлсэн.
- Монгол Улсын Боловсролын Их Сургуульд 2021 оны 10 дугаар сарын 18-ны өдрөөс 22-ны өдрүүдэд зохион байгуулагдсан “Заах арга зүйн анхан шатны сургалт”-д нийт 10 багшийг хамруулж, гэрчилгээжүүлсэн.
- Мэргэжлийн боловсрол, сургалтын үнэлгээ мэдээлэл арга зүйн төвд 2021 оны 11 дүгээр сарын 05-ны өдрөөс 09-ний өдрүүдэд зохион байгуулагдсан “Чадамжид суурилсан сургалтын хөтөлбөр боловсруулах арга зүйн сургалт”-д 3 ажилтныг хамруулж, гэрчилгээжүүлсэн.

Тус төв нь Нисэхийн сургалтын төвд 2021 онд зохион байгуулагдах дотоод сургалтын төлөвлөгөөг 2021 оны 1 дүгээр сарын 27-ны өдөр батлан, хэрэгжилтийг хангуулан ажиллаж байна. Тайлангийн хугацаанд төлөвлөгөөнд тусгагдсан төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус нийт 57 сургалтыг зохион байгуулж, давхардсан тоогоор 3078 ажилтныг хамруулан, гэрчилгээжүүлсэн.



Мөн “Гадны сургалтын байгууллагуудад 2021 онд зохион байгуулагдах дотоод сургалтын төлөвлөгөө”-г 2021 оны 5 дугаар сарын 05-ны өдөр батлан хэрэгжилтийг хангуулан ажиллаа. Төлөвлөгөөнд ИНЕГ-ын 7, ИНҮТ-ийн 9 салбар нэгжийн нийт 95 сургалтад 669 ажилтныг хамруулахаар төлөвлөж, МУБИС, Удирдлагын академи зэрэг гаднын сургалтын байгууллагуудтай гэрээ байгуулан ажиллаж, тайлангийн хугацаанд 34 сургалтад нийт 171 ажилтныг хамруулаа. Гаднын сургалтын байгууллагад зохион байгуулах дотоод сургалтын төлөвлөгөөний биелэлт **35%**-тай байна.

Сургалтын төлөвлөгөөний биелэлт нь ковид-19 цар тахлын нөхцөл байдлаас шалтгаалан буурсан бөгөөд төлөвлөгөөд тусгагдсан боловч цаг үеийн байдлаас шалтгаалан зохион байгуулагдаагүй сургалтуудыг дахин судалж, шаардлагатай сургалтуудад 2022 онд ажилтнуудыг нөхөн хамруулахаар сургалтын төлөвлөлтөд дахин оруулж байна.

Мөн Ковид-19 халдварын үед “ИКАО-ын хэлний ур чадварын ТЕАР шалгалт авах үйл ажиллагаанд мөрдөх түр журам”-ыг **шинээр** боловсруулан баталж, шалгалтын үйл ажиллагаанд мөрдүүлж байна. Тайлангийн хугацаанд ИКАО-ын хэлний ур чадварын “ТЕАР” шалгалтад нийт **170** нислэгийн удирдагч, нисгэгч нар хамрагдсан бөгөөд шалгалтын материалыг Их Британийн Нэгдсэн Вант Улсын “Англо-Континентал” боловсролын группд хүргүүлэн холбогдох арга хэмжээг хэрэгжүүлж байна.

Аюулгүй байдлын үзлэгийн шалгагч нарын рентген дүрс дүгнэх чадварыг дээшлүүлэх, хадгалах, сургах зорилгоор ашигладаг дүрс дүгнэх "Simfox" дадлагажуурын программын хүчин чадлыг 2021 оны 11 дүгээр сарын 10-ны өдөр 2 сурагч эрхээр нэмэгдүүлж нийт 6 дасгалын компьютерээр дадлага сургалт явуулж байна.

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн чиглэлээр:

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 26.2 дахь заалтын дагуу Иргэний нисэхийн ерөнхий газрын 2021 оны хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зардалд 3.4 тэрбум төгрөгийг тусган батлуулсан.

Иргэний нисэхийн үндэсний төв нь 2021 онд хөдөлмөр хамгааллын хувцас, хамгаалах хэрэгсэлд 712,8 сая төгрөг төсөвлөж баталсан. ИНЕГ-ын даргын тушаалаар батлагдсан нормын дагуу ажилтны ажлын байрны нөхцөл, онцлогт тохирсон ажлын тусгай хувцас, хамгаалах хэрэгсэлээр хангагдсан эсэх, хор саармагжуулах бодисоор хангаж байгаа байдалд тогтмол хяналт тавьж байна.

ИНҮТ-ийн даргын 2021 оны А/07, А/326 дугаар тушаалаар “Гамшгаас хамгаалах штабын бүрэлдэхүүн”-ийг, ИНҮТ-ийн даргын 2021 оны А/409 дугаар тушаалаар “ХАБЭА-н дэд зөвлөл”-үүдийг, ИНҮТ-ийн даргын 2021 оны А/44, А/364 дүгээр тушаалуудаар ХАБЭА-н орон тооны бус зөвлөлийг шинээр болон шинэчлэн байгуулж, ажиллах журмыг баталсан. байгуулсан. Мөн ИНҮТ-ийн даргын 2021 оны А/76 дугаар тушаалаар “Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогыг судлан бүртгэх орон тооны бус байнгын комисс”-ыг шинэчлэн байгуулсан.

ИНҮТ-ийн даргын 2021 оны А/25, А/365 дугаар тушаалуудаар “Коронавируст халдвар (Ковид-19)-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, нэг удаагийн хамгаалах хэрэгслийн норм”-ыг шинээр болон шинэчлэн баталсан.

Тус төв нь тайлангийн хугацаанд ХАБЭА-н чиглэлээр холбогдох хууль, тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах, ХАБЭА-н стандарт шаардлагыг хэрэгжүүлэх зорилгоор харьяа алба, салбар нэгжүүдийн хэмжээнд төлөвлөгөөт 19, төлөвлөгөөт бус 6 үзлэг, шалгалтыг зохион байгуулж, үзлэг шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлыг газар дээр арилгуулах эсвэл цаашид залруулан, арилгах талаар зөвлөмж хүргүүлэн ажиллаа. Тайлангийн хугацаанд 19 үзлэг шалгалтын үр дүн, мөрөөр нийт 129 зөвлөмжийг харьяа байгууллагуудад өгсөн бөгөөд зөвлөмжийн хэрэгжилт 96%-тай байна.

ИНЕГ-ын даргын 2019 оны А/688 дугаар тушаалаар батлагдсан “ХАБЭА-н чиглэлээр үзлэг, гурван шатны хяналтыг зохион байгуулах журам”-д заасны дагуу ИНҮТ-ийн ХАБЭА-н орон тооны бус зөвлөл нь ХАБЭА-н чиглэлээр үзлэг, гурван шатны хяналтыг харьяа 17 алба, нэгжид гүйцэтгэн нийт 81 зөвлөгөө, зөвлөмжийг өгсөн. Зөвлөмжийн хэрэгжилт 92%-тай байна. Хяналт шалгалтын мөрөөр ажлын байранд богино долгионы зуухаар хангах, энгийн хог хаягдлыг эрх бүхий мэргэжлийн байгууллагаар ачуулах, тээвэрлүүлэх, халдварын эсрэг хариу арга хэмжээний бэлэн байдлыг хангах зэрэг асуудлуудыг шийдвэрлэсэн.

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны 2019 оны А/370 дугаар тушаалын дагуу 2021 оны 5 дугаар сарын 21-ний өдөр “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудал хариуцсан ажилтны сургалтын хөтөлбөр”-ийг боловсруулан батлуулж, сургалтад 24 ажилтныг хамруулан гэрчилгээжүүлсэн.

“Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн 14 цагийн зайн сургалт”-ыг 3 удаа зохион байгуулж, Нислэгийн хөдөлгөөний үйлчилгээний алба, Нислэгийн урсгал төлөвлөлтийн алба, Санхүү, эдийн засаг төлөвлөлтийн газар, Үйлдвэрлэлийн нягтлан бодох бүртгэлийн алба, Холбоо, навигаци ажиглалтын алба, Газрын тусгай үйлчилгээ, шатахуун хангалтын алба, “Буянт-Ухаа”,



Эрүүл мэнд спортын цогцолбор, Аэродром, барилга байгууламжийн ашиглалтын алба, Аюулгүй байдал, хамгаалалтын албаны нийт 1163 ажилтныг хамруулсан.

Онцгой байдлын ерөнхий газар, “Чингис хаан” Олон улсын нисэх буудал, Холбоо, навигаци, ажиглалтын алба, Нислэгийн хөдөлгөөний үйлчилгээний албатай хамтран “Гамшиг осол, гал түймрээс урьдчилан сэргийлэх, авран хамгаалах, өндрөөс аврах, бэлэн байдлыг хангах ажиллагаа” сургалтыг 2021 оны 06 дугаар сарын 30-ны өдөр “Чингис хаан” Олон улсын нисэх буудлын нислэгийн хөдөлгөөний удирдлагын цамхагт зохион байгуулж нийт 26 ажилтныг хамруулсан.

Нийслэлийн онцгой байдлын газрын ХУД-ийн онцгой байдлын хэлтсийн 14, 30, 105-р ангиудтай хамтран 2021 оны 11 дүгээр сарын 04-ний өдөр Нислэгийн хөдөлгөөний үйлчилгээний албанд “Гал түймэр унтраах тактикийн дадлага сургуулилт” амжилттай зохион байгуулсан.

Иргэний нисэхийн ерөнхий газрын хэмжээнд 2020 онд 718 ажилтныг “Гранд Мед” ХХК эмнэлэгт эрүүл мэндийн үзлэг хамруулсан бөгөөд тухайн эмнэлэгээс ирүүлсэн ажилтнуудын эрүүл мэндийн дүгнэлтэд тулгуурлан ажилтнуудын эрүүл мэндийг нөхөн сэргээх, сувилуулах зардалд 2021 онд 113,2 сая төгрөгийг төсөвлөсөн. “Грандмед” эмнэлгээс ирүүлсэн эрүүл мэндийн дүгнэлтийг харгалзан шаардлагатай ажилтнуудыг нөхөн сэргээх эмчилгээнд 2021 оны 06 дугаар сарын 06-ны өдрөөс эхлэн үе шаттайгаар хамруулж байна. Тайлангийн хугацаанд 193 ажилтныг эрүүл мэндийн нөхөн сэргээх эмчилгээнд хамруулсан байна.

2021 онд Иргэний нисэхийн ажилтнуудыг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулах ажлын хүрээнд “Асралт мед” ХХК-тай “ИНЕГ-ын ажилтнуудыг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулах гэрээ” байгуулан, эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулах ажлыг зохион байгуулж, хэрэгжилтэд хяналт тавин ажиллаа. ИНЕГ болон ИНҮТ, түүний харьяа салбар нэгжийн нийт 790 ажилтан эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт бүрэн хамрагдаад байна. Мөн Иргэний нисэхийн ажилтнуудын эрүүл мэндийн даатгалд 667, ажиллагсдын хариуцлагын даатгалд, амь нас, гэнэтийн ослын даатгалд 200 ажилтныг хамруулсан.

Тайлангийн хугацаанд үйлдвэрлэлийн ослын 1 тохиолдол бүртгэгдсэн бөгөөд ослын актыг Нийслэлийн мэргэжлийн хяналтын газарт хүргүүлж, баталгаажуулсан. Мөн сүүлийн 5 жилд гарсан 36 үйлдвэрлэлийн ослын судалгааг гаргаж, дийлэнх осол нь ажилтан ажилдаа ирэх, гэртээ харих замдаа явганаас хальтирч унан бэртсэн тохиолдол байгаа тул энэ талаар ажилтнуудад цахим орчинд сэрэмжлүүлэг хүргэсэн.

ИНЕГ, ИНҮТ болон түүний харьяа салбар нэгжүүдийн ариутгал халдваргүйжүүлэлт, аюултай хог хаягдал, энгийн хог хаягдлыг гэрээний дагуу мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлж байна.

Хөдөлмөрийн сайдын 2015 оны А/295 дугаар “Ажлын байрны эрсдэлийн үнэлгээ аргачилсан зөвлөмж” тушаалын дагуу Иргэний нисэхийн үндэсний төвийн харьяа салбар, нэгжүүдийн ажлын байранд эрсдэлийн судалгаа хийх ажлыг зохион байгууллаа. Судалгааны үр дүнд Төвийн салбар нэгжүүдээс 68 ажлын байр эрсдэлийн түвшин өндөр, Орон нутгийн нисэх буудлуудаас 77 ажлын байр эрсдэлийн түвшин өндөр гарсан. Иргэний нисэхийн үндэсний төвийн хэмжээнд хэвийн бусын нөхцөлийн хөнгөлөлтөд хамрагддаг 55 ажлын байрны 275 ажилтан байна.

“ХАБЭА-н сарын аян 2021” арга хэмжээг “Хямралыг урьдчилан харж бэлтгэлтэйгээр даван туулья-ХАБЭА-н тогтолцоог бэхжүүлэе” уриан дор зохион байгуулсан.

ЗУРГАА. ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ ХАНГУУЛАХ, ХУУЛЬ ЗҮЙН ЗӨВЛӨГӨӨ ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛЭХ ЧИГЛЭЛЭЭР:

ИНҮТ-ийн зохион байгуулалтын бүтцэд өөрчлөлт орсонтой холбогдуулан ХАСХОМ гаргах албан тушаалтны жагсаалтыг шинэчлэн, ИНЕГ-ын даргын 2021 оны 5 дугаар сарын 27-ны өдрийн А/63 дугаар тушаалаар батлуулсан.

Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн 2020 оны биелэлтийг гаргаж, 2021 оны 1 дүгээр сарын 15-ны өдрийн 01/ 66 тоот албан бичгээр АТГ-т хүргүүлсэн бөгөөд хэрэгжилтийн тайланг АТГ-ын цахим системд мөн оны 6 дугаар сарын 07-нд холбогдох нотлох баримтын хамт оруулсан.

Иргэний нисэхийн ерөнхий газрын 2021 оны авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөг ИНЕГ-ын даргаар 2021 оны 02 дугаар сарын 23-нд батлуулан, нэгжүүдэд хүргүүлсэн. Мөн байгууллагын цахим системд болон мэдээллийн самбарт байршуулсан. Төлөвлөгөөний хэрэгжилт энэ оны 12 дугаар сарын 01-ний өдрийн байдлаар 89%-тай байна.

Хууль тогтоомжийг сурталчлах, авлигаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг танилцуулах зорилгоор энэ онд 3 сургалтыг АТГ-тай хамтран зохион байгуулах хүсэлтээ өгч, энэ оны 6 дугаар сарын 16-нд зохион байгуулж, 138 ажилтанг хамруулсан. Мөн 11-12 сард АТГ-аас зохион байгуулах сургалтад хамруулах ажилтнуудын жагсаалтыг хүргүүлж, 65 ажилтанг хамруулаад байна.

Авлигын эсрэг үйл ажиллагааг мэдээлэн сурталчлах “Шударга ёс, хөгжил дэвшилд 110” мэдээллийн самбарыг ажиллуулж, мэдээллийг сар бүр шинэчилж байна.



Иргэний нисэхийн ерөнхий газар, түүний харьяа байгууллагуудын Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлэг гаргах албан тушаалтнуудын жагсаалт гарган ИНЕГ-ын даргаар батлуулж, АТГ-т хүргүүлсэн. 2020 оны ХАСХОМ-ийг 150 ажилтнаас хуулийн хугацаанд гаргуулж авч, тайлан мэдээг АТГ-т хүргүүлсэн. ХАСХОМ-ийг хугацаандаа гаргаагүй хоцроосон албан тушаалтан байхгүй. Мэдүүлэг гаргагчдын цаасаар болон цахим хэлбэрээр өгсөн мэдүүлэг бүрэн гүйцэд бөглөгдсөн, хугацаандаа өгөхөд хяналт тавьж ажиллав. 2021 оны 12 дугаар сарын 01-ний байдлаар ХАСХОМ гаргах албан тушаалд шинээр томилогдох 71 ажилтны ХАСУМ-ыг АТГ-т хүргүүлж, хянуулж, албан тушаалд томилогдсон 51 ажилтнаас ХАСХОМ-ийг гаргуулж авсан.

Хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг /ХАСУМ/-ийг хянасан дүгнэлтийг байгууллагын цахим хуудасны http://www.mcaa.gov.mn/?page_id=25474 байршуулж нийтэд ил тод болгосон. “Мэдүүлгийн бүрдүүлэлтийн программ” дахь “ЭБАТ” цэсний ХАС-ын урьдчилсан мэдүүлгийн бүртгэлд тухай бүр мэдээллийг оруулж байна. ХАСХОМ-ийг цахимаар гаргуулан авч, баталгаажуулан, Авлигатай тэмцэх газраас баталсан бүртгэлийн маягтын дагуу бүртгэж байна.

Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2.2 дахь заалт, 8 дугаар зүйл болон Монгол Улсын Их хурлын Хууль зүйн байнгын хорооны 2012 оны 5 дугаар тогтоолоор баталсан “Албан тушаалтны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлэг түүнийг бүртгэх, хянах, хадгалах журам”-ын 3.5.3-т заасны дагуу ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх мэдэгдлийг 454 албан тушаалтнаас авсан. Захиргааны шийдвэр гаргах, удирдах, хяналт шалгалт хийхэд ашиг сонирхлын зөрчил үүсч болзошгүй нөхцөлд АСМ-ийг гаргуулж байна.

Иргэдэд үзүүлэх үйлчилгээнд хүнд суртал гаргаж, иргэдийг чирэгдүүлсэн тохиолдлыг илрүүлж, буруутай албан тушаалтанд хариуцлага тооцох, иргэдээс авлига, ашиг сонирхлын зөрчилтэй холбоотой мэдээлэл авах зорилгоор буланг цахим хуудаснаа нээн ажиллуулж байна. Одоогоор авлигатай холбоотой ямар нэгэн мэдээлэл ирээгүй байна.

ДОЛОО. САНХҮҮ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЧИГЛЭЛЭЭР:

2021 оны улсын төсөвт төвлөрүүлэх 122.8 тэрбум төгрөг навигацыйн орлогоос 2021 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн байдлаар 86.0 тэрбум төгрөгийг төвлөрүүлсэн.

– Иргэний нисэхийн ерөнхий газар, харьяа алба, салбарын тухайн жилийн төсвийн хязгаар, төсвийн төсөл, дараа жилийн төсвийн хүрээний мэдэгдэл, төсвийн төсөөллийг орлого, зардлын 45 үзүүлэлт бүрээр нэгтгэн хянаж, Зам, тээврийн хөгжлийн яам, Сангийн яаманд хугацаанд нь хүргүүлсэн.

– ИНЕГ-ын 2022 оны төсвийг хүрээний мэдэгдэл, 2023-2024 оны төсвийн төсөөллийг 2021 оны 3 дугаар сарын 30-ны өдрийн 01/531 тоот албан бичгээр ЗТХЯ-нд хүргүүлсэн.

– ИНЕГ болон НТОЗШША-ны 2022 оны төсвийн төсөл, тайлбарыг 2021 оны 7 дугаар сарын 09-ний өдрийн 01/1126 тоот албан бичгээр, ИНҮТ-ийн 2022 оны орлого, зарлагын төсвийн төсөл, хөрөнгө оруулалтын жагсаалтыг тооцоо, судалгаанд үндэслэн боловсруулж 2021 оны 7 дугаар сарын 24-ний өдрийн 01/1197 тоот албан бичгээр, ковид-19 цар тахлын улмаас 2022 оны орлого буурах, улсын төсөвт төвлөрүүлэх орлого тооцооллоос өндөр батлагдсан тул зардлыг дахин хянах шаардлага гарч 2022 оны төсвийн саналыг дахин хянаж 2021 оны хүлээгдэж буй гүйцэтгэлтэй уялдуулан 2021 оны 12 дугаар сарын 06-ны өдрийн 01/2136 тоот албан бичгээр ЗТХЯ-нд хүргүүлсэн.

Санхүүгийн бүртгэл, тайлан гаргах

Иргэний нисэхийн ерөнхий газрын 2021 оны санхүүгийн тайлан балансыг хугацаанд нь гарган Зам, тээврийн хөгжлийн яам, Сангийн яам, Татварын ерөнхий газар, Үндэсний Аудитын газарт хүргүүлж баталгаажуулан байгууллагын шилэн дансны цахим хуудсанд байршуулан нийтэд ил тодоор тайлагнан ажилласан.

2021 онд Иргэний нисэхийн ерөнхий газар нь навигацыйн үйлчилгээний хураамжаас нийгмийн даатгалын шимтгэлд 858.5 сая төгрөг, хувь хүний орлогын албан татварт 304.2 сая төгрөг, ногдол ашигт 414.4 сая төгрөгийг хуулийн хугацаанд улсын болон орон нутгийн төсөвт төвлөрүүлж цахимаар болон цаасаар тайлагнаж баталгаажуулсан.

Өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалт:

– Ажилтнуудын эзэмшиж байгаа хөрөнгийн бүртгэлийн картыг нэр бүрчлэн хөтөлж баталгаажуулсан. 2021 оны хагас жилийн тооллогоор 104.1 тэрбум төгрөгийн газар, 1.2 тэрбум төгрөгийн үндсэн хөрөнгө, 90.1 сая төгрөгийн бараа материал тоологдсон.

Агаарын тээвэрлэгчдийн авлага барагдуулах талаар:



Иргэний нисэхийн ерөнхий газар болон харьяа салбар нэгжүүдийн авлагын дүн оны эхэнд 36.2 тэрбум төгрөг байсан бөгөөд 2021 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн байдлаар 29.8 тэрбум төгрөг бол 18 хувиар буурсан байна. Нийт авлагын 61 хувийг гадаадын авиакомпаниуд, 33 хувийг дотоодын авиакомпаниуд, 2 хувийг бараа материалын худалдан авалттай холбоотой авлага эзэлж байна.

Дэлхий дахинаа тархаад буй коронавируст халдварын цар тахал нь улс орны нийгэм эдийн засагт сөргөөр нөлөөлж, харилцагч байгууллагууд төлбөрөө төлөхөд хүндрэл учирч авлага барагдуулалт удааширсан. ИНЕГ нь авлага барагдуулах асуудалд онцгой анхаарч олон жил дамжсан найдваргүй болсон авлага, хугацаандаа авлага барагдуулахгүй байгаа харилцагч байнгууллагуудыг шүүхийн байгууллагаар шийдвэрлүүлж 31.6 тэрбум төгрөгийн авлагыг барагдуулсан.

Дотоодын агаарын тээвэрлэгчдээс авах авлагыг барагдуулах ажил удаашралтай байсан тул АэроМонголиа ХХК-иас авах 1.9 тэрбум төгрөгийн авлагыг хуулийн шүүхийн байгууллагад хандаж 759 сая төгрөгөөр Өмнөговь аймгийн Гурвансайхан нисэх буудлын зурвасын засварын ажлыг гүйцэтгэж өрнөөсөө суутгуулах, үлдсэн төлбөрийг график гарган 2024 оны 12 дугаар сард багтаан төлж дуусгахаар эвлэрлийн гэрээ байгуулж шийдвэрлэсэн. Хүннү Эйр ХХК-иас 2024 он дуусах хүртэл өрөө жил бүр график гарган барагдуулах санал ирүүлсэн. МИАТ ТӨХК-иас авах авлагыг Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 12 дугаар сарын 08-ны өдрийн 370 дугаар тогтоолоор 9.2 тэрбум төгрөгийн авлагыг чөлөөлсөн.

Шилэн дансны хуулийн хэрэгжилт:

Иргэний нисэхийн ерөнхий газрын 2021 оны сар, улирлын төсөв, гүйцэтгэл, бусад мэдээллийг хуульд заасан хугацаанд нь шилэн дансанд байршуулан ажиллаж байна. Шилэн дансны тухай хуулийг 2015 оноос хэрэгжүүлэн байгууллагын цахим хуудсыг шилэн данстай холбон нийт 21 нэгжийн шилэн дансны цахим системд нэвтрэх эрхийг олгон ажилласан. 5 сая төгрөгөөс дээш үнэ бүхий мөнгөн гүйлгээнд 2021 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн байдлаар 1108 баримтаар 419.5 тэрбум төгрөгийг тайлагнасан.

Хөрөнгө оруулалтын талаар:

2021 онд өөрийн орлогоос санхүүжих 22.1 тэрбум төгрөгийн 58 төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн. Үүнээс он дамжин хэрэгжиж байгаа 17 төсөл, арга хэмжээнээс бүрэн хэрэгжсэн 10, хэрэгжиж байгаа 5, хэрэгжээгүй 2 төсөл, арга хэмжээ байна. Шинээр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн 41 төсөл, арга хэмжээнээс бүрэн хэрэгжсэн 12, хэрэгжиж байгаа 16, тендерийн дахин зарлаж нээгээгүй байгаа 2, тендерийг үнэлж байгаа 1, хойшлуулахаар санал оруулж байгаа 8, тодотголоор батлагдсан боловч 2021 онд санхүүжих төсөв тавигдаагүй 1 төсөл арга хэмжээ байна. Бүрэн хэрэгжсэн болон хэрэгжиж байгаа төсөл, арга хэмжээг 5.7 тэрбум төгрөгөөр санхүүжүүлсэн байна.

Найм. Хяналт-шинжилгээ, дотоод аудитын чиглэлээр:

Хэрэгжилтийг тогтмол гаргаж, Зам, тээврийн хөгжлийн яаманд мэдээлж байх бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэр, дээд газрын тушаал шийдвэр, төлөвлөгөөний хэрэгжилтийн явцын талаарх мэдээллийг улирал бүр нэгжүүдээс гаргуулан авч, нэгтгэж, гүйцэтгэлд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, ИНЕГ-ын даргын зөвлөлийн хуралд танилцуулан, холбогдох шийдвэрийг гаргуулж, хэрэгжилтэд хяналт тавин ажиллалаа. Үүнд:

- Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө энэ оны жилийн эцсийн байдлаар 58%-тай. ИНЕГ-ын даргын 2021 оны А/85 дугаар тушаалаар баталсан эрчимжүүлэх төлөвлөгөөнд удаашралтай хэрэгжилттэй байгаа 10 арга хэмжээг тусгаж, хэрэгжилтийг сайжруулах арга хэмжээ авсны үр дүнд хэрэгжилт өнгөрсөн улиралтай харьцуулахад 2%-иар өссөн дүнтэй байна. /Нийт 15 арга хэмжээ, эхний хагас жил- 42,8%, 3 дугаар улирал- 56%/
- “Төрөөс иргэний нисэхийн салбарт 2020 он хүртэл баримтлах бодлого”-ыг хэрэгжилтийг Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 2 дугаар хавсралтын “Бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг тайлагнах маягт”-ын дагуу гаргаж, суурь түвшин, шалгуур үзүүлэлтийг арга хэмжээ бүрээр нөхөж гаргаж, хяналт-шинжилгээ хийж, 2021 оны 3 дугаар сарын 11-ний өдрийн 01/ 402 тоот



- албан бичгээр Зам, тээврийн хөгжлийн яаманд хүргүүлсэн. Мөн бодлогын баримт бичгийн үр нөлөөнд хөндлөнгийн үнэлгээ хийлгэж байна.
- ИНЕГ-ын 2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтэд 2,3 дугаар улиралд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, тогтоосон хугацаанд Зам, тээврийн хөгжлийн яаманд тайлагнасан. Мөн 10,11 дүгээр сард биелэлтийг дахин гаргаж, даргын зөвлөлд танилцуулж, хэрэгжилтийг эрчимжүүлэх арга хэмжээ авч ажилласан. Төлөвлөгөөний хэрэгжилт энэ оны жилийн эцсийн байдлаар 92.3%-тай, мөн оны эхний хагас жилийн /80.8%/ хэрэгжилттэй харьцуулахад 11.5%-иар өссөн дүнтэй байна.
 - Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газрын тогтоол, Засгийн газрын хуралдааны тэмдэглэл, Засгийн газрын албан даалгаврын 19 заалтыг хяналтад авсан. Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт жилийн эцсийн байдлаар 92.1 %-ийн хэрэгжилттэй, эхний хагас жилийн хэрэгжилттэй харьцуулахад хэрэгжилт 19.6-иар өссөн дүнтэй. /Эхний хагас жил-72.5%, 3 дугаар улирал-80.6%/
 - Зам, тээврийн хөгжлийн сайдын 70 тушаалын 127 заалтыг хяналтад авч, хэрэгжүүлсэн. Сайдын тушаалаар өгсөн үүрэг даалгавар энэ оны жилийн эцсийн 91.3%-ийн хэрэгжилттэй бөгөөд энэ оны 2 дугаар улирлын хэрэгжилтийн байдалтай /80.9%/ харьцуулахад 10.4 хувиар өссөн дүнтэй байна.
 - Иргэний нисэхийн ерөнхий газрын даргын үйл ажиллагааны чиглэлээрх тушаалын хэрэгжилтэд улирал бүр хяналт-шинжилгээ хийж, удирдлагад танилцуулж, тайланг нэгжүүдэд хүргүүлж, зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж байна.
 - Зам, тээврийн хөгжлийн сайдын сайдын зөвлөлөөс зөвлөлийн хуралдаанаас гарсан санхүүжилтгүй, шүүхийн маргаантай, он дамжиж, цаг хугацааны хувьд цэнэ алдсан зарим арга хэмжээг хяналтаас хасах чиглэл өгсний дагуу тус байгууллагын хариуцан хэрэгжүүлж байсан 2017-2019 оны 10 үүрэг даалгаврыг Зам, тээврийн хөгжлийн яам хяналтаас хассан байна. ИНЕГ-ын даргын 2021 оны А/85 дугаар тушаалаар батлагдсан эрчимжүүлэх төлөвлөгөөнд сайдын зөвлөлийн хуралдаанаас гарсан удаашралтай хэрэгжилттэй 9 тусгагдсан байснаас 3 нь хасагдаж, 6 үүрэг даалгавар үлдсэн. 2020 оны 4 хуралдааны 7 үүрэг даалгавар, 2021 оны 10 хуралдааны 14 үүрэг даалгавар, 26 үүрэг даалгаврыг хяналтад авч, хэрэгжилтийг хангах арга хэмжээг авч байна. Энэ оны жилийн эцсийн 91.2%-ийн хэрэгжилттэй байна.
 - ИНЕГ-ын нэгжүүдийн 2020 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт болон үйл ажиллагааг үнэлж, ИНЕГ-ын даргын зөвлөлийн 2021 оны 02 дугаар хурлаар хэлэлцүүлж, шийдвэр гаргуулсан.
 - ИНЕГ-ын зохион байгуулалтын 8 нэгжийн 2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг биелэлтийг эхний хагас жилийн байдлаар дүгнэсэн. Үүнд:

№	Нэгжүүд	Ажил дүгнэсэн арга хэмжээ	Дундаж хувь
1	НААХЗА	6	83.2%
2	ДАА	5	84.3%
3	АННББЗГ	7	69.2%
4	АТБЗГ	5	78.8%
5	ИНҮТ	8	78.4%
6	ЗУГ	5	79.8%
7	ХЭЗДБГ	6	85.8%
8	СХОГ	7	91.4%

- Агаарын тээврийн зайлшгүй үйлчилгээний хөтөлбөрийн дунд хугацааны хэрэгжилтэд үр дүнд суурилсан явцын үнэлгээ хийж, тайланг даргын зөвлөлийн Агаарын тээврийн зайлшгүй үйлчилгээний хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийж, ИНЕГ-ын дарга зөвлөлийн 2021.07.28-ны өдрийн 7 дугаар хурлаар зөвлөлийн гишүүдэд танилцуулж, шийдвэр гаргуулсан. Хөтөлбөрийн хэрэгжилт 43%-тай.
- Нисэхийн аюулгүй ажиллагааны хөтөлбөр, Иргэний нисэхийн ажилтнуудын хөгжлийн хөтөлбөрт болон Нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн хэрэгжийн явцад үр дүнд суурилсан явцын үнэлгээ хийж, тайланг нэгжүүдэд хүргүүлсэн.
- Байгууллагын үйл ажиллагааны ил тод байдлыг хэрхэн хангаж байгаа байдлыг үнэлэх зорилгоор Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Авлигын эсрэг хууль болон засгийн газрын тухай хуулийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийсэн, тайланг нэгжүүдэд хүргүүлж, зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажилласан.



- ИНЕГ-ын 2021 оны эхний хагас жилийн үйл ажиллагаанд ЗТХЯ хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг хангах зорилгоор Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, иргэний нисэхийн ерөнхий газрын 2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө, хууль тогтоомж, тогтоол шийдвэр, зам, тээврийн хөгжлийн сайдын тушаал болон албан даалгавар, зам, тээврийн хөгжлийн сайдын зөвлөлийн хуралдаан, иргэний нисэхийн ерөнхий газрын даргын тушаалаар өгсөн удаашралтай хэрэгжилттэй арга хэмжээ, үүрэг даалгаврын хэрэгжилтийг эрчимжүүлэх төлөвлөгөөг ИНЕГ-ын даргын 2021 оны 7 дугаар сарын 23-ны өдрийн А/85 дугаар тушаалаар батлуулан, сар бүр хэрэгжилтийг гаргаж, даргын зөвлөлд 3 удаа танилцуулсан. Төлөвлөгөөний хэрэгжилт энэ оны 11 дүгээр сарын 08-ны байдлаар 80.7%-тай.
- Зам, тээврийн хөгжлийн сайдын 2020 оноос хойш гарсан 2 албан даалгаврын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийж, удирдлагад танилцуулж, тайланг нэгжүүдэд хүргүүлж, зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж байна.
- Иргэний нисэхийн ерөнхий газрын хэрэгжүүлж буй бодлого, үйл ажиллагааны гүйцэтгэл, үр дүн болон тус байгууллагаас агаарын тээвэрлэгч, иргэний нисэхийн үйлчилгээ эрхлэгч байгууллагуудад, иргэний нисэхийн ажилтнуудад болон иргэд, зорчигчдод үзүүлж буй үйлчилгээ нь чанартай, хүртээмжтэй, хүнд сурталгүй шуурхай байгаа эсэхийн талаар судалж, түүнд дүнд шинжилгээ хийсний үндсэн дээр цаашид хэрэгжүүлэх бодлого, үйл ажиллагааг тодорхойлох зорилгоор хэрэглэгчийн үнэлгээ хийлгэхээр ажиллаж байна.

2021 оны дотоод аудит, хяналт шалгалт хийх хуваарийг 2021 оны 3 дугаар сарын 10-ны өдөр ИНЕГ-ын даргаар батлуулсан. Батлагдсан хуваарийн дагуу ИНЕГ, болон түүний харьяа алба салбаруудад нийт 44 удаагийн дотоод аудит, хяналт шалгалт хийхээр төлөвлөснөөс 2021 оны 12 сарын 10-ны өдийн байдлаар 44 дотоод аудитыг хийж гүйцэтгэсэн. Мөн 2021 онд удирдлагаас өгсөн үүрэг, өргөдөл гомдлын дагуу төлөвлөгөөт бус 6 дотоод аудит хийсэн.

Төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус Дотоод аудит, хяналт шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлыг засч залруулахаар 277 зөвлөмж өгч, тэдгээрийн хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна. Зөвлөмжийн хэрэгжилт өнөөдрийн байдлаар 83 хувьтай байна.

ДҮГНЭЛТ:

2021 онд ковид-19 цар тахлын нөлөө үргэлжилсэн хэвээр байсан боловч нислэг үйлдвэрлэлийн үйл ажиллагааг тасралтгүй, хэвийн явуулах, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн дэглэмийг сахих, иргэний нисэхийн үйл ажиллагаанд цахим шилжилт хийх болон шинэ нисэх буудалд шилжих бэлтгэл ажлыг хангахад онцлон анхаарч ажиллалаа.

Дэлхий даяар хурдтай тархаж буй Ковид-19 халдвараас урьдчилан сэргийлэх ажилд цаг алдалгүй, мэргэжлийн байгууллагуудтай хамтран ажиллаж зорчигч үйлчлүүлэгчдийн халдвар хамгааллын дэглэмийг чанд мөрдүүлэн, нислэгийн аюулгүй ажиллагаа, аюулгүй байдлыг хангаж ажилласан бөгөөд COVID-19 цар тахлын хүрээнд Иргэний нисэхийн ерөнхий газрын хэмжээнд 474.3 сая төгрөгийг зарцуулаад байна.

Зам, тээврийн хөгжлийн сайдын 2021 оны А/01 дүгээр тушаалаар “2021 оныг техник, технологийн шинэчлэлт-Цахим шилжилтийн жил” болгон зарласантай холбогдуулан ИНЕГ-ын даргын 2021 оны А/02 дугаар тушаалаар “Дижитал шилжилт хийх ажлын хэсэг”-ийг байгуулсан бөгөөд ИНЕГ, ИНҮТ, харьяа салбар нэгжийн хэмжээнд дижитал шилжилт хийх үйл ажиллагаанд тус төв нь гол чиг үүргийг хэрэгжүүлэн ажиллаж, ИНЕГ-ын хэмжээнд “Цахим НААХЗА”, “iMCAA” системийн хөгжүүлэлтүүдийг хийж, 2022 оноос эхлэн үйл ажиллагаанд 100 хувь нэвтрүүлэхэд бэлэн болоод байна. Мөн ИНЕГ, ИНҮТ-ийн хэмжээнд тоон гарын үсэг ашиглалтын үйл ажиллагааг эхлүүлснээр төрийн үйлчилгээг үйлчлүүлэгчдэд түргэн шуурхай, нээлттэй хүргэх, төрийн байгууллагуудын ажлын уялдаа холбоог сайжруулахад томоохон түлхэц болсон ажил байв.

Иргэний нисэхийн салбарын хэмжээнд 2021 он “Буянт-Ухаа” Олон улсын нисэх буудлын үйл ажиллагааг Төв аймгийн Хөшигийн хөндийд байрлах “Чингис хаан” Олон улсын нисэх буудалд шилжүүлсэн түүхийн шинэ хуудсыг нээсэн жил байлаа.

Энэхүү нүүлгэн шилжүүлэлтийн ажлын хүрээнд концессын гэрээний дагуу нийт 568 мэргэжлийн ажилтан, албан хаагчдыг болон нислэг үйлдвэрлэлийн үйл ажиллагааны тоног төхөөрөмж, машин механизмыг “Нью Улаанбаатар Интернэйшнл Эйрпорт” ХХК-д үе шаттайгаар шилжүүлэн өгч, нислэгийн аюулгүй ажиллагаа, аюулгүй байдал, агаарын навигацийн үйлчилгээний бэлэн байдлыг бүрэн хангаснаар 2021 оны 07 дугаар сарын 04-ний өдөр “Чингис хаан” Олон улсын нисэх буудлын үйл ажиллагааг амжилттай эхлүүлсэн.

“Нисэх буудал дахь агаарын хөлгийн шатахууны агуулах, гидрант системийн үйл ажиллагаа болон чанарын хяналтад тавигдах шаардлага” стандарт, “Аэродром орчимд агаарын хөлгийг шувуу,



мал, амьтантай мөргөлдөх аюулаас сэргийлэх” стандартыг Стандартыг боловсруулан, батлуулж, мөн “Агаарын хөлгийн мөстөлт арилгах, хамгаалах ажиллагааны заавар”-ыг Олон улсын SAE AS стандартын дагуу, “Нисэх буудлын үйлчилгээний заавар”-ыг Олон улсын нисэх буудлуудын үйлчилгээний зааврын дагуу тус тус боловсруулан баталж, Олон улсын болон орон нутгийн нисэх буудлуудын үйл ажиллагаанд нэвтрүүлэн хэрэгжүүлж байна.

ИРГЭНИЙ НИСЭХИЙН ЕРӨНХИЙН ГАЗАР